

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-57
<hr/>	
1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг нэр дэвшүүлэх тухай асуудал	10-22
2. ““Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголын тайланг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	22-52
3. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	52-57

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 18-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Х.Баттулга, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, У.Отгонбаяр, Да.Цогтбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Ганбат.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, О.Номинчимэг, П.Сайнзориг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, О.Номинчимэг нар хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа “Шүүгчид зэрэг дэв олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 3 дугаарт байгаа “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулах тухай горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, О.Номинчимэг нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 3

Бүгд: 15

80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10-т заасны дагуу санал хураалт болон хэлэлцүүлэгт оролцохгүй гэдгийг хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн тухай үг хэлж, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “эсрэг” гарсан саналыг түдгэлзсэнээр тооцов.

Горимын санал дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа “Шүүгчид зэрэг дэв олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 3 дугаарт байгаа “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулахаар тогтов.

Нэг.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг нэр дэвшүүлэх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны дэд дарга О.Бат-Эрдэнэ, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн С.Дондов, Монголын хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн

Ц.Мөнхбат, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Нэр дэвшигч М.Алтан-Очир, С.Энхбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, нэр дэвшигч М.Алтан-Очирын танилцуулгыг ажлын хэсгийн хэсгийн илтгэгч гишүүн Х.Эрдэм-Ундрах, нэр дэвшигч С.Энхбаатарын танилцуулгыг ажлын хэсгийн илтгэгч гишүүн О.Бат-Эрдэнэ нар танилцуулав.

Тайлан болон нэр дэвшигчдийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, М.Нарантуяа-Нара нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Самдангийн Энхбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Н.Алтанхуяг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Машлайн Алтан-Очирыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 10
Бүгд: 15
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. ““Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголын тайланг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

“Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголын тайлан болон Байнгын хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайдыг байлцуулж хэлэлцэх шаардлагатай тул уг асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 11
Бүгд: 15
26.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Тайлан болон тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Ц.Сандаг-Очир, С.Эрдэнэболд, О.Номинчимэг, Н.Алтанхуяг, М.Нарантуяа-Нара, Х.Тэмүүжин, Ж.Алдаржавхлан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Баасанжаргал, М.Нарантуяа-Нара, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: ““Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголын тайланг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга Т.Энхболд, мөн хэлтсийн албаны дарга Б.Баярсайхан, ахлах мэргэжилтэн Ц.Баасандэлгэр нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурын гишүүн Г.Уянгахишиг, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга Б.Баярсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар уг асуудлыг хойшлуулав. /13:30/

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 03 минут үргэлжилж, 22 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 68.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 10 цаг 27 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул 2024 оны 12 дугаар сарын 18-ны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирсэн гишүүд Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Батжаргалын Заяабал, Лхагвын Мөнхбаатар, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Одсүрэнгийн Номинчимэг, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирц 63,6 хувиар ирц бүрдсэн байна. Ингээд гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр хэлэлцэхээр төлөвлөсөн 5 асуудал байгаа.

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг нэр дэвшүүлэх тухай асуудал,

2.“Шүүгчид зэрэг дэв олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

3.“Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

4.Байнгын хорооны тогтоолын төсөл /Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх, хүний эрхийн хэрэгжилт, хяналтын сонсголын тайланг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай/

5.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай/ гэсэн ийм 5 асуудал байна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Номинчимэг гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгаж мэндчилье. Өнөөдрийн хэлэлцэх асуудалд байгаа “Шүүгчид зэрэг дэв олгох журам батлах тухай” “Зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, /Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай/ энэ 2 асуудлыг хойшлуулах горимын саналтай байна.

Үндэслэл нь юу вэ гэхээр 2024 оны 6 сард Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад энэ бол Засгийн газраас өргөн баригдаагүй, Их Хурлын гишүүдээс өргөн баригдсан төсөлд шүүгчид зэрэг дэв олгодог асуудлыг хуульчилсан. Үүнтэй холбоотой 1 зарчмын асуудал шийдэгдсэн нь Монгол Улсын түүхэнд анх удаа шүүгчдийн цалинг Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө тогтоох эрхийг энэ хуулиар олгосон. Урьд нь бол Улсын Их Хурлын тогтоолоор шүүгчдийн цалинг тогтоодог байсан. Тэгэхээр Шүүхийн тухай хуульд сая 6 сард орсон өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлаас баталсан төсөвт багтааж цалингийн санд багтааж Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө цалингаа тогтоодог болгосон. Миний авсан албан бус мэдээллээр бол сая намар шүүгчдийн туслах, нарийн бичиг мэдэхгүй байна. 30-50 хувь нэмсэн сурагтай байгаа. Орон тоогоо сая 2025 оны төсөв дээр 470 хэдээр 77 шиг санаж байна. 2025 онд шинээр нэмүүлье гэдэг санал оруулж ирсэн. Улсын Их Хурал 50 хувиар нэмэх саналыг дэмжсэн. Энэ нь юу ярьж байна вэ гэхээр 1 орон тооны цаана цалингийн сан их олон төсвийг нь бид нар батлаад байгаа юм.

Бид нар 2025 оноос эхлээд орон байрных нь асуудлыг шийдвэрлэх хөрөнгө оруулалтын асуудлыг нь бол ш тавьж өгч байгаа. Хялбар ажиллагааны шүүх шинээр байгуулна. Тэгэхдээ энэ бол дотооддоо зохион байгуулалт хийгээд шийдэх боломжтой байгаа. Тэгэнгүүт орон тоогоо ер нь их томоор тавиулж байгаад, цалингийн сангийнхаа хэмнэлтээр цалингаа нэмдэг ийм жишиг рүү манай хуулийн байгууллагууд явах нь. Төсвийн хуулиар төсвийн ерөнхийлөн захирагч хэмнэгдсэн орон тооноос үүссэн цалингийн санг бусад урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулах эрхтэй байдаг юм. Сая цагдаа дээр мянган орон тоо нэмэхээр орж ирсэн. Манай Байнгын хорооны гишүүдэд буруу мэдээлэл өгсөн. Гишүүд ерөөсөө энэ эргүүлийн цагдаа, замын цагдаа байхгүй болох гэж байгаа юм шиг ойлголт төрүүлж байгаад, орон тоогоо том тавиулаад, энэ хэмнэгдсэн гэж байгаа орон тооныхоо санхүүжилтээр өөр юм шийдээд байна. Тийм учраас үүнтэй холбоотой төсөв санхүүгийн дэлгэрэнгүй танилцуулга авч байж энэ асуудлыг ярихгүй бол болохгүй байна. Манай Байнгын хорооны гишүүдэд ерөөсөө энэ ажил нь болох бичиг цаас ч байхгүй, принтер, хор ч байхгүй гэдэг ойлголт өгөөд. Гэтэл 240 нэмэгдэж байгаа хүний орон тооны цалингийн сан гэдэг бол хэдэн тэрбум төгрөг байгаа шүү. Тэгээд тэр орон тоондоо авахгүй. Жишээлбэл манай цагдаа гэхэд 2024 онд 400 орон тоогоор нэмсэн. Улсын Их Хурал. Тэгэхэд мянган орон тооны хэмнэлттэй ажилласан 2024 онд. Мянган орон тооны хэмнэлттэй ажилласан газар бид мянган орон тоо шинээр нэмэх тухай ярьсан. Тэгээд Улсын Их Хуралд ямар мэдээлэл өгсөн гэхээр ерөөсөө тэнд хүмүүс байхгүй болох гэж байгаа юм шигээр худлаа ярьсан.

Тийм учраас Улсын Их Хурал бүрэн дүүрэн, үнэн зөв, төсөв тооцоотой ийм мэдээллээр ярихгүй бол цааш цаашдаа дараагийн Байнгын хороо дээр асуудал үүсэх нь гэж 7 хоногоор хойшлуулах санал.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофон өгье.

О.Номинчимэг: Бүгдэд нь энэ өглөөний мэндийг хүргэе. Хэлэлцэх асуудалтай холбоотой 2 санал байна.

Нэгдүгээрх нь сая ярьсан энэ “Шүүгчийн зэрэг дэв олгох журам батлах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай. Ер нь би яах вэ, энийг өчигдөр Байнгын хорооны групп дээр ингээд материал авлаа харлаа. Тэгээд ингээд харсан чинь

“Шүүгчид зэрэг дэв олгох тухай” гээд. Тэгээд яагаад ийм юм ороод ирэв. Яах вэ цалингийн асуудлыг нь сая Энхбаяр гишүүн хөндчих шиг боллоо. Гэхдээ ер нь шүүх засаглал, шүүгчид маань анхан шатын шүүх, давж заалдах шатын шүүх, дээд шүүх, мэдээж Ерөнхий шүүгч гээд бас байгаа. Ийм л албан тушаалаараа ялгардгаас биш зэрэг дэвтэй байна гэсэн ойлголт яагаад орж ирээд байгаа юм бэ гэдгийг гайхаад байгаа байхгүй юу. Одоо бид нар ийм нэг гоёл чимэглэл, нэмэлт, зэрэг дэв юу байдаг юм тийм юмаа болиод, ажлаа хийдэг, ажлынхаа чиг үүргийнхээ дагуу юмаа хийдэг болохгүй бол нэг л их зэрэг дэв яриад л төрийн захиргааны албан хаагч шиг, төрийн тусгайгийнхан шиг. Шүүгч нар нь хүртэл одоо ямар юм гэнэ вэ, түшээ, шүүхийн түшээ, эрхэлсэн түшээ, тэргүүн түшээ гэдэг ийм зэрэг дэвтэй болох гээд байгаа юм. Judicial branch маань өөрөө төрийн тусгай, төрийн захиргаа шиг зэрэг дэв авъя гэж байгаа юм байна. Тэгтэл энэ чинь энэ шүүхийн тухай хууль дээрээ сая 6 сард нэмэлт, өөрчлөлт ороод шүүгчид өөрсдөө зэрэг дэвтэй байна гэдэг заалтууд оруулчихсан юм байна шүү дээ. Тэгээд ер нь бол бид тийм зэрэг дэв, элдэв гоёл чимэглэл байхгүйгээр ажлаа хийдэг, ажлынх нь мэдээж ажиллах нөхцөлийг нь сайн бүрдүүлэхэд бол Улсын Их Хурал анхаарах ёстой. Тэр чиглэл рүүгээ явмаар байна. Одоо бүр байтлаа шүүгчид нь хүртэл түшээ гээд янз бүрийн зэрэг дэв авдаг. Тэгээд ингээд харахаар тэрнийх нь ач холбогдол ерөөсөө байхгүй байгаа байхгүй юу. Ерөөсөө л анхан, дунд, дээд шатны шүүхүүд нь тус тусдаа нэг ийм түшээ гэдэг нэртэй л болох юм байна. Яг ямар ач холбогдолтой нь ерөөсөө байхгүй. Зүгээр нэг гуншин л нэмж байгаа байхгүй юу. Ямар бөх байгаа биш дээ энэ чинь одоо.

Тэгэхээр энийгээ дахиж нэг хараад, Улсын Их Хурлын тогтоолын төсөл юм байна. Тэгээд тэр хөндөх ёстой бол тэр Шүүхийн тухай хуулиа хөндөөд, энийг дахиж хармаар байна гэсэн ийм саналтай байгаа юм.

Хоёрдугаарх нь болохоор хэлэлцэх асуудал гэхээсээ илүү ер нь Байнгын хороон дээр хэлэлцэх гэж байгаа өнөөдөр 4,5 асуудал байсан. Өчигдөр бол гишүүдэд 3 асуудлын талаар урьдчилсан мэдээлэл өгсөн. Тэгээд өнөөдөр энэ 3 асуудал байгаа юм болов уу гэсэн чинь дахиад тогтоолд өөрчлөлт оруулах тухай гээд яах вэ нэг загвар юм байна. Хөнгөн асуудал. Гэхдээ Байнгын хорооны цаг эхэлчихсэн, 10 цаг өнгөрч байхад Байнгын хорооноос энэ материалыг анх удаа бид нарт тарааж байгаа байхгүй юу. Бид нар чинь тийм omnipotent бүх юмыг 3, 4 хуудас юмыг тэр дор нь уншаад, саналаа хураагаад, ул суурьтай бодоод бас шийдвэр гаргах тийм робот шиг хүмүүс биш шүү дээ.

Тэгэхээр энэ материалуудыг Байнгын хороогоор хэлэлцэх гэж байгаа материалуудыг ядаж 1 өдрийн өмнө тарааж өгч баймаар байна. Улсын Их Хурлын Тамгын газар би маш их ачаалалтай ажилладаг, орон тоо бас дутуу байгаа гэдгийг ойлгож байгаа. Гэхдээ энэ асуудлуудаа ядаж төслийг нь гишүүддээ урьдчилаад өгчих юм бол бид нар ч гэсэн судлаад, хэлэлцэхдээ ч гэсэн илүү үр дүнтэй сайн хэлэлцэх юм байна. Тэгэхгүй бол уншиж амжихгүй байна шүү дээ. Зарим нь ерөнхийдөө. Тэгээд ийм бас нэг ийм санал байгаад байна.

Д.Цогтбаатар: Ингэе Сайнзориг гишүүн орж ирээд бас хэлэлцэх асуудал дээр үг хэлье гэж байна. Би үг өгье. Гэхдээ Сайнзориг гишүүн ээ, хуулийг дагаж мөрдөнө гэдэг чинь энгийн процедураа дагаж мөрдөхөөс л эхэлнэ шүү дээ. Тэгээд та өөрөө хоцорч орж ирчхээд би ингээд микрофоноор ийм юм зарлаад баймааргүй байна. Гэхдээ би нэгэнт өгч байгаа өөрийнхөө процедурыг зөрчиж байгаа болохоор тайлбар хийхгүй бол бусад гишүүд чинь алинд нь боломж олгоод, алинд

нь олгодоггүй юм гэдэг асуудал ярих учраас би танд бол үг өгч байна. Цаашдаа би бүх гишүүддээ хандаад хэлчихье. Нэг л журмаараа явъя тэгэх үү. Тэгээд хаасан бол хаасан. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Дарга аа, би бол хамгийн эрт бүртгүүлсэн шүү. Би зүгээр сая орж ирлээ. Яагаад үг хэлэх болчхов гэхээр Энхбаяр гишүүн горимын санал гаргаж байгаатай холбоотойгоор энэ боловсруулалт дээр нь бас анхаараач гэдэг зүйлийг л хэлэх гэж байгаа юм. Хэлэлцээд эхэлсэн бол би саналаа хэлэх гэж байсан юм.

Тэгэхээр энэ Улсын Их Хурлын тогтоолын хавсралт нэмэлт, өөрчлөлт оруулах дээр Энхбаяр гишүүн 7 хоногоор хойшлуулъя гэж байгаа дээр бид хэд бас хэд хэдэн юм анхаармаар байгаа юм. Жишээ нь энэ шүүгч нарын цалинг Улсын Дээд шүүхийн шүүгчидтэй уях гэж байгаа байхгүй юу. Би хэлэлцэх асуудал ярьсан бол энийг ярих гэж байсан. Энийг дахиж оруулж ирж боловсруулахад анхаарахгүй бол Улсын Дээд шүүхийнх нь шүүгчийн цалин хөдлөхөд бүгд хөдлөхөөр ингээд хийчихсэн ийм сонин байдлаар энэ тогтоолыг оруулж ирсэн. Энийгээ анхаараач гэдэг зүйлийг горим гаргаад буцаах гэж байгаа бол хэлж, засаж оруулж ирэх талаас нь анхаарахгүй бол болохгүй нь гэдэг зүйлийг 1 дүгээрт хэлж байгаа юм.

2 дугаарт яах вэ, зүгээр энэ цалин хөлсний нэмэгдлийг илүү болгох үүднээсээ л бас ийм зүйлүүд яригдсан. Тэгэхдээ гишүүдийн хэлж байгаа зөв. Ер нь бол цаашдаа энэ төрийн албаны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, тодотгох энэ асуудал дээр бүх шатад байгаа хүмүүсийн докторын зэрэг энэ тэр дээр бол илүү тийм цалингийн нэмэгдэл өгдөг, энэ тэрийг бол болимоор байгаа юм. Энэ бол зүгээр тухайн албан тушаалд тавигдах шалгуур байж болохоос биш цалин хөлсийг нэмэгдүүлдэг шалгуур биш. Хүнийг сурсан, мэдсэн, төгссөн сургуулиар нь ялгадаг тийм процедурыг Монгол төр уламжлалынхаа хувьд зөндөө тогтоож ирсэн. Тэгээд сүүлдээ энэ боловсролын чанартай өөрчлөлт оруулаад, баахан хуурамч докторууд бий болоод, ингээд бараг тэтгэвэрт гарахын 5, 6 жилийн өмнө төрийн албанд докторуудаа тоолбол битүү шүү дээ. Тэгээд энийг ямар хэрэгсэл болгож авдаг вэ гэхээр цэвэр цалингийн нэмэгдэл 20 хувийг авах гэж явдаг. Тэгэхээр хэдүүлээ ер нь цаашдаа ч гэсэн шүүх гэлтгүй ийм зүйлүүдийг анхаарахгүй бол докторын нэмэгдлийг би бол 20 хувиар тооцож олгодгийг ерөөсөө эрс эсэргүүцэж байгаа юм. Энэ бол тухайн албан тушаалд тавигдах буюу томилогдох хүнд тавигдах шаардлага байж болохоос биш цалин нэмэгддэг шалгуур бол биш. Тэгэхээр ийм зэрэг юмнуудыг анхаарч орж ирмээр байна. Тэгээд нэгэнт энэ горимын санал гарахаас өмнө хэлж явахгүй бол эдгээр саналууд дахиад ороод ирвэл бас хэцүү юм л гэдэг зүйлээс би үг авч байгаа юм шүү.

Д.Цогтбаатар: Саяын энэ Номинчимэг гишүүн, Энхбаяр гишүүн 2-ын санал ер нь төстэй байна гэж үзээд, нэгтгээд тэгвэл энэ асуудлыг хойшлуулъя гэсэн томъёоллоор санал хураая гэж бодож байна. Яагаад ингэж байгаа гэхээр бас энэ оруулж ирж байгаа хүмүүс чинь тэнгэрээс юм авч оруулж ирээгүй шүү. Байгаа хууль чинь тийм юм билээ. Одоо тэр зэрэг дэв гэдгийг чинь хууль дээрээ байж байгаа. 21 дүгээр тогтоол гээд Улсын Их Хурлын тогтоол байж байна лээ. Тэгээд надад тэр нь таалагдаж болно, таалагдахгүй байж болно. Би гэхдээ субъектив хандаж чадахгүй. Байгаа хуулийнхаа л хүрээнд хандана шүү дээ. Тэгээд хуулийнхаа хүрээнд асуудал аваад ороод ирж байхад би энд оруулна, оруулахгүй гээд сууж байдаг хүн нь биш. Гэхдээ харин гишүүдэд ийм зөрүүтэй үзэл бодол байгаа учраас энэ оруулж ирж байгаа хүмүүс бас гишүүдтэй яг сууж энэ асуудлуудаа сайн танилцуулах нь бол зүйтэй байх гэж би бодож байна. Тэгээд тал

талдаа ахиад Байнгын хороогоороо орж ирээд хэлэлцэнэ гэдэг чинь хэлэлцэж байгаа хэрэг байхгүй юу. Түүнээс шийдэж байгаа хэрэг биш. Та нар л саналаа өгч, эс өгч шийднэ шүү дээ. Тэгэхдээ эхлээд оруулж ирэхээсээ өмнө нэлээн тэр танилцуулга юмнуудаа хийх нь зөв гэж бодож байна.

Номинчимэг гишүүн ээ, 5 дахь асуудлыг тэгээд хойшлуулъя гэж байгаа юу, анхааруулъя гэж байна уу. Тэгвэл 5 дахь асуудал дээр бол би санал хураахгүй. Гэхдээ энэ үнэн шүү. Ганцхан та нар дээр гарч байгаа биш. Одоо намайг Байнгын хорооны дарга гээд би чинь нөгөө удирдаж байгаа ухаантай болохлоор асуудал пад гээд л тулгаад л аваад л ороод ирнэ. Би өөрөө ч хааяа уншиж амжихгүй орж ирж байгаа. Манай Тамгын газрынхан энийг бас анхаараарай. Гишүүд одоо нөгөө informed consent, informed decision making гэж маш чухал зарчим байгаа. Өөрөө бүрэн гүйцэт мэдээлэл авч ухамсарлаж байж кнопоо гишүүд дарах ёстой.

Түүнээс ингээд тулгаад, цаг туллаа, яарлаа гээд Их Хурлын гишүүдийг шахаж байгаад шийдвэр гаргадаг тэр байгууллага Улсын Их Хурал биш шүү гэдгийг ойлгуулмаар байна. Тэрийг цаашдаа бусад бүх байгууллагууд энэ гүйцэтгэх засаглалын байгууллагууд Засгийн газар ч гэсэн ойлгох хэрэгтэй. Яаралтай журмаар оруулж ирдэг хүрээндээ эсвэл оруулж ир, эсвэл хангалттай гишүүд танилцах боломжтойгоор асуудлыг оруулж ир гэдэг бас лав л манай Байнгын хороонд харьяалагдаж байгаа байгууллагууд энийг анхаарч үзээрэй гэж бас протоколд үлдээмээр байна.

Тэгвэл ингээд энэ чинь 1, 2 дугаар асуудал биш ээ, 2, 3 дугаар асуудлыг хойшлуулъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ дээр холбогдуулан харин Хууль зүйн байнгын хорооныхоо гишүүдийг байхад энэ Тэмүүжин гишүүн ч нэг бус удаа ярьж байсан маш чухал асуудал яригдах гэж байна. Миний санаж байгаагаар яг парламент дээр одоо яг албан ёсоор энэ асуудал анх удаа гарч ирэх гэж байна. Ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд санал өгөхгүй байх. Баасанжаргал гишүүнд би микрофон өгье. Маш зөв асуудал энэ гишүүн хөндөж ярьж байгаа юм. Энэ дээр та байр сууриа хэлэхгүй юу. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Хэлэлцэж байгаа энэ 2 дахь, 3 дахь асуудалтай холбоотой ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй гээд урьдчилаад Байнгын хорооны дарга болоод Ёс зүйн байнгын хорооны даргад бичгээр бол мэдэгдчихсэн байгаа. Тэгээд нөгөө энэ хүрээндээ би ганцхан санал хураалт биш хэлэлцүүлэгт ч гэсэн бас оролцохгүй, ямар нэгэн байдлаар байр сууриа илэрхийлэх нь өөрөө зохисгүй гэж бодоод санал хураалт, хэлэлцүүлэгт аль алинд нь оролцохгүй гэж байгаа. Тэгэхдээ харамсалтай нь энэ нөгөө машин нөгөө санал өгөхгүй болохоор эсрэг буюу дэмжээгүй гэдэг санал хураалтаар автоматаар тоологдчихдог юм байна. Тэгэхээр энийг одоо протоколд үлдээгээд, санал өгөөгүй түдгэлзэнэ гэх үү. Яалт ч үгүй тийм процессын юман дээр яг тийм санал хураалтад оролцоогүй л гэдгээр гэсэн үг.

Үгүй үгүй. Манай гэр бүлийн хүний хувьд бол шүүхийн ажил хийдэг. Тийм учраас би энэ асуудал дээр оролцохгүй л гэж байгаа юм. Тэгэхээр нөгөө хэлэлцэхэд нь ч бас оролцох нь зохимжгүй гээд ганцхан санал хураалт биш.

Д.Цогтбаатар: Энэ дээр одоо манай Их Хурал ч гэсэн яг анхаарч үзэх асуудал гараад ирж байгаа. Манайхан бүгдээрээ ашиг сонирхлын зөрчил гэхээр муу муухай юм байна гэж бодоод байдаг. Тэгтэл энэ амьдралд чинь яг өөртэй нь холбоотой асуудал орж ирж байгаа тохиолдол энд яах аргагүй гэр бүлийнх нь хүн энэ салбарт нь ажиллаж байгаа маш ёс, зүйтэй, зөв асуудал гаргаж ирж байгаа байхгүй юу. Надад ашиг сонирхлын зөрчил байна. Тийм учраас би энд ямар нэгэн байдлаар оролцохгүй гээд энэ гишүүний энэ бүрэн эрх. Маш ёс зүйтэй энэ асуудалд хандаж байгаа. Харин Улсын Их Хурлын Тамгын газарт хандаад хэлэхэд одоо ингээд ирцэд орчхоод, гарч болохгүй болчхож байгаа юм. Үгүй гарч болохгүй. машин чинь гарахгүй байгаа байхгүй юу. Тэгэнгүүт эсрэг санал өгч байгаа гараад байгаа байхгүй юу. Тэгтэл энэ хүн би ерөөсөө оролцохгүй гээд. Тэгсэн оролцохгүй байх эрхийг чинь өнөөдөр Үндсэн хуулиар олгогдсон эрхийг чинь машин хаачаад байгаа байхгүй юу. Харин тэгэхээр чинь ирцэд ирчхээд би яг санал хураалтдаа оролцохгүй байх эрхтэй байгаад байгаа байхгүй юу. Тэгтэл энд заавал эсрэг санал өөрийн чинь өмнөөс машин өгч гаргаад байгаа байхгүй юу.

Тийм учраас би энд харин яг одоо тэр эрхээ хэрэгжүүлэх гэж байна. Яагаад гэвэл би эрхээ хэрэгжүүлж байгаа биш, Үндсэн хууль хэрэгжүүлж байгаа юм. Энэ хүн энэ санал хураалтад ороогүй. Протоколд тэгж тэмдэглэх ёстой. Санал хураалт дээр бол “эсрэг” гэж гарсан байгаа ч гэсэн тэр бол “эсрэг” санал биш. Энэ хүн зүгээр энэ санал хураалтад ороогүй. Энийг тэгэхээр түдгэлзсэнээр жишээлбэл бүртгэж авах хэрэгтэй гэдгийг протоколд тэмдэглэж үлдээмээр байна.

Тэгвэл ингээд 2 асуудал хэлэлцэх асуудлаас хасагдаж байна. Хэлэлцэх асуудалдаа орьё.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан **Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулна.**

Ажлын хэсэгт О.Бат-Эрдэнэ Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны дэд дарга, Х.Номингэрэл Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Хүний эрх, эрх зүйн бодлогын зөвлөх, Ж.Мөнхболд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга, Б.Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, С.Дондов Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Б.Амарсанаа МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, Ц.Мөнхбат Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн, З.Сүхбаатар Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, Х.Эрдэнэ-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, С.Эрдэнэболор Отгонтэнгэр Их сургуулийн ахлах багш. Ингээд нэр дэвшигчид бол та бүгд мэдэж байгаа. Бид нар урьд нь хэлчихсэн юм чинь. Машлан Алтан-Очир, нөгөөдөх нь Самдангийн Энхбаатар гэсэн ийм 2 нэр дэвшигч явж байгаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэндийг хүргэе. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч М.Алтан-Очир, С.Энхбаатар нартай ярьсан нэр дэвшигчийн сонсголын тайланг танилцуулж байна.

Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:

Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг Улсын Их Хурал нээлттэйгээр нэр дэвшүүлж, сонгон шалгаруулсны үндсэн дээр томилгооны сонсгол хийж, томилохоор заасан байдаг.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-д Улсын Их Хурал Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг нэр дэвшүүлж томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг Монгол Улсын Шүүхийн тухай хуульд заасан журмыг баримтлан хэлэлцэнэ гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2-т Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд бусад 5 гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно гэж, 77 дугаар зүйлийн 77.5.2-т энэ хуулийн 77.5.1-д заасны дагуу тайланг байршуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор томилгооны сонсголын товыг зарлах гэж, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30.1.1 Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол, 30.3-д нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо явуулна. 30.4-д нэр дэвшигчийн сонсгол явуулахад энэ хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтална гэж заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан зохион байгууллаа.

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн Машлайн Алтан-Очир, Самдангийн Энхбаатар нар нь Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам болон нэр дэвших тухай хүсэлт загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77.2-т заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 22-ны 5 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ахалж, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны дэд дарга О.Бат-Эрдэнэ ... энийг товчилчихъё. Сая Байнгын хорооны дарга хэлчихсэн учраас.

Ажлын хэсэг хууль журмын дагуу сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх, нэр дэвших тухай хүсэлт, материал хүлээн авах, ажлын хэсэг байгуулах, нэр дэвшигчдээ бүртгэж, нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн баримт бичгийг parliament.mn цахим хуудсанд байршуулах, нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх, ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах, нэр дэвшигчийг тодруулан Улсын Их Хуралд санал болгох гэсэн 8 үе шатын хүрээнд зохион байгуулж, С.Энхбаатар, М.Алтан-Очир нарыг хууль зүйн байнгын хороонд танилцуулсан.

Хууль зүйн байнгын хороо нэр дэвшигчтэй хийх томилгооны сонсголыг 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулахаар тов тогтоосны дагуу

сонсголыг зохион байгуулсан. Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан. Сонсголын тов хугацаа сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас parliament.mn болон бусад сайтуудад 20 хоногийн хугацаанд давтамжтай байршуулж, оролцогч ажиглагчийг бүртгэсэн.

Мэдээллийн дагуу 3 оролцогч бүртгүүлснээс оролцогч Пүрэвдоржийн Бадамрагчаа ажиглагч Пунцагийн Эрдэнэбаатар нар сонсголд оролцсон болно. 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 12 цагт Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, сонсголд Хууль зүйн байнгын хорооны гишүүн Дамдины Цогтбаатар, Жуковын Алдаржавхлан, Хүрэлбаатарын Баасанжаргал, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Одсүрэнгийн Номинчимэг, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Баттөмөрийн Энхбаяр, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд нарын 13 гишүүн оролцсон.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Машлайн Алтан-Очир, Самданы Энхбаатар нарын товч танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, сонгон шалгаруулах ажлын хэсгийн ахлагч Сандаг-Очир танилцуулж, нэр дэвшигч нар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших болсон үндэслэл, эзэмшсэн боловсрол, ажлын туршлагаа танилцуулсан. Нэр дэвшигч Машлайн Алтан-Очирын талаарх сонгон шалгаруулах ажлын хэсгийн тайланг ажлын хэсгийн гишүүн илтгэгч гишүүн Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, нэр дэвшигч Самданы Энхбаатарын талаарх сонгон шалгаруулах ажлын хэсгийн тайланг ажлын хэсгийн гишүүн, илтгэгч гишүүн Оросоогийн Бат-Эрдэнэ тус тус танилцуулсан.

Нэр дэвшигч нар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнд нэр дэвших болсон үндэслэл, эзэмшсэн боловсрол, ажлын туршлагаа танилцуулсан талаар:

Нэр дэвшигч Машлайн Алтан-Очир. Шүүхийн бие даасан байдлын гол баталгаа болсон шүүхийн байрны асуудлыг шийдвэрлэх талаар өнөөдрийн байдлаар Монгол Улсад 117 шүүх, 42 тамгын газар 42 байранд үйл ажиллагаа явуулж байгаагаас 36 стандартын шаардлага хангахгүй байранд, 4 шүүх прокурор өртэй хамт, мөн хэд хэдэн шүүх орон нутгийн өмчийн байранд түрээсээр байгаа нь шүүхийн бие даасан байдлын гол баталгааг хангахад зайлшгүй хийгдэх шаардлагатай ажил гэж үзэж байна.

Мөн шүүхийн цахимжилтын талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, харилцан ажилладаг байгууллагатай мэдээлэл солилцдог нэгдсэн программ хангамжийг бий болгох, орчин үеийн технологийн хөгжил бүхий тоног төхөөрөмж нэвтрүүлэх, аюулгүй байдлыг хангах, шүүгч болон шүүхийн захиргааны ажилтны цахим ур чадварыг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.

Мөн шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх талаар улсын хэмжээнд 724 шүүгч ажиллахаас Улсын дээд шүүхээс бусад шүүхэд 200 гаруй шүүгчийн орон тоо дутуу, 2023 онд 1 шүүгч 604 хэрэг шийдвэрлэсэн гэсэн статистик мэдээнээс үзвэл сард 50 хэрэг шийдвэрлэж байгаа нь ажлын ачаалал хэт их байгааг харуулж байгаа учир шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Мөн шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх талаар 2023 онд шүүхийн захиргааны ажилтан 367 гарч 422 ажилд орсон гэсэн мэдээнээс үзвэл шүүхийн захиргааны ажилтны хүний нөөцийн хөдөлгөөн их байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь шүүхийн захиргааны ажилтны ажлын ачаалал их, сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх боломж бага ажиллах орчин нөхцөл бүр бүрэн хангагдаагүйг харуулж байгаа гэжээ.

Мөн дээрх асуудлуудын гол зангилаа нь эдгээртэй холбоотой цалин, төсөв, санхүүгийн асуудал дутмаг, бүрэн шийдвэрлэгдээгүй байдлыг харуулж байгаа ба нарийн судалгааны үндсэн дээр тооцоолон гаргаж холбогдох эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх зэрэг үйл ажиллагаанд анхаарлаа хандуулан шүүхийн тухай хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах болно гэж танилцууллаа.

Нэр дэвшигч Алтан-Очир болон ажлын хэсгийн тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд, Баасанжаргал, Номинчимэг, Отгонбаяр, Алдаржавхлан, Цогтбаатар нар болон оролцогч Бадамрагчаа нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд шүүхийн нэр хүнд буурч олон нийтийн итгэл алдарч байгаа асуудалд нэр дэвшигчийн байр суурь болон иргэдийн итгэлийг сэргээхийн тулд ямар бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар шүүхийн шийдвэртэй холбоотой ташаа мэдээлэл олон нийтийн дунд тархаж, шүүхийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байгааг хэрхэн зохицуулах талаар асуулт асуусан.

Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал шүүхийн шинэчлэлийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн одоогийн нөхцөл байдлыг хөндөж, үүнд ямар дүгнэлт хийж байгаа талаар шүүхийн бүтэц, зохион байгуулалтын үр дүнг сайжруулах чиглэлээр ямар ажлуудыг хийх, мөн шүүгчдийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй болон хүний нөөцийн чадавхыг сайжруулахад анхаарах асуудлын талаар иргэдэд шүүхийн үйл ажиллагааг хэрхэн ойр хүртээмжтэй байлгах талаар асуулт асуусан.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг шүүхийн хараат бус байдал хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хэрхэн хангах талаар, иргэд шүүхээс шударга ёсыг мэдрэх, эрх ашгаа хамгаалуулах боломжийг хэрхэн бүрдүүлж байгаа талаар, шүүхийн шинэтгэлийн ажлын хэрэгжилтийн явц үр дүнг сайжруулах төлөвлөгөөний талаар асуулт асуусан.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр Шүүхийн хөгжлийн бодлого, цаашид урт хугацаанд тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан нэр дэвшигчийн шүүхтэй холбоотой хамаатан садан байгаа эсэх, мөн шүүхийн системд хонгилын шүүх гэж нэрлэгддэг шударга бус тогтолцоо байдаг эсэх талаар, оролцогч Бадамрагчаа нэр дэвших болсон үндэслэл болон хууль зүйн өндөр мэргэшилтэй эсэхийг хэрхэн ойлгож байгаа талаар, мөн нэр дэвшигч шүүх хуралдаанд оролцож байсан эсэх, шүүхийн ажиллагааны талаарх мэдлэг туршлагын талаар, шүүгчийн хараат бус байдалд учирч буй томоохон эрсдэлүүд тэдгээрийг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авах саналтай байгаа талаар, иргэн, захиргааны шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй байгааг онцолж энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх, Шүүхийн ерөнхий зөвлөлд ямар байр суурь баримтлах ёстой талаар тус тус тодруулсан.

Нэр дэвшигч Самданы Энхбаатар. Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 33 дугаар тогтоолоор Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсан. Шүүх эрх мэдлийн бодлогын баримт бичигтэй болсноор 10 жилийн алсын хараагаа харж нээлттэй ил тод байдлыг хангах, зорилт үр дүн бүрийн ард хэмжих, шалгуур болон санхүүжилтийг тавьсан нь цаасан дээрх бус бодит биелэлтийг хангах хөшүүрэг болсон.

Мөн шүүх эрх мэдлийн хүрээнд нэн тэргүүнд тавигдах иргэний эрхийг бүх шатны шүүх ажиллагаанд баталгаатай эдлүүлж, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахад бүрэн анхаарч, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлэх, өөрийн туршлагад тулгуурлан шүүх эрх мэдлийн байгууллагын захиргааны менежментийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх шүүхийн үйлчилгээний стандартыг төлөвшүүлэх бэхжүүлэх талаар тууштай зарчим баримталж ажиллана гэж.

Мөн иргэнд ээлтэй нээлттэй шүүхийн чухал алхам болсон цахимжуулалт, цахим платформд суурилсан шийдлүүд, түүний дотор тоног төхөөрөмжийн шинэчлэлд анхаарлаа хандуулна.

Мөн шүүхийн бие даасан байдлыг хангах, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэхэд нэн шаардлагатай шүүхийн байрны асуудал олон жил яригдаж шийдвэрлэгдэхгүй ирсэн. Одоогийн байдлаар 10 шүүх огт байргүй байгаа ба бүсчилсэн байдлаар байрны асуудлыг 4 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс төлөвлөж байгааг дэмжин ажиллана гэж.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан ёсны цахим сайтад гарсан статистик судалгаагаар 2022 онд 111 мянга, 2023 онд 118 мянган хэрэг дунджаар шүүхээр шийдвэрлэгдсэн ба үүний 80 хувь нь анхан шатын шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Иймд шүүхийн ачаалал тэнцвэрт байдалд анхаарлаа хандуулах суурь судалгаануудыг хийх шаардлагатай гэж дээр дурдсан асуудлын хүрээнд төрийн ажлын туршлага, дотоод, гадаадын өндөр хөгжилтэй улс орны сургуульд сурсан мэдлэг, чадвартаа тулгуурлан ёс зүйн өндөр сахилга баттай байж, Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, бусад хэм хэмжээний хүрээнд ажил үүргээ гүйцэтгэж хариуцсан салбар чиглэлээ сайжруулахад өөрийн хувь нэмрийг оруулахаар хичээн ажиллах болно гэж тус тус танилцуулсан.

Нэр дэвшигч Энхбаатараас болон ажлын хэсгийн тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд, Баасанжаргал, Номинчимэг, Соронзонболд, Сандаг-Очир болон оролцогч Бадамрагчаа нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд хамгийн чухал анхаарч ажиллах асуудал бол нэр дэвшсэн албан тушаалын гол зорилт, үйл ажиллагааны чиглэлийн талаар,

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал шүүхийн үйл ажиллагааг ил тод ойлгомжтой болгоход ямар гарц шийдэл байгаа талаар, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ажлын талаар,

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг 2023 оны шүүхийн индекст шүүгчийн ёс зүй сайжирч байгаа ч шүүхэд итгэх олон нийтийн итгэл буурч байгааг хэрхэн сайжруулах талаар, Шүүхийн үйл ажиллагааг цахимжуулахад анхаарах шийдлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Шүүхийн ерөнхий зөвлөлийн зүгээс шүүхийн цахимжуулалтын талаар анхаарах асуудал хийж хэрэгжүүлэх ажлын талаар, оролцогч Бадамрагчаа нэр дэвших болсон үндэслэл болон хууль зүйн өндөр мэргэшилтэй эсэхийг хэрхэн ойлгож байгаа талаар, мөн нэр дэвшигч шүүх хуралдаанд оролцож байсан эсэх, шүүхийн ажиллагааны талаарх мэдлэг, туршлагын талаар, шүүгчийн хараат бус байдалд учирч буй томоохон эрсдэлүүд, тэдгээрийг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авах саналтай талаар тодруулж хариулт авсан болно.

Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Сандаг-Очир, Тэмүүжин, оролцогч Бадамрагчаа нар үг хэлсэн болно.

Сонсголыг Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар хааж үг хэлсэн болно.

Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу Хууль зүйн байнгын хороо нэр дэвшигчийн сонсголыг 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2024 оны 12 сарын 13-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргасан бөгөөд нэр дэвшигч Алтан-Очир, Энхбаатар нарыг хуульд заасан болзол шалгуурыг хангаж байгаа тул Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар эцэслэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Одоо нэр дэвшигч Машлайн Алтан-Очирын танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, илтгэгч гишүүн Оросоогийн Бат-Эрдэнэ танилцуулна. Бат-Эрдэнийн микрофоныг өгье. 3 дугаар микрофон.

Х.Эрдэм-Ундрах: Эрхэм хүндэт байнгын хорооны дарга гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Нэр дэвшигч Машлайн Алтан-Очир нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хэрхэн хангаж буй талаарх ажлын хэсгийн санал дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч М.Алтан-Очир нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын

10.2.1-д заасны дагуу хүсэлт, мөн холбогдох баримт бичгийг ирүүлсэн бөгөөд эдгээрийг судлан үзэж үнэн зөвийг нягталсан болно.

Нэр дэвшигч М.Алтан-Очир нь боловсролын хувьд 1995-1999 онд Цагдаагийн дээд сургуулийг эрх зүйч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн. 2001-2003 онд ТЕГ-ын дээд сургуульд суралцаж Аюулгүй байдлын магистрын зэрэг хамгаалсан. 2010-2012 онд Жонон дээд сургуулийг эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. 2012-2014 онд ОХУ-ын Москва хотод ДХЯ-ны удирдлагын академид суралцан удирдахуйн менежерийн магистрын зэрэг хамгаалсан. 2014-2017 онд Дотоод хэргийн их сургуулийн гэмт явдал судлалын докторын хөтөлбөрт суралцан төгсөж, 2019 онд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан. Эдгээрийг нотлох баримт болгож дипломын хуулбарыг тус тус ирүүлсэн болно.

Нэр дэвшигч М.Алтан-Очир нь 1999 оны 10 дугаар сараас Шүүхийн Шийдвэр биелүүлэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх газарт ахлах төлөөлөгчөөр ажил хөдөлмөрийн гараагаа эхэлж, 2023 оны 8 дугаар сарыг хүртэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх системийн шат шатын байгууллагад тасралтгүй 28 жил эрх зүйч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан мэргэжлээр ажилласан байна. Ажилласан байдлыг дурдвал 1999 оны 10 сараас 2000 онд Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх газарт ахлах төлөөлөгчөөр 3 сар, 2000 оны 1-9 сард Барилгын материалын ашиглалтын өмнөх захиргаа буюу 409 дүгээр ангид ахлах төлөөлөгчөөр 8 сар, 2000-2003 онд Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь 423 дугаар ангид дэд даргаар 3 жил, 2003-2004 онд 401 дүгээр ангийн гүйцэтгэх ажил харуул хамгаалалт эрхэлсэн дэд даргаар 2 жил орчим, 2004-2012 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хэнтий аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны даргаар 8 жил, 2015 оны 2-4 дүгээр сард 409 дүгээр ангийн даргаар 2 сар, 2015 оны 4-8 дугаар сард Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Амгалан дахь хорих 421 дүгээр ангийн даргаар 4 сар, 2015 оны 8 дугаар сараас 2017 оны 7 дугаар сар хүртэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Захиргааны удирдлагын газрын даргаар 9 сар, 2017 оны 7-12 дугаар сар сард Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд даргаар 5 сар, 2018 оны 1 дүгээр сараас 2021 оны 11 дүгээр сар хүртэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт шалгалтын газраар 3 жил 10 сар, 2021 оны 11 дүгээр сараас 2022 оны 11 дүгээр сар хүртэл мөн ерөнхий газрын Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын даргаар 1 жил, 2022 оны 11 сараас 2023 оны 4 дүгээр сар хүртэл Ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албанд Мэргэжлийн удирдлагын хэлтсийн даргаар 5 сар. Хамгийн сүүлд 2023 оны 4-8 дугаар сард Ерөнхий газрын сургалтын төвд менежерээр 4 сарын хугацаатай тус тус ажилласан байна. Эдгээрээс харахад дээрх журмын 2.1.2, 2.2.2-т заасан шаардлагыг хангасан гэж үзэх боломжтой байна.

Нэр дэвшигч Алтан-Очир нь дангаар бичсэн 3, бусадтай хамтарч бүтээсэн болон редактораар ажилласан 10 ном, түүхэн замнал, гарын авлагын талаарх мэдээлэл, гадаадад болон дотоодод хэлэлцүүлсэн илтгэл, хэвлэн нийтлүүлсэн өгүүлэл, нийтлэл нийт 12-ыг бол ирүүлсэн. Эдгээрээс заримыг нь дурдвал Хорих ял эдлүүлэх дэглэм, Хяналт шалгалтын алба, Мөнх дурсагдах дайчид, Гайхамшигт Монгол цэрэг, Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал, Хан Хэнтийн бүтээн байгуулалтын 35 жил зэрэг. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүлд өгүүлэл нийтлэлүүд, ОХУ-ын Закуан И Права сэтгүүлд удирдагч багшийн хамт орос хэл дээр өгүүлэл 1-ийг тус тус бичиж нийтлүүлсэн

байна. Ирүүлсэн бүтээлүүд нь М.Алтан-Очирын докторын зэрэг хамгаалсан сэдвийн хүрээнд болон түүний хашиж байсан шийдвэр гүйцэтгэлийн албаны чиг үүрэг, байгууллагын түүхэн замнал, бүтээн байгуулалт зэрэг ажил мэргэжилтэй нь шууд холбогдох ба бичлэгийн хувьд ойлгомжтой, цэгцтэй, сэдэв агуулгын уялдаа холбоо сайн болсон байна гэж үзэхээр байна.

Мөн журамд заасны дагуу 3-аас доошгүй хүнээс тодорхойлолт авч ирүүлэхээр байсан. Энэ дээр 1 дүгээрт нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга асан, бригадын генерал Батжаргалын тодорхойлолт байдаг. Мөн бригадын генерал Ганхүүгийн ирүүлсэн тодорхойлолт байдаг. Энэ 2 хүний тодорхойлолт бол ажил байдалтай нь холбоотой тодорхойлолтууд байдаг. Мөн академич Ж.Амарсанаагийн гаргаж ирүүлсэн тодорхойлолт байгаа. Нэр дэвшигч Алтан-Очирын 2019 онд докторын зэргээ амжилттай хамгаалсан “Хорих ял эдлүүлэх дэглэм” нэг сэдэвт бүтээлийнх нь редактораар ажилласных нь хувьд тус тус тодорхойлж ирүүлсэн байдаг. Нэр дэвшигч Алтан-Очирын удирдах албан тушаалтан, хамт ажиллаж байсан, удирдлагад нь ажиллаж байсан ажил хэргийн харилцаатай байсан 10 хүнтэй бол ярилцлага хийж мэдээлэл авсан.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны ажлын албанд нэр дэвшигчийн талаар иргэд олон нийтийн байгууллагаас мэдээлэл ирүүлээгүй. Нэр дэвшигчийн эзэмшсэн мэргэжил, боловсролын түвшин, мэдлэг чадвар, ажил, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хуримтлуулсан туршлага зэрэгт тулгуурлан хууль зүйн өндөр мэргэшилтэй гэж дүгнэх боломжтой гэж ажлын хэсэг үзсэн. Мөн журамд заасан бусад шалгуурын хувьд нэр дэвшигч нь Монгол Улсын иргэн, 50 настай, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн 5 жилд улс төрийн болон намын удирдах албан тушаал хашиж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, сахилгын шийтгэлээр халагдаж эсхүл огцорч байгаагүй, урьд нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, шүүгч, шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаж байгаагүй, шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокуророор тус тус ажиллаж байгаагүй болно. Цуглуулсан бүх нотлох баримт дээр дурдсан мэдээлэл дүгнэлтэд тулгуурлан нэр дэвшигч нь хууль зүйн мэдлэг, ур чадвар, ёс зүй, зан төлөвийн хувьд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 2.1, 2.2, 2.3-д заасан шаардлагыг хангаж байх тул Улсын Их Хуралд санал болгохыг дэмжих саналтайгаар ажлын хэсэг санал, дүгнэлт гарсан болно.

Нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайланг бол ажлын хэсгээс хүргүүлсэн байгаа. Ингээд танилцуулж дууслаа.

Д.Цогтбаатар: Саяын танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, илтгэгч гишүүн Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах танилцууллаа. Одоо нэр дэвшигч Самдангийн Энхбаатарын танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, илтгэгч гишүүн Оросоогийн Бат-Эрдэнэ танилцуулна. Хэддүгээр микрофон байна. 1 дүгээр микрофон.

О.Бат-Эрдэнэ: Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг хийе. Нэр дэвшигч Самдангийн Энхбаатар 1977 онд төрсөн, эрэгтэй, 47 настай, Улаанбаатар

хот, Сүхбаатар дүүрэгт оршин суудаг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших хүсэлт гаргасан.

Нэр дэвшигч Энхбаатар нь боловсролын шаардлагыг бүрэн хангасан. Тэрээр 1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч бакалавраар, 2007 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг хууль зүйн магистр, 2015 онд Австрали Улсын Маккюри Их сургуулийн олон улсын харилцааны магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн. 2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 30 дугаар зарлигаар Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг, 2024 онд 89 дүгээр зарлигаар тэргүүн түшмэлийн гутгаар зэрэг, дэв олгож байсан нь дипломын хуулбар болон бусад баримтаар нотлогдсон. Эрх зүйч мэргэжлээр 10-аас дээш жил ажилласан байх шаардлагыг бүрэн хангасан. Түүний ажлын тодорхойлолт, ажил үүргийн хуваарь, ажлын үнэлгээгээр бүрэн нотлогдож байна. Тэрээр эрх зүйч мэргэжлээр гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагт мэргэжилтнээс Тамгын хэлтсийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний бүртгэл мэдээллийн төвийн дэд дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын орлогч дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт, Засгийн газрын тохируулагч агентлаг ШӨХТГ-ын орон тооны гишүүн бөгөөд дэд дарга, Соёмбо Легал Партнерс ХХН-д зөвлөх, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д дэд захирал, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Архивын ерөнхий газрын дарга бөгөөд Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчаар ажиллаж байна.

Энхбаатар нь эрх зүйч мэргэжлээр ажиллахдаа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хууль 1963 оны эх сурвалж, Хаадын зарлиг, өргөмжлөл, жуух бичиг, Халхын голын орчим дахь Зэвсэгт мөргөлдөөн зэрэг 3 ном бүтээлийг судлаачдын хамтаар туурвисан байна.

Тэрээр сүүлийн жилүүдэд архивын эрх зүйн орчныг бүхэлд нь шинэчлэх ажлыг манлайлан ажиллаж, баримт хадгалах, хамгаалалтын орчныг сайжруулах, архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн уялдааг хангах, боловсронгуй болгоход анхааран ажилласан.

Нэр дэвшигч Энхбаатар нь Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт амжилттай ажиллаж, батлуулсан бөгөөд тус хуулийг дагаж гарах журам, заавар, стандартыг боловсруулж, ажлын хэсгийг ахалж ажилласан байна.

Улсын бүртгэлийн байгууллагад ажиллах хугацаандаа Иргэний бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэл, Эд хөрөнгийн бүртгэлийн багц хуулиуд, журмын төслүүд дээр ажиллаж амжилттай батлуулсан. Мөн улсын бүртгэлийг цахимжуулах ажлыг ахалж ажилласан. Түүнчлэн улсын бүртгэлийн стандартыг боловсруулж анх удаа төрийн байгууллагад нэвтрүүлсэн байна. Тэрээр албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн орчин, улсын бүртгэлийн төгөлдөршил, шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажилласан нь хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлага зэрэг шаардлагыг бүрэн хангаж байна гэж дүгнэж байна.

Нэр дэвшигчийг таньж мэдэх 10-аас дээш хүмүүстэй ярилцлага хийсэн. Нэр дэвшигчийн талаар сөрөг мэдээлэл гараагүй. Ёс зүй, зан төлөвийн тал дээр

бусдын нөлөөнд автахгүй, хараат бусаар шударга ажиллах зан төлөвтэй гэсэн хариулт давамгайлж байсан.

Нэр дэвшигч нь 47 настай учраас төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй. Монгол Улсын иргэн, сүүлийн 5 жил улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаалд эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, сахилгын шийтгэлээр халагдаж, огцорч байгаагүй, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр, шүүгчээр ажиллаж байгаагүй, сахилгын хорооны гишүүнээр ажиллаж байгаагүй.

Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэж байна.

Д.Цогтбаатар: Бат-Эрдэнэ гишүүнд талархлаа ажлын хэсгийн тайлан болон нэр дэвшигчийг танилцуулж дууслаа. Одоо ажлын хэсэг болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Тусдаа. Байхгүй байна. Тэгвэл асуулт асууж, хариулт авч дууслаа гээд тооцъё. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Энэ асуудлаар. Нара гишүүнээр тасаллаа. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Монголчууд хэлдэг. Төр төмбөгөр, ёс ёмбогор гэж хэлдэг. Энэ юу гэсэн утгатай үг вэ гэхээр ерөөсөө л хууль ёс хамгийн эрхэм гэсэн үг. Хуулийг давж хүний субъектив санаа зориг гишгэхгүй гэсэн үг. Тэгэхээр энэ сонсголын үеэр ч гэсэн Улсын Их Хурлын олон гишүүд хэлж байсан. Үүнээс гадна бас нийгэм дээр байдаг маш олон төрлийн иргэдийн шүүмжлэлүүд бол энэ шүүх байгууллага, шүүх байгууллагадаа итгэх, шүүхээс гарч байгаа шийдвэрүүд нь хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнтэй байх асуудал бол дандаа чухлаар тавигдаж байдаг. Тэгэхээр яах вэ, Шүүхийн ерөнхий зөвлөл, тэгээд Дээд шүүх ч гэдэг юм уу анхан, дунд шатны шүүх ч гэдэг юм уу ингээд олон төрлийн шүүхүүд байхад яг маш энгийн элементарны ойлголтоороо бол иргэдэд шүүх бол нэг л гэж ойлгогддог байхгүй юу. Энэ одоо анатомийн хувьд 1 л гэж ойлгогдож байгаа. Тэгэхээр энэ 2 нэр дэвшигчийн хувьд өмнөх сонсгол дээр бас тодорхой мөрийн хөтөлбөр дэвшүүлж байсан. Нэг нь бол 7 зүйл, заалттай, нэг нь бол 5 бүлэг, зүйл, заалттай мөрийн хөтөлбөрүүд дэвшүүлсэн байсан. Мөрийн хөтөлбөр дээр бол давхардсан санаанууд бол байсан. Тэр шүүхийн цахимжилтын асуудал, иргэдэд ойрхон, хялбар болох энэ тэр гэсэн асуудлууд байсан.

2 дугаарт шүүхийн өөрийнх нь одоо хүчин чадавхыг сайжруулах, энэ чиглэлээр гарч байгаа хууль тогтоомжуудыг цааш нь боловсронгуй болгох гэсэн зүйлүүд байсан. Тэр мэдээж энэ бол хэн нь ч сонгогдсон байсан стандартын дагуу ажил хэрэг болоод явах байх гэж бодож байна.

2 нэр дэвшигчтэй холбоотой бол хувь хүнтэй холбоотой болон мөрийн хөтөлбөртэй холбоотой бол асуулт байхгүй. Зүгээр 3 зүйлийг онцолж үг хэлэхдээ бас дурдмаар байна.

1 дүгээрт ер нь энэ 1992 оны ардчилсан Үндсэн хуулиас хойш энэ Шүүх гэдэг тогтолцоог бид ер нь ингээд засаглалын салаа мөчрийн 3 зүйлийн 1 гэдгийг нь олон тохиолдолд мартсаар ирсэн. Ерөнхийлөгчийг 01 дүгээр хүн, Их Хурлын даргаа 02, Ерөнхий сайдыг 03 гээд байдаг. Уг нь нөгөө Монтескагийн эрх мэдлийн хуваарилалтын онолоор бол энэ чинь шүүх засаглал эрх мэдлийн 1 том салаа мөчир байх ёстой. Тэгээд хууль тогтоох, гүйцэтгэх гээд ингээд явдаг. Гэтэл бол

ард түмний дунд бол энэ ойлголт бол тийм түгээмэл биш. Дээрээс нь улс төрчид хүртэл яг энийг нь бол засаглалыг хуваарилах чек энд баланс гэдэг энэ ойлголт дээр бол маш дутуу дулимаг байр суурьтай байсаар ирсэн. Тийм учраас цаашдаа Монгол Улсад шударга ёсыг тогтоох энэ үйл хэрэгт бол энэ шүүх засаглалын бие даасан, шүүгчийн хараат бус, засаглалын энэ салаа мөчрийнхөө мөн чанар луу төгссөн тэр алхмууд бодлогын хувьд болбол явах ёстой гэж боддог. Тэгэхээр энэ зүйл дээр ч гэсэн бас 2 нэр дэвшигч 1 нь сонгогдлоо гэхэд нөгөөдөх нь сонгогдохгүй байлаа гэхэд бас тууштай энэ үзэл санааны төлөө тууштай байхыг хичээгээрэй гэж хэлмээр байна.

Хэн 1 нь сонгогдлоо гэхэд ажил авсан анхны өдрийн урам зориг байдаг. Яваан дундаа тэр нь бүдгэрдэг, сарнидаг, наана цаана болдог. Тэгээд ийм зүйлд битгий автаарай гэж хүсмээр байна. Яагаад энийг хэлж байгаа вэ гэхлээр бас энэ сонсголын дараагаар над руу бол хэд хэдэн хүмүүс ярьж, лоббидох гэж оролдсон. Эндээс бол би тухайн хүмүүст бол шууд хэлсэн. Ёс зүйтэй албанд очих гэж байгаа хүмүүс ийм ёс зүйгүй байдлаар ингэж хандлага гаргаж болохгүй шүү гэдгийг бол хатуу анхааруулсан. Цаашдаа ч гэсэн ер нь Улсын Их Хурлын гишүүд рүү нөлөөлөх гэсэн орлогуудыг хэрхэвч гаргаж болохгүй. Энэ бол ёс зүйн хувьд бол маш том асуудал шүү гэж анхааруулж хэлмээр байна.

3 дугаар хэлэх гэж байгаа зүйл нь болох юм бол ямар ч тохиолдолд улс төрчөөс, төрийн өндөр албан тушаалтнаас хэзээ ч битгий чиглэл, команд аваарай. Авах үйлдэл битгий хийгээрэй. Ийм төрлийн үйлдэл Шүүхийн ерөнхий зөвлөл дээр ямар нэгэн байдлаар болсон тохиолдолд, болох гэж байгаа тохиолдолд, шүүгч дээр илэрч байгаа тохиолдолд таслан сэргийлэх арга хэмжээ авч, хуульдаа үнэнч ёс зүйдээ .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэмж хэлэх юм уу. Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр миний ажигласан нэг зүйл бол ер нь энэ шүүгч бус гишүүнийг томилох ажлын хэсэг дээр үнэхээр нэр дэвшигчид ийм цөөн байгаа нь эсвэл ажлын хэсэг дээрх энэ сонгон шалгаруулалтад нөлөөлөл орж байна уу, эсвэл үнэхээр энд бүртгүүлээд энэ ажлын байран дээр өрсөлдөх сонирхолтой хууль, эрх зүйн мэдлэг, мэргэжилтэй хүмүүс ийм дутмагшилтай байна уу, эсвэл энэ ажлыг сонирхохгүй байна уу гэдэг дээр би гайхаж байгаа юм.

Ингээд хоёрхон нэр дэвшигчтэй. Тэгээд 2 нэр дэвшигчээс 1-ийг нь угаасаа хуулийн хугацаа нь тулсан учраас ингээд сонгоно. Ер нь миний бодлоор энэ бол бас их чухал том ажил юм шиг байгаа юм. Гэтэл энэ дээр ингээд 2-хон л хүн. Тэгээд ер нь бол бас яг манай гишүүдийн дунд ярьж байгаагаар бол яг ч тийм шаардлагыг дээд хэмжээнд нь тултал нь хангасан нэр дэвшигч байхгүй л байгаа даа. Тэгэхээр яах аргагүй л энэ 2-ын аль нэгийг нь сонгоно.

Ер нь бол ажлын хэсэг цаашдаа энэ сонгон шалгаруулалтын мэдээ мэдээллийг маш өргөн дэлгэр мэдээлэх, тэгээд энэ ер нь бол одоо хэн ч сонирхсон шаардлагыг нь, шалгуурыг нь хангаж чадах хэн ч оролцох хэмжээний ийм нээлттэй мэдээлэл түгээдэг байгаасай гэж би их бодлоо. Тэгээд ямар ч л байсан нэг нь одоо шалгарна. Тэгээд тэр шалгарсан хүн хамгийн гол нь хараат бусаар ажиллах чинь хамгийн 1 дүгээр зарчим байгаа. Тэгээд иргэнийхээ эрхийг хамгаалах, иргэнийхээ зөрчигдсөн эрхийг сэргээхийн төлөө чин сэтгэлээсээ

ажиллаж бас хэдийгээр бид нар ийм нөхцөл байдалтай сонгогдсон ч гэсэн шинэ манлайлал, шинэ үлгэр дуурайлыг бий болгох тийм хүн байгаасай гэж бодож байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Би нэг товчхон тайлбар хэлчихмээр байна. Нара гишүүн ээ, энэ бол хуультай явж байгаа болохоор өөрийн чинь сая ярьснаар бид нар мэдээлэл түгээгээгүй, эсвэл дутуу түгээсэн юм шиг яригдаж байна. Би түрүүний бас нэг хурал дээр хэлж байсан. Энэ бол яг хуулийнхаа дагуу олон нийтийн хэвлэл мэдээллээр ил тавигдаад, D-parliament дээр тавигдаад энд ямар нэгэн нууцалж барьсан тийм юм ёстой байхгүй шүү. Энэ чинь ингээд ил тод яваад орж ирж байгаа юм.

Таны хэлж байгаа нэг юм яг үнэн. Ингэж тавиад 2 л хүн орж ирж байгаа байхгүй юу. Энэ салбарын мэдээлэлтэй, мэдээлэлгүй байсан би бас нэг юмыг шууд хэлчихмээр байна. Энэ салбарынхан бүгдээрээ энд орон тоо гарсныг түрүүн нөгөө гишүүн эндээс бид нар чөлөөлөөд л явуулсан чөлөөлөхгүй гэж байгаад л энэ чинь дуулиантай юм болсон шүү дээ. Бүгд мэдэж байсан. Өөрөөр хэлбэл энэ хүрээнийхэн бол мэддэг хүмүүс нь нэр дэвшихүйц болзлоо хангасан хүмүүс нь бүгд мэдэж байсан. Нэг асуудал яг таны хэлж байгаа үнэн байгаа юм. Энд чинь ингээд ирдэг хүн байхгүй болчихсон байхгүй юу. Энэ шүүх засаглалаа дэмжихгүй. Яагаад бид нар сая энэ төсөв эд нар дээр нь Хууль зүйн байнгын хороо би бүх гишүүддээ талархал илэрхийлмээр байгаа юм. Хатуу байр суурьтай байсан. Яагаад энэ дээр тэр бид нар хатуу байр суурьтай байгаад байгаа гэхээр энд байгаа хугацаандаа ямар ч гэсэн шүүх байгууллагыг бэхжүүлж өгөх, тэнд хүн очоод ажиллах сонирхолтой болгож өгөх талаас нь бид нар хүчин чармайлт гаргаж бодлого гаргаж, Их Хурал бол Монгол Улсад бодлого гаргадаг, тэрийгээ баталдаг газар нь Их Хурал шүү дээ. Гүйцэтгэх засаглал бол энийг бодлогыг биелүүлээд явна. Тэгэхээр бид нар тэр бодлогоороо бол үнэхээр ажиллаад явах ёстой. Энэ дээр сайжралт гарах ёстой. Ажлын байрны тэр нөхцөл байдал сайжрахгүй бол хүмүүс бодит байдал дээрээ ийм байгаа юм. Шүүгч дээр сонгон шалгаруулалт он гараад сонгон шалгаруулалт зарлахад 1 дүгээрт хүмүүс ирэхгүй, эсвэл маш цөөхөн хүн ирнэ. Ирж байгаа хүмүүс нь шалгалтынхаа босгыг давахгүй ийм тохиолдлууд маш их байгаад байгаа.

Энэ 2 хүний хувьд бол өөрсдөө энэ ажлын хэсэг эд нар бүгд дүгнэлтүүдээ гаргасан байгаа. Болзлоо бол хангаад яг л орж ирж байгаа, бас урдаа хийсэн, хүнд хэлэх үгтэй хүмүүс орж ирж байгаа. Харин цөөхөн байгаа нь бол бодитой үнэн.

Тэгээд энэ дээр тэгэхээр бид нар цаашдаа анхаарч ажиллах ёстой л гэдгийг хэлмээр байгаа юм. Тантай тэр дээр санал нэг байна.

Алдаржавхлан гишүүн ээ, би тэр журам түрүүн танилцуулчихсан шүү дээ. Одоо үүнээс хойш нэгэнт цаг өнгөрсөн бол хэдүүлээ тэр журмаа барья тэгэх үү. Тэгэхгүй бол Байнгын хорооныхоо даргын хаагаад хэлсэн үгний дараа үг хэлье гээд байх чинь эсвэл та энд ирж суугаад, хурал удирдаад үг хэлээд байж болно.

Ингээд үүгээр гишүүд үг хэлж дууслаа. Ингээд санал хураалт явуулж эхэлье. Нэр дэвшигч Энхбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана. Энэ нөгөө нэрсийн жагсаалт яагаад ингэж орж ирж байгаа вэ гэхээр ажлын хэсэг дээр авсан саналынхаа дагуу нэрс ийм дэс дараатай орж ирж байгаа шүү. Ингээд Самдангийн

Энхбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус ил санал хураана шүү дээ. Энэ бол гишүүдийн бүрэн эрхийн л асуудал. Нээлттэй.

Нэр дэвшигч Самдангийн Энхбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 73,3 хувиар санал дэмжигдлээ.

Гэхдээ энэ дээр Сандаг-Очир гишүүн, Алтанхуяг гишүүн дэмжсэн санал өгсөн байна. Энэ бол чухал шүү. Энэ тоог оруулж тооцохгүй бол би 73,3 гээд тоо хэлчихлээ. Гэхдээ энэ биш шүү. Энийгээ оруулж шинэ тоо надад өгөөрэй. Хувиар нь. Одоо санал хураалтын тэгэхээр дүнг танилцууллаа. Дэмжигдлээ.

Нэр дэвшигч Машлайн Алтан-Очирыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 33 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд шийдвэр гарч байна. Санал хураалтын дүнг аль алин дээр нь би танилцуулсан. Ингээд Шүүхийн зөвлөлийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир гишүүнийг тавьж байгаа. Нөгөө ажлын хэсгийн дарга учраас өөрөө ингээд эхнээс нь дуустал яваад асуудлаа танилцуулах нь зөв байх.

Ажлын хэсэгт талархал илэрхийлье. Бас идэвхтэй бүгдээрээ цаг заваа зарцуулж, идэвхтэй санаачилгатай оролцсон.

11.28 цаг.

Дараагийн асуудалдаа орьё. Ингээд 2, 3 дахь асуудал хасагдсан байж байгаа.

““Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх, хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголын тайланг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүгдэд бол тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбоотойгоор 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт, хяналтын сонсголын тайлан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.4-д заасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандлагаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн Улсын Их Хурлын хяналтын сонсголын тайлан, санал, дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 22 гишүүнээс Монгол Улсын Их Хурлын даргад 2024 оны 8 дугаар сарын 6-ны өдөр Улсын Их Хурлын 03/1114 тоот албан бичгээр Улсын Их Хурлын даргад хяналтын зогсоол зохион байгуулах тухай хүсэлтийг гаргасан. Энэхүү хүсэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-д заасны дагуу Хууль зүйн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж Байнгын хорооны 2024 оны 02 дугаар тогтоолыг баталж, хүний эрх чөлөөг хангахтай холбоотой “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх эрхийн хэрэгжилт” Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн миний биеийг томилон ажиллалаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2 дахь хэсэгт заасны дагуу хяналтын сонсголын тоон мэдээллийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 15-ны өдрийн 17 цаг 30 цаг хүртэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өдөр бүр давтамжтай мэдээлж, сонсголд нээлттэй бүртгэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хяналтын сонсголыг Төрийн ордонд зохион байгууллаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, сонсголын ирц бүрдсэн бөгөөд сонсголд Хууль зүйн байнгын хорооны гишүүдээс гадна бусад Байнгын хороодын гишүүд оролцлоо.

Сонсголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна төрийн байгууллага, албан тушаалтан 37, иргэн, хуулийн этгээд 85, цахимаар оролцогч 2, ажиглагчаар оролцсон 2 иргэн оролцож нийт 126 оролцогч хамрагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-д заасны дагуу сонсголыг нээлттэй явуулсан бөгөөд хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах, тэдний сонсголд оролцох, ажиглах боломжийг хангаж МҮОНРТ болон парламентын шууд дамжуулах суваг, Tenger TV, NTV, Ийгл, ТМ зэрэг сувгуудаар, мөн 14 цахим хуудсаар сонсголыг дохионы хэлмэрчтэй олон нийтэд шууд дамжуулж хүргэлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-д заасны дагуу эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандалтаас ангид байх эрхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хийсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлтийг танилцуулснаар хяналтын сонсгол эхэлж, холбогдох чиг үүргийн байгууллага, албан тушаалтан мэдээлэл танилцуулсан.

Тухайлбал, эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүү шүүлт шүүлт болох гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг Улсын ерөнхий прокурор, Эрүүдэн шүүх гэмт хэргийн шүүхийн шийдвэрлэлт ба гэмт хэргийн улмаас хохирогч учирсан сэтгэцийн хор уршгийн зэрэглэлийг тогтоох нөхөн төлүүлэх талаарх хууль тогтоомжийн хэрэглээ, шүүхийн практикийн талаарх мэдээллийг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын ажлын албанаас тус тус танилцуулж, мөн Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагад хүний эрх, эрх чөлөөг зөрчих, дүрмийн бус харилцааны талаар

гаргасан гомдол, мэдээллийн шийдвэрлэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрөлжсөн асрамжийн газарт амьдарч байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн эрхийн хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлж байгаа байнгын асруулагчийн эрхийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Эрүүл мэндийн яам тус тус танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.4-д заасны дагуу сонсголд нийт 41 оролцогч санал, дүгнэлтээ илэрхийлж, Улсын Их Хурлын гишүүд, холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнуудаас асуулт асууж, хариулт авлаа.

Хууль зүйн байнгын хороонд дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулсан хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх эрхийн хэрэгжилт” Улсын Их Хурлын хяналт шалгалтын сонсголын үеэр Улсын Их Хурлын гишүүд болон оролцогч дараах санал, дүгнэлтийг гаргасныг нэгтгэн танилцуулж байна.

1.Хяналт сонсголын үр дүн хөндөгдсөн асуудлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сонсголоор хөндөгдсөн асуудлыг шийдвэрлэх арга замын талаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах.

2.Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг барагдуулах асуудлыг нарийвчлан зохицуулах үүднээс авлига, албан тушаал, ашиг сонирхлын гэмт хэргийн улмаас хураагдсан хөрөнгүүдийг хохирол барагдуулах ажиллагаанд зарцуулах.

3.Шүүхийн шийдвэр гарахаас өмнө учирсан ямар ч төрлийн хохирлуудыг тэргүүн ээлжид барагдуулж болох асуудлыг хуульд тусгах буруутай этгээдээс гаргуулдаг байх зэрэгтэй холбоотой асуудлаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах.

Эрүүдэн шүүхийн конвенцын орчуулга, агуулга, нэр, томъёог нэг мөр болгох. Улмаар 2015 оны Эрүүгийн хуулийн эрүү шүүлт болох гэмт хэргийн шинжийг тодорхой болгох.

4.Засгийн газрын хүний эрхэд суурилсан хүний эрхийн мэдрэмжтэй, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Гэр бүлийн хууль зэрэг хууль тогтоомжийг яаралтай боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх талаар чиглэл өгөх, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн талаар цогц судалгаа хийж, шаардлагатай тохиолдолд хуульд нэмэлт оруулах асуудлыг судлан шийдвэрлэх.

5.Шүүх шинжилгээний байгууллагын тоног төхөөрөмж, хүний нөөц, төсөв, санхүүжилт, чиг үүргийн талаар Засгийн газрын бодлогын арга хэмжээ авах талаар Засгийн газарт чиглэл өгөх. Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт

оруулах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг гадаад улстай байгуулах. Ялангуяа Монгол Улсын иргэд олноор амьдарч байгаа улс орны хувьд иргэдийнхээ амь нас, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр Засгийн газрын бодлогын арга хэмжээ авах талаар Засгийн газарт чиглэл өгөх.

6.Эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий хандах, хүний эрхийг хангах чиглэлээрх судалгаа мэдээллийг холбогдох байгууллагад нарийвчлан гаргах, улмаар холбогдох мэдээллийг Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороонд ирүүлж шаардлагатай тохиол, тохиол. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдтэй уулзалтыг тогтмол зохион байгуулах. Албан үүргээ гүйцэтгэх явцад иргэдийг эрүүдэн шүүсэн, хүнлэг бус, хэрцгий хандсан, хүний эрхийг зөрчсөн албан тушаалтнуудын талаарх жагсаалт үүсгэх, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу арга хэмжээ авч чангатгах, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд бие биеэсээ хянадаг, шалгадаг одоогийн бүтэц тогтолцоог өөрчлөх асуудлыг судлан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах.

7.Улсын Их Хурлаас эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий хандах, хүний эрхийн хэрэгжилтийн асуудлаар цогц хянан шалгах, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд хууль, тогтоомж нэмэлт, өөрчлөлт оруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллах зэрэг болно.

Мөн энэхүү санал, дүгнэлттэй холбогдуулан Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулж та бүхэнд тараасан байгаа болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Та бүхнийг танилцуулга болон тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүнд баярлалаа. Тогтоолын төсөл болон хяналтын сонсголын тайлан, санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Тусдаа. Та ичихгүй бол өөрөө өөрөөсөө асуугаад үз дээ. Тэмүүжин гишүүн, Алтанхуяг гишүүнээр тэгвэл тасаллаа. Алдаржавхлан гишүүн, ингээд Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Минийх асуултаас гадна бараг горимын санал болчхоод байна дарга аа. Бид нар эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн асуудлаар сонсгол хийсэнтэй холбоотой бас тогтоол гаргах гэж байна л даа. Тэгэхээр энэ тогтоолыг гол хэрэгжүүлэх хүмүүс маань Засгийн газар байдаг. Хүний эрхийн комисс энд бас чухал үүрэг, рольтой байдаг. Ялангуяа эрүүдэн шүүх ажлууд хийгдэж байгаа гэх хууль сахиулах байгууллагуудын бас төлөөлөл юмнуудаас энэ Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбоотой асуух асуулт байгаад байдаг. Ер нь энэ шинэ дэгд өөрчлөлт оруулж, Хууль зүйн сайдыг Хууль зүйн байнгын хорооны хуралд оруулдаг байх, гишүүн болгохгүй бол энэ болохгүй байгаад байна. Бид нар одоо нэг гишүүн нөгөө гишүүнээсээ ийм бодлогын асуудлаар асуугаад тэгээд шийдвэр гаргах гээд байгаа байхгүй юу. Тэгтэл Хууль зүйн сайд байхгүй байгаад байдаг. Тэгэхээр энэ асуудлыг ер нь Хууль зүйн сайд, харьяа байгууллагуудыг байлгаж байж ярихгүй бол бид нар ажил хэрэгч биш болох гээд байна. Сонсгол хийж хийчхээд яг шийдвэрээ гаргах болохоор ингээд бид нар ямар Сайнзориг гишүүнээсээ асуулттай биш. Сайнзориг гишүүн бол

сонсголыг бол маш сайн амжилттай зохион байгуулсан. Би өглөөнөөс авхуулаад дуустал нь сонсголыг бол яг бүтэн үзсэн. Сонсголыг Сайнзориг гишүүн бол маш сайн зохион байгуулсан.

Тогтоолын төслийн хувьд бол ч гэсэн 2023 оны 11 сард Улсын Их Хурал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлд Улсын Их Хурлаас бүр бүтэн 3 хуудас тогтоол гаргасан юм. Засгийн газарт үүрэг өгсөн. Тэгэхээр тэрний хэрэгжилтийг хамт үзэхгүй бол жишээлбэл 3 дахь, 1-ийн Б, В, Д гэсэн заалтууд тэр Их Хурлын тогтоолд жишээлбэл байгаа. Одоо харин хэрэгжилт нь юу болов гэдгийг үзэх чиглэлд бас тодруулах юмнууд гараад байна л даа. Тэр бол маш том тогтоол гаргасан шүү дээ Улсын Их Хурлаас ноднин яг жилийн өмнө. Тэгээд бүр тодорхой деталь үүрэг өгчихсөн. Тийм учраас энэ асуудлыг саяын хэлсэн бүрэлдэхүүн байлгаж байж асууж, хариулж ярилцахгүй бол маш тийм ажил хэрэгч бус байна гэж хойшлуулах горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Энэ ийм шүү дээ. Энэ хүртлээ явахдаа нөгөө асуудаг бүх газруудаасаа бид нар асуугаад. Энэ чинь яг манай Байнгын хорооны өөрийнх нь бүрэн эрх. Харин тэр сайд байхгүй байгаа бол үнэхээр би энэ дээр санал нэг байгаа юм. Тэгээд энэ Шинэ дэгийн хуулиар чинь ингээд байхгүй болгочихсон юм байна лээ. Бид нар энийгээ засаж янзлахгүй бол бодит байгаа, үйлчилж байгаа хууль маань л ийм. Энэ горимын саналыг би бол хүлээж авмааргүй байна. Хэлэлцээд яваад дуусгахгүй бол. Эсвэл сайдаа дуудаж болно. Сайдыг ирж оролцооч гээд уриад болж байна. Урьчих. Түүнээс бол энэ чинь яг манай энэ Байнгын хороогоороо л ингэхийн тулд тэр сайд, яам, бүх юмыг нь оролцуулж байгаад бид нар дүгнэлт юмнуудаа гаргасан байж байгаа шүү дээ. Тэгэхээр одоо бол тэгж бид нар хойшлуулаад хэрэггүй байх. Саналаа хураагаад хэлэлцээд явах нь зөв. Таны хэлж байгаа жишээлбэл сайдад хандаад хэлэх юмнуудыг одоо уриад хэрэв ирж амжихгүй байсан ч бид нар Их Хурал бол үүрэг даалгавраа харин өгөөд одоо энэ дээр ч гэсэн бид нар протоколдоо тэмдэглэж байгаад цаашаа чиглэл өгөөд явж болно шүү дээ.

Таны түрүүний асуусан тэр нөгөө ноднин гаргасан, жилийн өмнө гаргасан тогтоолын дагуу бол Хууль зүйн байнгын хорооноос яг энэ хэрэгжилтийн талаарх бичиг бид нар явуулчихсан байгаа. 10 сарын 17-ны өдрөөр огноолсон бичиг Хууль зүйн яам руу явчихсан байж байгаа. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Нэгэнт горим гаргасан чинь үнэн үнэн. Санал хураая. Энэ асуудлыг хойшлуулъя гэх үү. Үгүй ээ үгүй, тэрийг чинь бид нар байлцуулаад сонсгол юмаа хийчихсэн байхгүй юу. Тэгэхээр чинь тэр тогтоолын төслөө бид нар эндээ боловсруулаад оруулж ирсэн. Сонсгол даргалагчаасаа асууж болох байхгүй юу. Тэгэхгүй тэр хүмүүсийг чинь ахиж авчраад яг тэгвэл тэр сонсгол чинь явах гэж байна шүү дээ. Тэгэхээр ажил чинь өөрийн дэс дараатай, шат шатаараа л явна шүү дээ сайд аа. Тэгэхээр би бол энэ дээр хойшлуулахгүй гэсэн саналтай байна. Тэгээд энэ асуудлыг хойшлуулах горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 26,7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Тийм учраас асуудлаа цаашаа хэлэлцээд явъя. Түрүүн үг хэлье гэсэн гишүүдийн нэрсийг энэ чинь дахиж гарахгүй юу тээ. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Тогтоолын төсөл дээр нэг асуулт байна. Энэ нөгөө шүүх шинжилгээний байгууллагын тоног төхөөрөмж, хүний нөөц, төсөв санхүүжилт, чиг үүргийн талаар Засгийн газраас бодлогын арга хэмжээ авч ажиллах гээд. Тэгээд би энэ сонсгол дээр бол энэ шүүх шинжилгээний байгууллагын чадавхын асуудал нэг их төдийлөн яригдаагүй шиг санагдаад байдаг. Тэгээд эрүү шүүлттэй холбоотой асуудал маань бас энэ яг яаж холбогдож байгаа билээ гэдэг нэг асуулт.

2 дахь нь энэ тогтоолын 2 дугаар хэсэг дээр эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах гээд. Энэ хохирогчтой холбоотой тусдаа дахиад ажлын хэсэг гарах уу. Тэгж ойлгоод ер нь хохирогчтой холбоотой өөр газар, тогтоол дээр ерөөсөө дурдаагүй байсан. Тэгэхээр энэ 2-ыг тодруулаад асуучихъя.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: 2 дахиас нь хариулъя. Ер нь бол яг таны хэлж байгаа сүүлийн асуулт бол яг зөв. Энэ дээр бас нөгөө хохирогчдын нэг холбоо бол гараад ирсэн байгаа юм. 47 хүн байна гэж байгаа. Тэгэхдээ эдгээр 47 хүний яг статусыг би бол хараахан хэлж мэдэхгүй байгаа юм. Зарим нь бол эрүүдэн шүүх гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй гэж өөрийгөө үзэж байгаа хүмүүс байх шиг байгаа юм. Зарим нь бол болсон гэдэг нь бүр шүүхээр тогтоогдчихсон хүмүүс байх шиг байгаа юм. Тэр дундаа үүнээс ажил амьдралаа алдаад, төрөөс хохирлоо барагдуулах арга хэмжээг авах гээд хөөцөлдөөд явж байгаа хүмүүс бас байх шиг байгаа юм. Ийм ер нь хүмүүсээс бүрдсэн бас ийм асуудлууд байна. Тэгэхээр эдгээрийг ерөнхийдөө авч үзэж бас Хүний эрхийн дэд хороо дээр бас ажлын хэсэг гаргах уу гэдэг зүйлийг бас ярьж болох юм гэдэг зүйлийг би тэр бас сонсголын үеэр өгч байсан. Тэгэхээр яах вэ, үүнийг бол бид хэд бас ингээд тавьсан гэдгээ хэлье.

2 дугаарт яах вэ, эхний асуулт буюу шүүх шинжилгээний байгууллагын асуудал хөндөгдсөн. Эргээд энэ гэмт хэргийг шийдвэрлэхэд нотлох баримтыг яг цуглуулах, үнэлэх, шинжлэн магадлахад хамгийн чухал асуудал бол энэ шүүх шинжилгээний байгууллага байгаа. Энэ нь өөрөө эргээд энд аль ч гэмт хэрэг дээр гарсан асуудлаасаа эхлээд яг энэ эрүү шүүлт болсон уу, эрүүл мэнд бие махбодын хохирол үзүүлсэн үү, эргээд энэ цаашдаа бас олон асуудлууд ярьж болно. Дээрээс нь яг энэ эрүү шүүлтийн гэмт хэрэгт учирсан хүмүүсийн сэтгэцэд учирч байгаа хор уршгийг үнэлэх асуудал шүүх шинжилгээний байгууллага хийж байгаа юм. Энэ дээрх тоног төхөөрөмж, хүний нөөц байхгүй бол энэ асуудал шийдэж чадахгүй л байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлыг ер нь анхаарахгүй бол бид хэд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа хүмүүсийн хамгийн их бүтээмжийг сайжруулах институц болох шүүх шинжилгээний буюу энэ байгууллагыг цаашдаа анхаарч тоног төхөөрөмжийг орчин үеийн байдлаар шийдэхгүйгээр хэн нэгнийг бас хэлмэгдүүлж болно. Эсвэл хэн нэгэнд ял завшуулах боломжийг олгож болзошгүй гэдэг зүйлүүд бас ер нь бол хөндөгдсөн. Бас асуулт хариултын үед явсан. Би өөрөө бас энэ чиглэлд нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг санаачлах гээд бэлдээд өнөө маргаашгүй бас Засгийн газраас санал авах гээд ингээд байж байгаа ю. Ер нь бол нэн тэргүүний асуудал нь ийм төрлийн гэмт хэрэгт хохирогч болсон хүмүүсийн хохирлыг тус сангаас ядаж тодорхой эмчилгээний зардлаас нь эхлээд барагдуулчихдаг, тэрийг нь буруутай этгээдээс нь авдаг том агуулгаараа тэр сэтгэцэд учирч байгаа хор уршгийг нь шүүх үнэлээд гараад ирсний дараа ингээд энэ сангаас төлөх ийм

нөхцөл байдал энэ тэрийг бас шийдээд явъя гэсэн ийм агуулга бас цаана нь яригдаж байгаа шүү гэдэг зүйлийг бас танд хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Бид нар энэ сонсгол хийгээд, тэгээд 1 тогтоол гаргаад орхиж болохгүй байх. Ингээд тогтоол гаргаснаар, сонсгол хийснээр энэ чиглэлийн гэмт хэрэг гарахгүй, асуудлыг шийдчихлээ гэж ойлгож болохгүй байх. Тийм учраас энэ тогтоолоо маш сайн сонсгол хийсний гол учир утга, агуулгыг л гаргаж ажилламаар байгаа юм. Тэгээд тэрний хэрэгжилт нь бол энэ тогтоол болох ёстой. Тэгээд сонсголын үеэр хэлж байсан 2 асуудал маань бас орсон байна.

Нэгд өнөөдрийн манай энэ хууль хүчний байгууллагуудын бие биеэ хянаж шалгаж, цагддаг байгаа асуудал. Энэ тогтолцоог өөрчлөх асуудлыг бас эргэж харах асуудлыг хууль зүйн хүрээнд нь тусгасан байна. 7 жилийн дотор 14 гэмт хэргийг бүртгэж шалгасан байгаа нь өөрөө энэ хууль хүчний байгууллагууд бие биеэ хянаж шалгах 14-ийнх нь бараг 8, 9 нь бараг торгуулийн ял өгсөн байх жишээтэй. Тэгэхээр хууль хүчний байгууллагууд бие биеэ өмгөөлж байна. Хамгаалж байна. Эцсийн үр дүн цаана нь хохирогч нар хохироод үлдэж байна гэдэг ийм асуудал гарахаар байгаа. Тийм учраас энэ асуудлыг эргэж харах, хууль, эрх зүйн хүрээнд нь өөрчлөлт хийх асуудлыг оруулсан нь бас болж байна.

2-т энэ гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх гээд тэр сонсгол дээр чинь ирсэн хүмүүс бол үндсэндээ бас л ер нь голцуу хохирогч болсон хүмүүс ирээд харагдаж байна лээ шүү дээ. Тэр асуулт, үг хэлэх, хэлсэн хүмүүсийн хүрээнд бол. Тийм учраас тэр хүмүүсийн хүрээнд бас хууль зүйн ойлголт их багатай юм шиг байдаг юм шиг харагдсан зарим нэг нь. Тэгэхээр хууль зүйн үнэгүй зөвлөгөө өгөх асуудлыг бас энэ тогтоолын тэр 2-т сүүлийн 2.2-т хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр гэсэн энэ хэсэгтээ оруулж өгвөл зөвхөн эд хөрөнгө, эрүүл мэнд, нийгмийн сэтгэл зүйн гэхээсээ илүүтэй бас хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх асуудлыг энэ ажлын хэсэг дээр тэр хүмүүсийг бүр дуудаж уулзаж, тэр санал хүсэлтийг нь сонсож, зовлон бэрхшээлийг нь сонсож, хүн ёсоор үзэж, ерөөсөө энэ хүмүүс чинь дээшээ тэнгэр хол доошоо газар хатуу гээд хэнд хандахаа мэдэхгүй аргаа барчихсан, ядсан хүмүүс л энд ирсэн байна лээ шүү дээ. Тэр сонсгол дээр. Хүлээж авдаг хүн байхгүй. Төрийн байгууллага байхгүй. Сонсдоггүй. Ингээд байгууллагынхаа үүднээс гаргачихдаг. Тийм учраас энэ хүмүүст төрийн байгууллага сонсдог, зовлонг нь сонсдог, аргачлалыг нь зааж өгдөг, хууль зүйн зөвлөгөө өгдөг ийм .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд асуух уу. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр энэ хоёртоо бас тэр асуудлыг тогтоолынхоо төсөлд бас оруулж өгөөч Сайнзориг дарга. Хууль зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх гэдэг дээр ороогүй байна. Тийм учраас энэ чиглэлийн санааг маань оруулж өгөөд тогтоолдоо тусгаж өгөөч ээ. Тэгэхгүй бол энэ хүмүүс чинь нэг л их төр засагт гомдсон хүмүүс яваад байгаа байхгүй юу. Сонсохгүй байна. Бид нарын үгийг сонсохгүй байна гэдэг хамаг их гомдол нь яваад байдаг юм шиг санагдсан. Тийм учраас энийг ёстой хүн ёсоор нь, гэр бүлээр нь, ах дүүсээр нь хүлээж авч уулзаж, сонсож байгаад баярлалаа л гээд байна лээ шүү дээ тэр хүмүүсийн чинь үгэнд. Хамгийн эхэлж л өнөөдрийн сонсголыг хийж байгаад. Тэглээ гээд тэр хүмүүсийн

асуудал шийдэгдчихээгүй. Тэгэхээр зүгээр нэг сонсгол хийгээд өнгөрөх биш, нэг тогтоол гаргаад өнгөрөх биш. Сая Энхбаяр гишүүн ярьж байна шүү дээ. Өмнө нь бас нэг бус удаа энэ асуудлуудаар тогтоол гарч байсан. Түүний хэрэгжилт юу болсон тэрийг .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Энд бас нэг хариулт тайлбар өгье.

П.Сайнзориг: Манай Сандаг-Очир гишүүн бас зөв өнцгийг ярьж байгаа юм. Гол асуудал яг л энэ л байсан. Тэр 47 хүний асуудал дээр зарим нь хууль зүйн туслалцаа аваад явж байгаа хүмүүс маань шүүхийн процесс дээр чинь удааширч байгаа. Нотлох баримтаа нөгөө гаргуулж авч чаддаггүй. Жишээ нь тэр Зориг агсны хэрэг дээр яваа хүмүүс бол нотлох баримт энэ тэр гаргуулаад авъя гэхээр хэрэг нь нууцаас гарсан гээд байгаа мөртөө авч чадахгүй байна гэдэг зүйлийг жишээ нь ярьж байгаа. Гэхдээ хэрэг нь нөгөө зарим хүний хэрэг тусгаарлагдаад хавтаст хэрэг жишээ нь Төв аймгийн шүүх дээр байгаа учраас одоо хүртэл тэр процедурыг гүйцээж хийж чадахгүй л байгаа байхгүй юу. Ерөөсөө л ийм.

Зарим нь бол үнэндээ хэлэхэд бас учраа олохгүй яваа хүмүүс байна. Тэгэхдээ би энийг нэг ярих гэхээр Засгийн газарт чиглэл өгөх тогтоолуудыг хийж болно. Үүний цаана дандаа хүний нөөц, төсөв л яригдах гэж байна. Бид хэд ингээд сая төсөв батлахдаа хууль зүйн салбараас зарим хэрэгцээтэй зүйлүүдийг нь бас бодолцоогүй л явчихсан байж байгаа. Энэ Хууль зүйн туслалцааны тухай хуулийг манай өмнөх парламент баталж өгсөн. Сандаг-Очир гишүүн эд нар сайн мэдэж байгаа. Дэмжиж баталж өгсөн хүмүүсийн нэг. Энэ дээр бид нар зөвхөн сэжигтэн, яллагдагчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй өгдөг байсныг хохирогч, зарим төрлийн хохирогчид бас нэмэгдүүлсэн, зарим төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд бас үзүүлж байгаа. Гэхдээ гол шалгуур маань төлбөрийн чадваргүй байх. Гэхдээ зарим зорилтот бүлэг ахмадууд, зарим үнэхээр юу гэдэг юм. Бас ээж, аав нь өөрөө үр хүүхдийнхээ эсрэг явчихаар төлбөрийн чадвартай эсэхээс үл хамаараад бас үзүүлэх ч гэдэг юм уу ийм зүйлүүд байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг бол тусгаад явахад бол татгалзах зүйл алга. Зүгээр Засгийн газар яг ямар институцээр хийж болох вэ. Тэгэхдээ заавал энийг төрийн байгууллага дээр чиг үүргийг шавж нэмэгдүүлэх гэхээсээ илүүтэйгээр Монголын хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоотой хамтран зохион байгуулах, нийгмийн хариуцлагын хүрээнд хуульчдын гүйцэтгэх ёстой хуульд заасан үүргийг хангуулахтай холбоотойгоор явах ёстой. Тэгэхдээ энэ их эмзэг асуудал. Нарийн юман дээр бас мэргэшсэн хуульчид бас зөвлөгөө өгөхгүй бол зүгээр ерөнхий байдлаар нэг хуульчдын нийгмийн хариуцлагын хүрээнд ингээд хаяхад бас их хэцүү. Тэгэхээр энийгээ бодолцоод ер нь бол бас таны хэлж байгаа шиг хүлээгээд авдаг, зам жимийг нь хууль, эрх зүйн талаасаа гаргаад өгчихдөг ийм институц байх нь зөв. Энийг бол тусгаад явах нь асуудал алга.

Хэдүүлээ яг ийм гэмт хэргийн хохирогч болсон хүмүүст хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй өгөх асуудлыг шийдвэрлэх хууль, эрх зүйн орчныг судлах, цаашдаа Монголын хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоотой хамтран ажиллах бололцоог эрэлхийлэх гээд ингээд ерөнхий агуулгыг нь багтаагаад оруулчаж болж байна. Би энэ дээр бол татгалзах зүйл алга байна. Бас чухал санал байна гэдэг зүйлийг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Ер нь Сандаг-Очир гишүүний түрүүний хэлсэнтэй агаар нэг. Сонсгол ингээд өглөөнөөс орой хүртэл болсон. Юуны өмнө бас Сайнзориг гишүүнд талархал илэрхийлье. Бас их амаргүй сонсгол болсон. Яагаад гэхээр маш олон төрлийн эрх ашиг нь хөндөгдсөн, маш олон асуудалтай хүмүүс нэг зэрэг ороод ирчихсэн. Энд ч нэг вакцины хүмүүс, энд ч нэг гээд маш олон төрлийн зүйл байсан. Тэгээд энэ сонсголоос бол нэг ийм хүлээлтүүд үлдчихсэн байгаа. Тэгээд бас би Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх Золжаргал эд нартай ярьж байгаад тухайн үед эрүүл мэнд ба хүний эрх гэсэн сэдэвтэй дахиад сонсгол хийх ёстой юу гээд ярьж байгаад энэ маань Бейсен гишүүний ахалж байгаа Байнгын хороо руу явчих шиг боллоо. Тэгээд нөгөө сонсголынхоо тухай журмаараа бол нэг Байнгын хороо эд нар гээд лимит байдаг юм байна шүү дээ. Одоо сонсгол хийх тийм ээ. Хяналтын сонсголын, ерөнхий сонсголын гээд тодорхой тоонууд байдаг учраас бид нар энэ сонсголоос хүмүүст бол маш их хүлээлтүүд үлдчихсэн байгаа. Тэр энэ дээр тухайн үед илэрхийлж байсан Сайнзориг гишүүнээ нөгөө ийм асуудлуудыг ярьсан шүү дээ. Нөгөө 47 хүнтэй Энхбат гээд тэр даргалж байгаа хүн нь ярьж байсан. Энэ нөгөө төрийн өндөр албан тушаалтнууд улс төрд нөлөө бүхий хүмүүсийн захиалгаар эрүүдэн шүүх биш ээ, эрүүдэх процессууд болсон гэдэг талаарх маш их өргөдөл, гомдлууд дээр тухайн үед яригдаж байсан. Мэдээж энд бол хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэл болон тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл гэдэг бол бололцооны сайн орчихсон байна. Яг энэ дээр жишээлбэл ямар нэгэн байдлаар тусгах боломж байсан уу. Тэр шууд мэдээж тэрийг томьёолох нь хэцүү л дээ. Одоо юу гэдэг юм, улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон төрийн өндөр албан тушаалтнууд ингэж болохгүй гэж хэлэх нь утгагүй. Гэхдээ тэнд маш олон удаа давтагдаж гарсан зүйл байсан учраас энэ дээр ямар нэгэн байдлаар энэ тогтоолд тусгах шаардлагатай юу, үгүй юу. Би бас сайн хэлж томьёолж мэдэхгүй байна. Гэхдээ энийг бас ингээд хэдүүлээ мартаад өнгөрчхөж болохгүй байх. Эсвэл дотор нь процесс дотор нь оруулаад явах юм уу. Энэ дээр та байр сууриа хэлээч.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Тогтоолын төсөл дээр бол эрүүдэн шүүх гэмт хэргийн шинжийг тодорхой болгож олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх асуудал байгаа юм. Энэ хүрээндээ яг энэ гэмт хэргийг хамтран үйлдэх этгээдийн нэг нь өөрөө захиалагч буюу тодорхой чиглэл өгч байгаа төрийн өндөр гэдэг юм уу эсвэл хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд байж болно. Яг тодорхой би кэйсийг бол ярьж чадахгүй. Өөрөөр хэлэх юм бол энийг шүүхийн асуудал. Шүүх л гэм буруутай нь тогтоогдож үнэхээр ийм захиалга өгсөн, өгөөгүйг тогтоох байх. Зүгээр ийм зүйлүүд гарсан, эсвэл цаашдаа гарахаас урьдчилан сэргийлээд гарсан этгээдэд нь бас ял хариуцлагыг нь зохистой буюу шударга ёсонд нийцүүлж өгөх асуудлын хүрээнд бол энэ гэмт хэргийн шинжийг тодорхой болгох гэдэг дээр хүндрүүлэх бүрэлдэхүүн дээр магадгүй улс төрд нөлөө бүхий этгээдүүд өгсөн, эсвэл хууль сахиулах байгууллагын өндөр албан тушаалтнууд өгсөн ч гэдэг юм уу ийм зэргээр хууль сахиулах байгууллагын өндөр албан тушаалтан гэж ярихгүй. Хууль сахиулах байгууллагын удирдах албан тушаалтнууд өгсөн бол гээд бас шийдэж, тодотгож болно. Тэгэхээр агуулгын хувьд бол орсон. Бид хэд бас яах вэ зүгээр Засгийн газарт өгч байгаа энэ чиглэлээ бас ер нь тэгж ойлгох хэрэгтэй. Гэмт хэргийн шинжийг тодорхой болгох гэдэг бол цаашдаа үндсэн бүрэлдэхүүнээсээ гадна хүндрүүлэх бүрэлдэхүүн дээр ч гэсэн бас бодож, ял хариуцлагыг бас оновчтой

оруулж ирэх ёстой гэдэг зүйлийг чиглэлийг бол багтааж энэ агуулгын хувьд өгсөн гэдэг зүйлийг би танд бас тайлбарламаар байна.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Энэ яах вэ, нөгөө Цогтбаатар дарга бас өөрөө 2 ч удаа өмнө нь энэ санааг хэлж байсан л даа. Нөгөө юу гэдэг юм хүнийг хэлмэгдүүлсэн бол тийм ээ, хүнийг хэлмэгдүүлсэн бол тэр хэлмэгдүүлэх зүйл дээр захиалга өгсөн ч гэдэг юм уу, гүтгэсэн ч гэдэг юм уу тэр санкц нь өөрөө бараг нөгөө тухайн хүн нас барчихсан байхад ч гэсэн хөөн хэлэлцэх хугацаа нь дуусахгүй байна энэ тэр гээд санаа хэлж байсан шүү дээ. Тэгэхээр энэ нь бол нөгөө эртээрийн сонсгол дээр ч гэсэн тэр 47 хүний төлөөлөл болж байгаа хүмүүс маш олон дахин ярьж байсан. Тэгэхээр таны хэлж байсан энэ санаа жишээлбэл одоо яг ийшийгээ тусгагдаад явах юм уу. Энэ чинь бие даасан хууль байх гэхээс илүүтэйгээр тодорхой нөгөө процессын хууль дотор орох юм байгаад байгаа юм. Тэгээд энэ дээрээ энэ тогтоол дээрээ энэ санаагаа жишээлбэл уялдуулаад явах юм уу. Яах юм гэдэг санааг л хэлэх гээд байгаа юм. Энийг би Сайнзориг гишүүнээс гэхээс илүүтэйгээр Байнгын хорооны даргаас асуучихъя.

Д.Цогтбаатар: Үгүй ээ, би бол өөрийнхөө байр суурийг маш тодорхой хэлж байгаа шүү дээ. Энэ улсад эрүүдэн шүүх асуудал байгаа, байсаар байна. Энэ яригдсаар байна гэдэг бол өөрөө маш ичгүүртэй асуудал. Тэгэхдээ ингээд асуудлаас ичиж байна гээд улс төржөөд гарч болохгүй. Энийг таслан зогсоох ёстой. Тийм учраас энэ тогтоол эд нар дээр энэ асуудлууд маш тодорхой орох ёстой. Хүнийг захиалаад ямар нэгэн үүрэг даалгавар өгч байгаад хэлмэгдүүлнэ гэдэг бол өөрөө ноцтой гэмт хэрэг. Би ялынх нь хэмжээг тэр Монгол Улсад байдаг хамгийн дээд хэмжээнд нь тулгаж өг гээд байгаа шүү дээ. Авлигачдад 20 жил өгөөд байгаа бол хүнийг хийгээгүй хэргийнх нь төлөө хилс хэрэгт хамруулна, тэгээд захиалж хийлгэнэ гэдэг чинь бүр Монгол Улсад байх ямар ч гэмт хэргээс маш том хүнд гэмт хэрэг байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлууд сая Сайнзориг гишүүн хэлж байна. Энэ санаанууд бол агуулгаараа тусаад орсон байгаа гээд. Энийгээ тэгээд миний бол ярьж байгаагаар Хүний эрхийн дэд хороо хариуцсан даргын хувьд Эрдэнэболд гишүүн өөрт чинь би бас хэлж байгаа. Урьд нь би Одонтуяа гишүүнд энэ цагаатгах комиссын даргынх нь хувьд хэлж байсан. Ийм хууль санаачлаад оруулах ёстой байхгүй юу. Түүнээс энэ бол тогтоолоор шийдэгдэх асуудал биш. Энэ чинь өөрөө маш ноцтой асуудал байгаа учраас би бүр тэр дээр нарийн зохицуулалтуудыг нь хүртэл гүйцээгээд яриад байгаа шүү дээ. Тэгэхээр 1 тогтоолд орох төсдийгээр энэ бол шийдэгдэх асуудал биш. Үзэл санаа нь бол ороод явж байх ёстой сая Сайнзориг гишүүн ярьж байна. Тэр нь бол цаашаа ороод явж байх ёстой.

Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Сонсголын үр дүнд гарч байгаа, холбогдох арга хэмжээний тогтоол дээр 2 асуулт юм уу, санал байна. Түрүүн бас зарим хүмүүсийн асуулттай давхацсан учраас.

1 дүгээрт яах вэ тэр сонсгол дээр бүтэн суусан л даа. Ер нь бол бүгдийнх нь санал бодлыг сонссон. Тэнд түрүүн яг манай гишүүдийн хэлж байгаа үнэхээр аргаа барьчихсан хүмүүс бол ирсэн байсан. Тэгээд тэд нарын ярьж байгаа юм бол

1 дүгээрт нөгөө хохирлоо бид нар ерөөсөө төлөвлөж барагдуулж чадахгүй байна. Яаж яахаа мэдэхгүй байна гээд. Түүнтэй холбоотой асуулт асуух ч гэсэн үнэндээ гэмт хэрэг зөрчлийн хохирогчид төлөх тэр сангийн зарцуулалт эд нар бол үнэхээр хангалтгүй байгаагаа хэлж байсан. Тэгэхээр бид нар энэ эрүүдэн шүүх гэмт хэргийн хохирогч болсон хүмүүсийнхээ хохирлыг яаж барагдуулж байх юм бэ. Энэ нөгөө эрхээ сэргээлгэх процессыг нь яаж илүү энэ хүмүүст ээлтэй болгох юм бэ гэдэг дээр нь хууль, эрх зүйн зохицуулалтыг нь илүү боловсронгуй болгох шаардлагатай юм байна гэсэн уг нь бол дүгнэлт гарсан. Тэгэхээр энэ дээр номер нэг буюу энэ хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр яг энэ асуудлыг уг нь тодорхой тусгаад өгвөл их зүгээр юм уу гэсэн саналтай байгаа юм. Түрүүн яах вэ Сайнзориг гишүүн хэлж байна л даа. Яг энэ тусгай сангийн тухай хууль бичих гэж байгаа гээд. Тэр нь бол энэ дээр бас нэг их тийм тодорхой тусаагүй байгаа учраас энэ бол яг манай хохирогч иргэдийн хамгийн хүсэж хүлээж байгаа юм шиг байгаа юм. Тэгээд тэр нөгөө сэтгэцэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай хууль бол буцаан хэрэглэх боломжгүй юм байна гээд Дээд шүүхийн нэг тайлбар бариад, тэгээд эд нар боломжгүй байгаа учраас бид нар бас яах ёстой юм бэ гэдэг гарц гаргалгаа бол асууж байсан. Тэгэхээр энэ бүгдийг хараад ер нь бид нар хохирлыг барагдуулахдаа энэ хүмүүст эрх зүйн туслалцаа болон эрхээ сэргээлгэх энэ процессыг яаж ээлтэй байлгах тал дээр нэг ийм эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох чиглэлээр нэг юм байх ёстой юм болов уу гэсэн юм байна.

2 дугаарт, 2 дугаар хэсэг буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлээр гээд. Энэ дээр гол нь хохирлоо тэд нар хүмүүст төлчихлөө. Тэгтэл нөгөө хариуцлага тооцдог механизм яг энэ хэргээр гэмт хэргийн ял авч байгаа, эсвэл хариуцлага тооцогдож байгаа, эсвэл гомдол гараад прокуророос цаашаа шилжиж байгаа хүмүүсийн тоо нь маш тийм харьцангуй байсан л даа. Тэгэхээр энэ дээр яг тэнд бас хөндөгдөж байсан юм бол энэ төрлийн гомдол шийдвэрлэгдэхгүй байгаа нөхцөл байдал нь юу юм. Яагаад энэ хариуцлага тооцох механизм сайн бүрдэхгүй байна гэдэг дээр бас нэлээн бид хэд ярилцсан. Тэгээд энэ дээр бол нөгөө нэг жилийнхэн бүгдээрээ хуулийн байгууллагад байдаг. Танил тал байдаг. Тэгээд энэ хуулийн байгууллагын өөрийнх нь юм гээд энэ дээр мэдээж гүйцэтгэх ажиллагаа, цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэл гээд хуулийн юм дээр бас боловсронгуй болгоод Хууль зүйн байнгын хороонд ир гээд яачихсан байна. Гэхдээ яг энэ энэ дээр тусад нь тэр “ё” дээр болохоор эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх криминоги судалгаатай хамт хариуцлага тооцох шийдвэрлэгдэхгүй байгаа талаар хөндлөнгийн судалгааны байгууллагаар суурь судалгаа хийлгэх гэгчихсэн байна л даа. Тэгэхээр энэ 1 дүгээрт зүгээр тодруулмаар байгаа юм. Ямар учир шалтгаанаар суурь судалгаа гэж. Тэгээд урьдчилан сэргийлэх .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээх үү. Микрофоныг нь гүйцээгээд өгье.

О.Номинчимэг: Урьдчилан сэргийлэх криминоги судалгаа болон шийдвэрлэгдэхгүй байгаа буюу хариуцлага тооцож чадахгүй байгаа процесс явахгүй байгаа юмыг нийтээр нь хамтад нь ингээд нэг суурь судалгаа гэж орсон юм болов уу. Энэ дээр ер нь тэр сонсголоос бараг л учир шалтгаан нэлээн л тодорхой байх шиг санагдсан.

3 дугаарт бол яах вэ санал. Энэ 2 дээр Хүний эрхийн дэд хорооны даргаар ахлуулан ажлын хэсэг байгуулаад энэ хохирогчдод тулгарсан асуудал дээр бас

санал, дүгнэлт гаргуулъя гэж байгаа юм байна. Тэгээд үүнтэй холбоотой уг нь бас Тэмүүжин гишүүнээр ахлуулсан эрүү шүүлт тулгах гэмт хэрэгтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг байгаа юм. Би бас гишүүн нь. Тэгээд тэр дээр бас нэлээн их мэдээллээ сонсоод, хууль, эрх зүйн орчин тэр эрүүгийн ял, зүйлчлэл дээр Эрүүгийн хууль дээрээ бид нар яаж анхаарах ёстой юм. Механизмын хувьд яах ёстой юм гэдгээ ярьж байгаа юм. Тэгээд уг нь нэгтгэсэн бол бүр илүү чамбай болох байж уу гэж бодсон. Гэхдээ яах вэ тэр ажлын хэсгийн хурал дуусаагүй байгаа учраас мэдээж бид нар ингээд Байнгын хорооны тогтоолоо гаргах байх. Зүгээр тэр дээр бас яригдаж байгаа юмнууд энд давхар байгаа бол .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Эхлээд Сайнзориг гишүүн тэгээд. Дараа нь Баасанжаргал гишүүн бас хариулах нь зөв байх. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Судалгаа энэ тэр дээр бол манай Бааска гишүүн бас нэмээд хэлэх байх. Энэ тогтоолуудаас бас саналуудаа манай Байнгын хорооны гишүүд бас өгсөн. Тусгах боломжтой буюу тухайн үед хөндөгдөж байсан асуудлуудыг бол тусгаад явъя гээд би бол зүгээр хурал даргалагчийн хувьд ч шийдсэн шүү. Энийг бол та бүгд хамтаараа шийднэ. Юу байх, байхгүйг. Ингээд ер нь зүгээр тэр Шүүх шинжилгээний хуулийг дагаад бид нар Иргэний хуульд өөрчлөлт оруулсан. Сэтгэл санааны хохирол гэж ярьсаар байгаад сүүлдээ хохирол гэдэг үгнээсээ болоод гэмт хэргийн зүйлчлэл дээр нөлөөлөх гээд байсан учраас энэ чинь өөрөө эргээд шийдэгдэхгүй байсан байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол сэтгэцэд учирч байгаа хор уршиг тэр гэмт хэргийн хохирлыг шийдээд буюу тэр гэмт хэргийг шийдвэрлэсний дараа хэдэн жилийн дараа ч гарч болдог эд байхгүй юу. Тэгэхээр энэ чинь хор уршиг юм гэж байж шинжлэх ухааны буюу анагаахын шинжлэх ухааны нэр томъёонд бид хэд бас хүндэтгэлтэй хандаж, энэ шинжлэх ухааныг хүндэтгэх ёстой гэж байж өнгөрсөн парламент дээр нэлээн тулаан болж байж хууль зүйн салбарынхантайгаа гарч байж авсан. Тэгэхдээ хууль бол хэрэглээд явж байгаа юм байна лээ. Хэрэгжиж байгаа гэж байна лээ. Зүгээр цаашдаа анхаарч улам боловсронгуй болгох асуудал бол байна гэдэг зүйл дээр би бол энэ хуулийг хэрэгжүүлж байгаа, хэрэглэж байгаа байгууллагууд дээр бол төлөөллүүдтэй уулзахад хэлж байсан.

Тэр Дээд шүүхийн тэр тайлбар бол буруу. Би энэ хуулийг боловсруулж, батлуулах ажилд оролцож явсны хувьд бол энэ хууль буцаан хэрэглэх зарчмын асуудлыг зүгээр тодотгож өгөх юм бол байгаа. 1986 оны хууль, 2002 оны хуулийн дагуу сэтгэцэд учирсан, тэнд учирсан эрүү шүүлтийн гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирч байгаа хор уршигийн асуудлыг шийдвэрлэж болох уу гэж асуувал тэр дээр үлдээгээд буюу ойлгомжгүй орхигдсон юм бол байна. Энийг бол зохицуулаад явчих ёстой. Гэтэл энэ хууль маань үндсэндээ 2021 оноос хойш 2022 он оноос хойш байгаа шүү дээ. 2017 оноос хойш Эрүүгийн хууль хэрэгжээд эхэлсэн байгаа. 2017 оны 7 дугаар сараас хойш үйлдэгдсэн энэ нэр заагдсан гэмт хэргүүдийн улмаас үнэхээр эрүү шүүлт учирсан бол энийгээ сэтгэцэд учирч байгаа хор уршиг ч гэдэг юм уу энийгээ тогтоолгох боломжтой байхгүй юу. Дээд шүүх хүртэл ингээд худлаа хууль тайлбарлаад байхаар ерөөсөө ойлгохгүй юм. Тэр дээр бүр ингээд 2017 оны Эрүүгийн хуулийг эш татаад ийм ийм гэмт хэргүүд гээд заачихсан байгаа. Тэр гэмт хэргийн хохирогч болсон бол, эсвэл тэр гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирч байгаа хор уршиг байна гэх юм бол Иргэний хуулийнхаа ерөнхий зарчимд нэхэмжлэл гаргах, хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй, эсвэл бололцоотой

байвал явах, нэхэмжлэх эрх нь бүрэн байж байгаа. Гэтэл Дээд шүүх энэ дээр нугалаа гаргаад зөвхөн шүүх шинжилгээний хууль баталсан өдрөөс урагшаа, хойшоо байх ёстой гээд ингээд бас нугалаа гаргаж байгаа юм байна лээ. Би энийг бас хуульчдын холбооны өмгөөлөгч хэд хэдэн гишүүд надад тавихаар нь хуулийн анхны intention бол тийм байсан шүү. Энэ Дээд шүүхийн тайлбар бол буруу байна. Харин 2002, 1986 оны хуулийн дагуу гэмт хэргийн хохирогч болчхоод, тэндээс үүссэн сэтгэл санааны хохирлын асуудлыг ярих гэж байгаа бол орхигдуулсан байна. Би энийг бол хүлээн зөвшөөрч байна гэдэг зүйлийг би бас зүгээр энгийн мэтгэлцээний хувьд бид хэд ярилцаж байсан. Тэгэхээр энийг бол засаж залруулах уг нь заавал хуулиар биш. Уг нь Дээд шүүх маань бас шийдвэрээ бас эргэж хараад 2017 оны 7 дугаар сарын 1 буюу тэрнээс хойш шинэ Эрүүгийн хууль үйлчлээд явснаас хойш энэ нэхэмжлэлүүдийг авчихмаар байгаа байхгүй юу. Ингээд иргэдийг ерөөсөө ингээд чирэгдүүлдэг, бухимдуулдаг, хаана хандахаа мэдэхгүй байж байгаа юм чинь ерөөсөө л энэ болчхоод байгаа юм. Бусад тэр асуудал дээр нь Бааска гишүүн хариулах уу.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Өчигдөр би энэ Байнгын хорооны тогтоолтой холбоотой өөрийнхөө саналыг бас нэмж өгөөд, тэгээд зарим саналууд нь бол тусчихсан явж байгаа. Тэгээд ялангуяа нөгөө судалгаатай холбоотой зүйлийг 2 салгаж оруулсан юм. Нөгөө криминологи судалгааг нэг талаас нь хийлгэх, нөгөө талаас нь бас яг энэ суурь судалгааны асуудлууд нэлээн хөндөгдөх болов уу гээд. Яах вэ зүгээр бид нар сонсголын явцад таамаглах байдлаар бол нөхцөл байдлыг бол харсан. Гэхдээ энийг бол яг нөгөө шинжлэх ухааны үндэслэлтэй. Дээрээс нь тухайн үедээ сонсголд оролцож байсан зарим хүмүүс 6 удаа цагдаагийн байгууллагаас эрүүдэн шүүсэн байж болзошгүй гээд цагдаагийн байгууллагаас прокурорын байгууллага руу шилжүүлэхээр прокурор 6 удаа хэрэгсэхгүй болсон тогтоол гарч байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бид нар маш нухацтай авч үзэх ёстой. Яг нөгөө өнгөц шийдэгдсэн хэргийн хүрээнд авч үзэхээр цаана нь шийдэгдэхгүй байгаа гомдол гаргаад байхад процесс нь удаашраад байгаа ийм .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Х.Баасанжаргал: Тэгэхээр нөгөө зарим нэг зүйлийг шууд таамаглаад арга замыг эрэлхийлнэ гэхээс илүү бас яг энэ судалгаа дээр үндэслээд магадгүй манай Байнгын хорооны үйл ажиллагаа цаашаа үргэлжилж болно гэж харж байгаа. Тэгэхээр энэ судалгаанууд маш чухал юм болов уу. Дээрээс нь сонсголын үед криминологи судалгаатай холбоотой асуулгыг би бүх хуулийн байгууллагаас асуухад хэн нь ч ерөөсөө криминологи судалгааны талаар хариулт хэлээгүй. Тэгэхээр байхгүй. Бас хайж үзэхэд бол ер нь бол гарч ирэхгүй байгаа гэсэн үг.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Энэ ер нь их чухал сонсгол болсон л доо. Тэгэхдээ бид нар цаашдаа анхаарах 2 зүйл байгаа юм уу гэж би харсан. Манай Сайнзориг гишүүн нэг ийм эвтэйхэн эвийг нь олоод, зохицуулаад явуулчихсан.

1 дүгээрт бол одоо үүнээс хойш хяналтын сонсголд хуульд нь байна уу, үгүй юу би мэдэхгүй байна. Нэг их баахан төрийн байгууллагынхны хүмүүсийг үдээс өмнө хүртэл яриулаад л, залхаагаад л, энэ халуун өрөөнд авчирч нөгөө муу хэдэн

гомдсон хүмүүс чинь нойр нь хүрээд л. Тэгээд үдээс хойш нөгөө хэдийгээ яриулахаар нь цаг нь багтахгүй нэг ийм сонин юм болоод байгаа юм. Энэ төрийн байгууллагын хүмүүсийг авчирч сонсдогийг болимоор юм байна лээ. Тэр хүн чинь зовлон жаргал ярих гээд орж ирсэн. Тэрийг л шууд сонсох хэрэгтэй. Тэгээд дараа нь бид нар юмаа ярьдаг. Нэг ийм юм.

2 дахь нь хаа хамаагүй байгууллагын хүмүүс ингээд ороод ирчихсэн. Тэр асуудалтай холбоогүй, хохироогүй, бүр огт хохиролгүй хүн. Зүгээр нөгөө ярьдаг хүмүүс байдаг шүү дээ. Тэд нарын төлөөлөгчид хүртэл ороод ирчихсэн байна. Тэгэхээр орж ирдэг хүмүүсээ яг л хохирсон, яг тэр асуудалтай холбоотой хүмүүсийг нь оруулмаар юм уу гэж бодсон.

Би энэ тогтоолын төслийг харсан. Тэр дотор явж байгаа олон хүн чинь надтай бас ингээд холбогдоод байдаг юм. Өмнө нь ч холбогдож байсан. Би бараг бүгдийг нь таних юм. Тэгэхээр энийгээ хэдүүлээ нэг юм гаргаад явчихъя. Тэгээд энэ Хүний эрхийн дэд хорооны даргаар ахлуулсан нэг ажлын хэсэг байгуулъя гэж байна шүү дээ. Энэ ажлын хэсгээ хурдан байгуулчхаач. Би энэ ажлын хэсэгт чинь орж, ажилламаар байгаа байхгүй юу. Тэр хүмүүстэй уулзмаар байгаа юм. Яг яачхаад байгаа ю, юу болчхоод байгаа юм. Миний мэдэж байгаагаар бол жишээ нь тэр Жаргал гэдэг хүнийг чинь бол АТГ-ын Золбаяр гэдэг нөхөр шууд улайм цайм хэлмэгдүүлээд л явсан. Энхбатыг шүүх гэсэн чинь нөгөө торгуулийнх нь хэмжээ нь Шүүхийн шинжилгээний төвөөс арай бага гаргаад өгчихсөн. Бага юу байх вэ дээ, байгаагаар нь гаргаад өгсөн нь арай бага мөнгө гараад л, тэгээд тэрнийх нь төлөө шоронд аваачаад хийчихсэн. Иймэрхүү улаан цайм юмнууд байдаг байхгүй юу. Тэгээд эд нар надад ямар зовлон ярьдаг юм гэхээр үгүй ээ, бид нарыг улайм цайм хэлмэгдүүлчихсэн. Тэгээд ингээд энэ хэрэг чинь бол хэлмэгдүүлсэн хэрэг байхгүй юу. Тэгээд энийг больё гэхээр шинээр тогтоогдсон нөхцөл байдал байхгүй байна гээд ингээд явчихдаг. Шинжээчээ олоод л захиалаад авчихсан. Энэ ерөөсөө бүтэн ийм захиалгатай юмнууд байхгүй юу. Тэгэхээр энийг манай ажлын хэсэг гараад хэдүүлээ нэг сэтгэл гаргаад, хэдэн хүн олоод тэд нартай уулзах хэрэгтэй. Тэр олон хүн дунд бас их замхарч байна лээ. Олон асуудал. Тэгээд нэлээн детальчилчихад тэд нар ганцхан юманд гомддог юм. Үгүй ээ, бид нарыг хэлмэгдүүлсэн хүмүүс чинь албан тушаал дэвшээд улам яваад байна шүү дээ. Нэг хэсэг зарим нэг прокурорын тушаал буусан чинь одоо бүүр дээшээ оччихсон шүү дээ. Ер нь манай Хөгжлийн банкны хэрэг дээр ч гэсэн бид нарыг сайн ялласан хүмүүс бол албан тушаал дэвшчихсэн шүү дээ. Үгүй ээ, ийм улаан цайм юм. Би энэ дундуур чинь явчихсан учраас би ажлын хэсэгт чинь ормоор байна. Тэгээд хэдүүлээ ажилламаар байна. .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Хамгийн гол нь дахиж ийм юм гаргамааргүй байгаа байхгүй юу. Тэр Энхбатыг чинь бол шорон дамжуулж алж байгаа шүү дээ. Эрүүдэн шүүнэ гэдэг чинь энэ шүү дээ. Бүр аймшигтай. Би тэд нарыг чинь өмнө нь бүгдтэй нь уулзчихсан. Би бүгдийг нь мэдэж байгаа. Одоо сүүлд нь тэр Сонгинохайрханы газрын маргаантай нэг иргэн нэмэгдсэн. Ганболд билүү. Хэн билээ. Тийм ээ Сайнзориг мэдэж байна. Тэр бол бас хүнийг тамлаад л энэ хууль хяналтын байгууллагынхан чинь ингэж байгаад л тэгээд л нөгөө нөхрийг чинь хэлэлцэх хэргээ шийтгэхээд байгаа байхгүй юу. Тэр чинь ихэнх нь шийтгэгдчихсэн шийтгэлээ эдэлчихсэн хүмүүс. Тэгээд одоо энийгээ болиулмаар байна шүү дээ. Миний үр хүүхдүүд ч гэсэн сонсоход дээр нь хувь хүний хувьд өчнөөн хохирол

амсчихсан, өчнөөн мөнгө төгрөгөөр хохирчихсон энийг л ингээд шийдье л гээд байгаа юм. Хэдүүлээ энэ рүү нь жаахан яамаар байна. Тэр 2 дугаар зүйлүүд бараг хэрэггүй юм биш үү. Та нар яриарай. 2 нь энэ хорих анги, эмчилгээ, тэр сургалт явуулаад бүтэхгүй ээ. Хүний хэлмэгдүүлсэн амьтдыг шийтгэх хэрэгтэй. Тэгж байж энэ сайжирна. Шийтгэгдсэн хүмүүст нь бол .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Алтанхуяг даргын хэлж байгаа бас зөв зөв. Бид хэд сонсголыг бас бүтээмжтэй, аль болохоор иргэдээ сонсох, эрх ашиг нь хөндөгдсөн хүмүүсээ сонсох талдаа бас байх нь зөв байгаад байгаа юм. Гэхдээ нөгөө талуудын оролцоог зөв байлгах, зөв мэдээлэлтэйгээс бид нар бас зөв шийдвэр гаргана гэж үзээд ерөнхийдөө хуулиараа энэ чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын байр суурийг сонсохоос өөр аргагүй байна.

2 дугаарт манай энэ хууль зүйн салбарын бас онцлог байна л даа. Зөвхөн ганц одоо төрийн байгууллагыг уг нь төлөөлөөд Засгийн газрын байр суурийг сонсчихёо гэхээр шүүх эрх мэдлийн байгууллага шүүхийн шийдвэрлэлтийн байдал, эргээд прокурорын байгууллага гэдэг чинь бас харьцангуй бие даасан статустай буюу Үндсэн хуулийн институцүүд болчихоод байгаа. Тэгэхээр эд нарын мэдээллийг ч гэдэг юм уу Засгийн газар нэгтгээд танилцуулахаар бас их болж өгдөггүй. Эд нүүрийг бас зайлшгүй сонсож юу нь хаанаа болохгүй байгаа талаар бас сонсохоос өөр аргагүй байгаа.

Яах вэ зүгээр Засгийн газрын байр суурь дээр Батлан хамгаалах, зэвсэгт хүчин, эрүүл мэнд болон тэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг нэгтгээд сонсгочиход бол болох байсан. Тэгэхдээ энэ бас онцлог бүхий яах аргагүй бас асрамжийн газар эрүүдэн шүүлт явагдаад байдаг хүүхдийн өдөр өнжүүлэх төвүүд явах магадлал эрсдэлтэй. Бас тэр СЭМҮТ-д бол бүр нэлээн бүр хүний эрхийн том зөрчлүүд байхыг бас үгүйсгэхгүй байгаа гэх зэрэг тэгээд батлан хамгаалах салбарт бас дүрмийн бус харилцаа буюу яг энэ эрүүдэн шүүхийн асуудал бас хөндөгдчих гээд байдаг учраас зайлшгүй бас сонссон юм. Тэгэхдээ таны хэлж байгаа энэ саналыг бид анхааръя. Цаашдаа бас дэгдээрээ өөрчлөлт оруулах, эдгээрийг нэгтгэж Засгийн газар нь танилцуулна ч гэдэг юм уу.

Ингээд оролцогчдын хувьд бас ялгахад их хүнд. Яах аргагүй иргэд бас сонирхсон асуудлаараа төрийн байгууллагуудын сонсголд бүртгүүлээд оролцоно гэж байгаа. Тэр дээр бид нар янз бүрийн шаардлага шалгуур тавихад бас тун бэрх юм байна лээ. Зөвхөн та энэ асуудалд эрх ашиг нь хөндөгдсөн этгээд байна гээд явчихаар. Тэгээд л одоо яах аргагүй тэр дэгийнхэндээ дагуу бид хэд зохицуулаад сэдвийн хүрээнд яриагүй учраас зарим хүнийг та энэ чиглэлээрээ үг хэлж болохгүй байна. Би бас Эрдэнэболд даргыг гуйгаад жишээ нь тэр вакцины асуудал ярьсан хүмүүсийг тусад нь нэг сонсьёо ч гэдэг юм уу ийм байдлаар ингээд аргалаад зохицуулаад явсан шүү.

Яах вэ, тэгээд энэ тогтоол дээр байгаа тэр сургалт сурталчилгааны асуудал чухал байгаа юм. Хүн заримдаа нөгөө мэдэхгүйгээсээ хамаарч ял шийтгэлээс зугтах боломжгүй шүү буюу ял хариуцлагаас чөлөөлөх, хөнгөлөхгүй гэдэг мөртөө бид бас энэ хүмүүсийг ер нь байнгын л тогтмол мэдээлэлжүүлэх асуудал байгаа юм.

Би бас Хууль зүй, дотоод хэргийн яаманд ажиллаж байхдаа энэ сургалтыг бас зардал багатай, үр нөлөөтэй болгохын тулд хууль сахиулагч нарт ийм платформ хийе гэж хийсэн юм. Үүнийхээ араас бас явъя гэж байгаа юм. Тэгэхгүй болохоор нэг сургагч багш гээд явахаар хэдэн үгнүүдийг бэлдээд гаргадаг. Хөдөө орон нутгаар машинд суугаад аймаг аймаг дээр болсон, болоогүй халти лекц уншингуутаа орой нь сайхан мах, шөл, янз бүрийн юм болж байгаад л хүрээд ирдэг. Тэгэхээр энэ дээрээ илүү цахим гарын үсгээр ороод тухайн албан хаагч аль ч өдөр, шөнийг ялгахгүйгээр цаг гарсан үедээ хэрэгцээтэй тэр мэдээллүүдийг эсвэл заавал үзэх ёстой мэдээллүүдийг үзчихдэг. Тэгээд энэ дээрээсээ бас хууль, эрх зүйн орчин ингэж өөрчлөгдөж байгаа юм байна. Энийг ингэх юм байна гэдэг мэдээллүүдийг цахим технологийн юугаар бас дамжуулж хийх ёстой байгаа юм. Тэгээд яах вэ, энэ агуулгын хувьд бол сургалт гэдэг зүйлээс хэдүүлээ хууль сахиулах салбараас хэзээ ч арчиж болохгүй. Энэ салбарын бас хүний нөөцийн хөдөлгөөн бас явж байдаг, зарим нь бүгд дээд боловсролтой хүн байдаггүй. Энэ мэдээллийг тогтмол өгөөгүйгээс цаана нь хүний эрхийн үр дагавар гарчихна. Бид хэд үр дагавартай буюу тэмцэх гээд байгаа юм биш. Наана нь урьдчилан сэргийлэх ажил бас хийгдэх ёстой байгаад байгаа юм. Тэгээд тийм учраас бас энийг оруулаад явъя. Та бас зөвөөр ойлгоорой гэдэг зүйлийг би бас хүсэж байна.

Д.Цогтбаатар: Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр 11 сарын 20-ны сонсголын асуудлыг олон нийт ч гэсэн маш сайн үзсэн. Бид нар хамгийн гол нэг зүйлийг тэнд бол тэр чигтээ хохирсон, хохирсон нь тогтоогдсон. Хохирсондоо арга хэмжээ одоог хүртэл авч чадахгүй байгаа ийм гомдолтой иргэд бараг 99 хувь нь байсан. Тэгэхээр зэрэг энэ тогтоол дээр бид нар яг тийм хохирсон хохирогчдын тухайд авч хэлэлцэх, тэгээд дээрээс нь тэдний эрхийг сэргээх талын зүйл заалтыг дутмаг оруулсан байна гэж би хувьдаа харж байна. Яах вэ миний тухайн үед хэлж байсан эрх мэдэлтэн хүн эрүүдэн шүүсэн, хүнлэг бус, хэрцгий хандсан, хүний эрхийг зөрчсөн тохиолдолд тэр хүнийг дахин удирдах албан тушаалд томилдоггүй байх тухай хүсэлтийг бол энэ 2 дугаар хэсгийн Д хэсэгт бол оруулсан байна. Гэхдээ энэ эрх мэдэлтнийг дараагийн албан тушаалд томилохгүй байх нь энэ бол авч байгаа арга хэмжээ биш юм. Энэ эрх мэдэлтнийг мэдээж дараагийн албан тушаалд томилохгүй байхаас гадна эрх мэдлээ урвуулан ашигласан тэр үйлдлийг нь хуулиар ямар хариуцлага тогтоодог хууль, эрх зүйн хүрээнд ял шийтгэл ноогдуулдаг энэ юмыг нь бас тусгайлан зааж өгөхгүй бол болохгүй байна. 1 дүгээрт.

2 дугаарт энэ зөрчигдсэн эрхийг сэргээх, хамгаалах гэсэн бүр ийм бүлэг 3 дугаар зүйл дээр нэмдэг юм уу, эсвэл 4 дүгээр зүйл болгож оруулдаг юм уу ийм санал оруулмаар байгаа юм. Яагаад гэвэл нэгэнт эрх нь зөрчигдчихөөд байхад тэрэн дээрээ арга хэмжээ авч чадахгүй байна. Хохирлоо барагдуулж чадахгүй байна гэж байгаа. Тэгвэл эрхийг сэргээлгэх, зөрчигдсэн эрхийг сэргээх, хамгаалах дээр миний бодлоор бүр ийм юу ингэмээр байгаа юм. Жишээлбэл сэтгэл санааны болон нийгэм, эдийн засгийн хохирлыг үнэлэх, алдагдсан боломжийг үнэлэх. Энэ жишээлбэл хэлмэгдсэн, эрүүдэн шүүлтээс үүдсэн бүх хохирлыг нь наад зах нь минимум стандартаар бид нар тогтоож болдог болов уу. Жишээлбэл 15 жил хэлмэгдээд ял эдлээд, хоригдоод гараад ирсэн хүнд 50 сая төгрөг өгөөд ингээд амыг нь хаагаад явж байна. Гэтэл мөн адил хэмжээний хэлмэгдсэн хүмүүс тэнд хэдэн тэрбум нэхээд байж байна шүү дээ. Тэгэхээр ийм харилцан адилгүй зүйлийг нэг ёсондоо сайн өмгөөлөгч, хуульчтай, эрхээ сайн мэддэг, эрхээ сэргээлгэхээ мэддэг ийм хүмүүс нь болохоор илүү мөнгөн дүнгээр хохирлоо барагдуулах

боломжтой, тийм нөхцөл боломжгүй хүмүүсийг нь бас нэг ёсондоо мэдлэггүй байгаагаар нь ялгаварлан гадуурхаж байгаа юм шиг ийм нөхцөл байдал үүсээд байна. Дарга аа, би нэгмөсөн 1 минутаа авчихъя.

Тэгээд эрүүдэн шүүт шүүлтэд өртсөн гэх 21 настай талийгч “О”-ын асуудал байгаа шүү дээ. Энэ хүн жишээлбэл танин мэдүүлэх ажиллагааг цаг тухайн үед нь явуулж чадаагүйн улмаас энэ хүн цагдан хоригдож байх явцдаа ингээд нас барчихсан байгаа. Гэтэл энийг жишээлбэл АТГ зүгээр тухайн танин мэдүүлэх үйл ажиллагааг цаг тухайд нь явуулж чадаагүй хүнийг албан тушаалаас нь огцруулаад, ажлаас халсан байдлаар ингээд шийдчихсэн. Гэтэл дараа дараад ийм зүйл бол яах юм бэ. Нэг тал. Нөгөө талд нь хохирогчийн ар гэр бүлд барагдуулах нөхөн олговор энэ тэр гэдэг зүйл манай улсад байж болдоггүй юм уу.

2 дугаар 1 чухал зүйл байгаа нь улс төрийн болон ашиг сонирхлын үүднээс эрүүгийн хилс хэрэгт хохирсон хэлмэгдсэн хүмүүсийн тодорхой баримтууд хүртэл байна шүү дээ. Тэгэхээр энэ зүйл дээр нь бид нар бас ингээд нөгөө хүсэлтийг нь яг энэ баримтад тулгуурласан тэр иргэдийн хохирлыг барагдуулах ийм арга хэмжээнүүдийг тогтоол дээр зүйл заалтаар оруулмаар байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Манай Нара гишүүн бас зөв асуудлуудыг хөндөж байна. Гэхдээ 1 ийм байгаа юм Нара гишүүн ээ. Тухайн хүнийг тэр албан тушаалаа хашиж байх хугацаанд энэ эрүү шүүлт, хүнлэг бус хэрцгий хандаад ийм асуудал орооцолдсон байна гэдэг дээр бол тэр албан тушаал нь чөлөөлөөд, төрийн албанд ч юм уу тодорхой хууль сахиулах албанд ажиллуулахгүй гэхээс гадна, энэ эрүүдэн шүүлтийн асуудал чинь өөрөө гэмт хэрэг байхгүй юу. Хариуцлагыг нь л бид нар оногдуулах. Өнөөдрийн энэ оногдуулж байгаа гэмт хэрэг өөрөө эргээд зүгээр үндсэн бүрэлдэхүүний хувьд бол бас торгох ялтай. Тодорхой хорих ял нь бага юм. Тэгэхдээ энэ нь өөрөө эргээд бусдын эрүүл мэндэд ямар хэмжээний хохирол гэдэг юм уу гэмтэл учруулснаасаа хамаараад бусад гэмт хэрэгтэй давхар зүйлчлэгддэг. Хүний амь нас хохирвол бас давхар зүйлчлэгддэг ийм байсан. Тэгэхдээ ер нь зүгээр цаашдаа энийг гэмт хэргийн шинжийг нэг цогц байдлаар нь шийдэх асуудлыг нь анхааръя. Ялангуяа түрүүн бас Эрдэнэболд гишүүн хэлж байсан. Ялангуяа улс төрд нөлөө бүхий этгээдүүд болон хууль сахиулах байгууллагын удирдах албан тушаалтнуудын захиалгаар гэдэг юм уу, тодорхой хувийн сэдлээр энэ гэмт хэргүүд хийгдсэн байвал илүү ял шийтгэлийн хариуцлагыг нь өндөржүүлж оруулж ирье гэдэг зүйлийг бид нар бас энэ тогтоолоороо өгөх гэж байна.

Тэгээд ер нь зүгээр, энэ төрлийн гэмт хэргээс учирсан хохирлуудыг бид хэд ер нь бас их бодит хохирлыг л тогтоож буюу үнэхээр та хэдэн төгрөгийн цалин авч байсан юм. Эсвэл эмчилгээнд хэдэн төгрөг зарцуулсан юм. Тэр явсан эмчилгээний зардлаа баримт нь байгаа юм уу. Энэ аймаг хооронд тэдэн удаа явсан автобусны билет чинь байна уу гэдэг зэргээр шүүх үнэлж байж тогтоож өгөөд байгаа юм энэ хохирлыг. Энэ нь эдгээр хүмүүст хэцүү байхгүй юу. Яг үнэндээ хэлэхэд маш хэцүү. Тогтоох ч хэцүү. Тэгэхээр энийг бид нар ер нь зүгээр цаашдаа арай жоохон хялбарчилж жишигчилж авч үзэх энэ юм руу бас оруулж үзье, судалъя гэж байгаа юм. Тэгээд энийгээ бас анхаарах ёстой.

Мэдээж хохирлын хувьд бол бодитой тэр нотлох баримтаараа үнэлэгдэнэ. Цаашдаа тэр сэтгэцэд учирч байгаа хор уршгийн асуудлыг үнэлэхдээ таны ярьж

байгаа бусад тэр боломжуудыг алдсан энэ нөхцөл байдлуудыг бас анхаарч авч үзэх бололцоонууд юу байна гэдэг зүйлийг бас авч үзье. Ер нь тэгээд мэдээж энэ чинь сэтгэл санаа, ажил ерөөсөө нийгэм дэх бүх л юмаа алдаж байгаа юм. Хүнд байгаа тэр дигнити буюу ер нь байгаа, байж болох тэр бүх юмаа алдаад, бараг дахин амьдрах хэмжээнд л гарч ирж байгаа юм л даа. Одоо өөрөө өөртөө итгэхээ байчихсан, өөрөө өөрөөсөө айдастай, нийгмийн бусад этгээдээсээ айх айдастай болчихдог. Аливаа ийм хилс хэрэгт ороод, үнэхээр тэр эрүү шүүлтэд ороод ирсэн хүн бол маш хүнд. Би одоо бас энэ салбарт ажиллаж, энэ чиглэлийн нэлээн олон хүмүүстэй бас биечилж уулзаж, яг энэ сэтгэгцэд учирсан хор уршгийн асуудлыг нь үнэлж байсан.

Үнэхээр хүн бол ердийн иргэн бол хараад ойлгохгүй ч гэсэн яг хамт ингээд байхаараа ерөөсөө л ердийн биш болчихдог, хэвийн амьдрах чадвараа алдчихдаг байхгүй юу. Тэгэхээр энийг бол бид хэд цаашдаа анхаарч авч үзэх учраас энд тогтоолын төсөл дээрээ энэ хохирлыг барагдуулах асуудлыг анхааръя гээд. Түүрүүн манай Номинчимэг бас хэлж байсан. Илүү их тэр иргэний процесс, нотлох баримтыг цуглуулах энэ тэр асуудал дээр нь анхаарч өгье. Магадгүй илүү шүүхийн оролцоотой байдаг юм уу, тийм юм руу явахгүй бол зарим талаараа өөрөө аваад ир гээд шүүгч нар удаашруулаад, үнэхээр нөгөө хавтаст хэрэг нь Төв аймгийн шүүх дээр дараагийн тусгаарлагдаад шийдэгдэх гээд байж байхад тэндээс юу ч гаргаж өгөхгүй нөгөө иргэд нь нэхэмжлэлээ гаргаж чадахгүй бараг 2, 3 жил гүйж байгаа байхгүй юу. Ийм л нөхцөл байдалтай зүгээр нэг жишээг л аваад ярихад ярьж болж байгаа юм. Тэгэхээр ийм хүнд байгаа. Энийг бид нар маш хялбарчилж бас авч үзэх, тэр иргэний процессын хууль, магадгүй эрүү, эрүүгийн процессын хууль дээр ч гэсэн тодотгож авч үзье гэж бас энэ дээрээс тусгаж байгаа шүү гэдэг зүйлийг танд хэлье.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Сонсголыг нэлээн чамбай нягт зохион байгуулах гэж оролдсон. Сонсгол дээр болж байгаа үйл явцыг бол нэлээн сайн ажигласан, анзаарсан. Улсын Их Хурал дээр 2, Улсын Их Хурлын даргын захирамжаар 2 ажлын хэсэг байгуулагдсан байгаа юм.

Нэг дэх нь болохоор яг энэ эрүү шүүлттэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын чиглэлийн өөрчлөлт хийх, шаардлагатай бол бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудлыг ч хөндөх чиглэлээр нэг ажлын хэсэг байгуулагдчихсан. Дээр нь нөгөө гэрч, хохирогчийг хамгаалах нэг ажлын хэсэг байгуулагдчихсан. Гэрч, хохирогчийг хамгаалах хууль зүйн орчныг боловсронгуй болгох, зохион байгуулалтыг бас сайжруулах. Гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлийн ажлын хэсэг ахлагч нь надтай зөвшилцөөгүй учраас гээд би яг энэ дээр ийм санал илэрхийлээгүй гээд ахлагч нь түдгэлзээд, тэгээд үйл ажиллагаа явуулахгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ тогтоолын төслийн 2 дахь хэсгийн тэр ард байж байгаа Хууль зүйн байнгын хорооны даргад даалгасугай гэдэг хэсэг дээр байгаа Хүний эрхийн дэд хорооны даргаар ахлуулсан ажлын хэсэг Их Хурлын даргын зохион байгуулагдсан ажлын хэсэг 2-ыг холбочихмоор санагдаад байна. Тэгвэл илүү үр дүнтэй ажил болох байх.

Яг үүнтэй холбоотойгоор манай байгуулагдсан ажлын хэсэг бас нэлээн олон уулзалтуудыг хийсэн. Энэ уулзалтуудын хүрээнд 5 асуудал их чухал байгаа юм

байна лээ. Ерөөсөө ингээд ярьж байгаа мэргэжилтнүүд, хохирсон иргэд, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанаас харахаар.

1 дүгээрт нь болохоор түрүүн Нарантуяа гишүүний хэлсэн нөгөө амь насаа алдсан залуутай холбоотой асуудал энэ сонсголыг зохион байгуулах их үйтгэл болсон тэр хэрэг дээр гэхэд гэрч, хохирогчийн хамгаалах чиг үүрэг нь цагдаагийн байгууллагад байгаад байдаг. Эрүү шүүлтийг хийсэн байгууллага нь цагдаагийн байгууллага өөрөө байгаад байдаг. Тэгээд АТГ-т гомдол өгдөг. Авлигатай тэмцэх газар нь гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг манайд байхгүй, зардал байхгүй, энийг хариуцсан хүн байхгүй учраас гээд нөгөө иргэнээ хамгаалах чадваргүй байгаад байдаг. Яг энэ үл ойлгогдох цонхон дотор чинь л тэр иргэн амь насаа алдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог сайжруулах, зохион байгуулалтыг оновчлох, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр далайцтай 1 алхам хийхгүй бол энэ төрлийн чинь маргаан ер нь бол дуусахгүй юм байна лээ. Харагдаад байгаа юм. Яагаад гэвэл энэ эрүү шүүлтийг хэрэглэж байгаа гэмт хэрэг гэдэг юм уу эс үгүй бол зөрчил гаргаж байгаа албан тушаалтан, байгууллагууд чинь өөрсдөө мөрдөх байгууллагууд байгаад байгаа. Өөрсдөө гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагууд байгаа. Тэгээд гэмт хэрэгтэй тэмцэх нөөц, хүч чадлаараа өөрсдийнхөө үйлдсэн гэмт хэргийг халхлах гэж оролддог ийм зүйл байгаа.

Тэгэхээр нөгөө гэрч, хохирогчийг хамгаалах одоо байгаа энгийн тогтолцоо чинь тэр хүчтэй хэрэгслийн өөдөөс бол зогсох ямар ч боломжгүй байгаад байгаа юм. Дээр нь ../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд микрофоныг нь өгье.

Х.Тэмүүжин: Дээр нь дахиад яг энэ гэрч, хохирогчийг хамгаалах болон энэ эрүү шүүлттэй холбоотой асуудал дээр угаасаа нөгөө хяналт тавьдаг бүтцүүд нь ойлгомжгүй юм байна лээ. Хяналтыг үндсэндээ ингээд харахаар гадаад, дотоод 2 хяналт байгаад байгаа байхгүй юу. Бусад улс орнуудын туршлагыг харахаар. Манайд бол Засгийн газар дотооддоо хяналт тавих бүтэц угаасаа байхгүй. Бусад улс орнуудад Хууль зүйн сайд, Ерөнхий прокурор нь нэг байгаад, Хууль зүйн яам дээр прокурорын систем байдаг учраас дотоод хяналт нь маш амжилттай явдаг юм байна лээ. Манайд прокурор нь гадаа байгаа учраас Хууль зүйн яаманд энэ чиглэлийн дотоод хяналт хийх ямар ч нөөц байхгүй, чиг үүрэг байхгүй, зохион байгуулалт байхгүй.

Гадаад хяналт нь бол нэг бол шүүх, нэг нь парламентын хяналт байгаа. Парламентын хяналт дээр Хүний эрхийн Үндэсний Комисс дээр урьдчилан сэргийлэх бүтэц байгуулсан. Гадаад хяналт хэрэгжүүлэх 1 комиссын гишүүн байгаа. Гэтэл Улсын Их Хурал дээр гадаад хяналтын бүтэц байгаа байхгүй. Яагаад гэвэл манай яг Тусгай хяналтын дэд хороо чинь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дээр байгаад байгаа юм. Хууль зүйн байнгын хороо дээр байхгүй. Тэгээд энэ ../минут дуусав/

Д.Цогтбаатар: Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

Ж.Алдаржавхлан: Баярлалаа. Надад 2 ийм санал байна. Байнгын хорооны дарга аа, ажлын хэсгийн дарга аа, бид нар чинь өмнө нь Нүүрсний сонсгол гэж сонсоод, Монгол орон даяар бөөн юм болсон. Дараа нь Ногоон автобусны сонсгол

гэж болж байсан санагдаж байна. Саяхан бид нар эрүүдэн шүүлтийн эсрэг сонсгол гэж хийж байгаа юм. Тэгэхээр энэ сонсголыг ер нь 2 үе шаттай хийж болохгүй юу гэдэг ийм санал байгаа юм. Хуульд өөрчлөлт оруулаад. Эхлээд хяналтын сонсголоо хийгээд, тэгээд түүний дараа үр дүнгийн сонсгол хийдэг баймаар байгаа юм. Жил орчмын дараа. Тэгэхгүй бол яг ямар ажил хийгдсэн нь тодорхойгүй, баахан хүмүүс энд орж ирж зовлонгоо ярьж ярьж явдаг. Эртээд тэр сонсгол дээр нэг хүн хэлж байна лээ шүү дээ. Бид нар зөндөө энд ингэж ярьж ярьсан. Ерөөсөө шийдэгдэхгүй байгаа гэж хэлж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар сонсоод л яваад байгаа юм. Тэгэхээр асуудлыг яаж мухарласан бэ, яаж шийдсэн бэ, тэр нөгөө хүн эрүүдээд байгаа нөхөрт ямар хариуцлага тооцсон бэ гэдгийг эргэж сонсох үүднээс үр дүнгийн сонсгол хийдэг болъё гэсэн ийм санал байна. Манай нийгэмд чинь нэг ийм яаж л хариуцлагаас бултах вэ гэдэг ажил маш их явдаг учраас ялангуяа энэ хүчний байгууллагууд дунд энийг дахиж хиймээр байгаа юм. Тэгвэл хүмүүс энэ чинь эргээд сонсдог юм. Энэ ажлыг нь хийе гэдэг тийм зорилго үүсэх байх.

2-т нь энэ Хүний эрхийн комисс гээд ийм шүдгүй ийм байгууллага байгаа юм. Тэгээд үнэхээр ямар нэгэн хэлбэрээр Сайнзориг дарга аа, ямар нэгэн хэлбэрээр тэр хорих дотроос хүн намайг эрүүдэн шүүгээд байна гэдэг мессежийг өгөх юм бол Хүний эрхийн Комисс түдгэлзүүлж эрхийг нь өгмөөр байгаа юм. Тэр хэргийг. Тэгж үздэг, эрүүдэн шүүлтийн орчныг нь шалгадаг тэр эрхийг нь Хүний эрхийн Комисс. Бараг 100 гаруй ажилтантай юм байна лээ шүү дээ энэ Хүний эрхийн комисс. Сая 80 хэд байсан сая төсвөөр 10 хэдэн хүн нэмэгдээд 100 гаруй болчихсон байгаа. Тэгээд энэ хүмүүс очиж ажлаа хийдэг. Очихдоо бас тэр эрүүдэн шүүлтийг зогсох эрх мэдэлтэй болгож өгөхгүй бол бид нар өнөөдөр энд нэг ярьж ярьж, тардаг, тэгээд мартчихдаг.

Тэгэхээр яг эрүүдэн шүүлтийг хамгийн торгон мэдрэмжээр мэдрэх байгууллага нь гэхээр Хүний эрхийн Комисс байгаа юм. Цагдаа нар бол бие биеийгээ мэдээж юу яахгүй шүү дээ. Тэр ойлгомжтой. Нэг төгсөлтийнхөн байдаг гээд яриад байлаа шүү дээ. Тэгэхээр бидний хувьд бол Хүний эрхийн Комиссыг илүү хүчтэй болгож өгч, илүү асуудал руу ордог болгож байж, илүү шийдвэрлэгдэх юм байна гэж би харж байгаа юм.

Тэгээд л бид нар энэ хүчнийхээ байгууллагатай ноцолдоод л, энэ хэдэд даалгавар өгөөд л, энэ хэддээ хугацаатай үүргүүлээд байх юм бол энэ хэзээ ч биелэхгүй. Тийм учраас гуравдагч байгууллагад эрх өгмөөр байна гэсэн ийм 2 зарчмын том санал байна. Энийг та хэд маань бас хүлээж аваач гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофон.

П.Сайнзориг: Алдаржавхлан даргын тэр хэлж байгаа саналуудыг бол зарчмын хувьд дэмжиж байна. Ер нь бол яах вэ, зүгээр энэ тогтоол хэдийгээр батлагдсан ч гэсэн бид хэд бас яг үүний дагуу дахиад үр дүнг нь танилцуулах, зөвхөн Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд үр дүнтэй байна, байхгүй биш. Нөгөө оролцогчдоо магадгүй зар хүргүүлээд дахиад сонирхсон этгээд байж болох юм. Энийг бол бас цаашдаа бас Хууль зүйн байнгын хорооны дарга бас даргын зөвлөл энэ тэр дээр ярих байх. Тэгээд өнөөдөр бас нөгөө яг Энхбаяр гишүүн ч хэлээд байгаа зөв байхгүй юу. Хууль зүйн сайдгүй л бид нар хууль зүйн бодлогын хамгийн том хүний эрхийн асуудлыг яриад л сууж байгаа гэх зэрэг энэ сонсгол болон цаашдаа энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээ янзалж, тал талдаа

тэнцвэртэй мэдээлэлтэй, шийдвэр гаргах дээрээ бас сонсдог, хариултыг нь авдаг, эндээсээ бодлогоо зөв тодорхойлох энэ бололцоог бол бүрдүүлэх ёстой гэдэг дээр санал нэг байна.

2 дугаарт бол яах вэ комиссын үйл ажиллагааг сайжруулах юман дээр бол дэмжиж байна. Комиссын энэ хуулийг бол би бас яг л нээлттэй сонгон шалгаруулалтын юмыг анх бодож оруулж ирсэн хүн л дээ. Тэгээд тухайн үедээ бас их зэмлүүлээд чи хаанаас юу хийв гээд. Тэгэхдээ 1 зүйл байна. Манай энэ комиссын үйл ажиллагаа эрүүдэн шүүхийн тэр асуудал эрхэлсэн гишүүн маань их буруу ажиллаж байгаа юм байна лээ. Бие даасан байгууллага болох, сүүлдээ хяналт шалгалт руу явж ордог болсон байна лээ. Тэр этгээдэд тийм эрх байхгүй. Конвенцоороо. Тэгээд энийг ер нь цаашдаа нэгтгэж Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээр 1 гишүүн нь энийгээ аваад явдаг энэ асуудлыг нь шийдэж, комиссын үйл ажиллагаа уялдаатай байхгүй бол тусдаа байранд гарчихсан. Би бүүр ойлгохгүй байгаа байхгүй юу. Хэзээ ч ийм юм байхгүй шүү дээ. Тэгээд тэр хүн бол баахан хүмүүстэй уулзсан гээд нэг ийм худлаа ярьдаг. Тэгээд ерөөсөө 1 ийм тайлан хэвлүүлээд, тэгээд ерөөсөө ингээд нөгөө комиссын гишүүддээ намайг л жийрхээд байна гэдэг юм байгаа юм.

2 дугаарт яах вэ зүгээр омбутсмэний загвар луу орж болно. Таны хэлж байгаа шиг. Нэлээн тийм хүчтэй комиссарууд гэдэг юм уу, омбутсмэн шууд тодорхой нийтийн эрх ашгийн төлөө шийдвэрүүдийг гаргадаг. Тэгэхдээ энэ бол яг манайд нийцэх үү, үгүй юу. Тэгэхээр магадгүй зүгээр Хүний эрхийн Үндэсний Комиссын хувьд урьдчилан сэргийлэх болон шийдвэрлэгдсэн хэрэг маргааны улмаас хохирсон иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудал дээр дэмжлэг үзүүлж явах тэр чиг үүргийг илүү их тодотгож өгмөөр байгаа юм. Ингээд энийг нь аваад явахгүй бол шууд хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд бол Хүний эрхийн Үндэсний Комисс оролцох боломжгүй. Харин эрүүдэн шүүлтийн гэмт хэрэг гарсан бол хэнээр энэ хэрэг маргааныг хянан шийдвэрлэх вэ гэдэг асуудлыг гишүүд яриад байгаа юм. Цагдаа үйлдсэн бол АТГ хийж байгаа нь зөв үү. АТГ-ын үлдсэн юуг цагдаа хийх нь зөв үү. Эсвэл нөгөө хуучны ярьж байгаа шиг прокурорын дэргэд байх уу. Эсвэл түрүүн Хууль зүйн сайдын дуугардаг шиг ерөнхийдөө бас Тахрын алба буюу бас энэ чиглэлдээ бас гэмт хэрэгт гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргээсээ гадна бусад мөрдөн шалгах ажиллагааг хийх үү гээд. Хэдүүлээ энэ хууль зүйн салбарын тогтолцооны асуудлуудыг чиг үүргийн энэ хуваарилалтуудыг бас бодож бас наана цаана гаргах нь зөв байгаад байгаа юм. Би энэ дээр бол тантай санал нэг байна.

Тэгээд ер нь зүгээр бас Комиссын харьцангуй бас эрх мэдэл бол гарчхаад байгаа юм. Эрх мэдэлтэй болсон. Энийг харин хэдүүлээ бас зөв хэрэгжүүлж чадах уу, үгүй юу гэдэг дээр манай комисс бол сайн ажиллах ёстой гэж би зүгээр хувьдаа бодоод байгаа. Зүгээр өгөх чиг үүргийн хувьд бас тэр лимит гэдэг юм уу, тэр хязгаар бол бас яг энэ засаглал, тодорхой бас чиг үүргийнхээ хуваарьтай оновчтой байх ёстой гэдэг зүйлийг бол хэлмээр байгаа юм.

Түрүүн Тэмүүжин сайд бас цухас дурдлаа. Би бас Хууль зүйн сайд байсан бол асуумаар байгаа юм. Ер нь бол яах вэ, зүгээр энэ хууль сахиулах салбаруудын удирдлагын ёс зүйн асуудал болон яг ийм тодорхой хууль зүйн салбар дээр гардаг гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцдаг тийм бие даасан институц байгуулъя. Хууль зүйн сайд жишээ нь цагдаагийн дэд даргыг томилчихоод тэр хүнтэй асуудал ороод ирэхээр хариуцлага тооцоход хэцүү байхгүй юу. Тэгээд тэнд гарсан асуудлуудыг яамны газрын даргаар ахлуулаад ажлын хэсэг

гаргаад шалгадаг юм. Гэтэл яамны газрын дарга чинь өөрөө нотлох баримт цуглуулах этгээд биш байхгүй юу. Тэгэхээр энийг уг нь доороо .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Микрофоныг нь гүйцээгээд өгье. Нэлээн чухал юм ярьж байна. Та гүйцээгээд ярьчих.

П.Сайнзориг: Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл, тэгээд хуульчдын холбооны төлөөлөл, магадгүй зүгээр шүүх болон прокурорын төлөөлөл зэрэг 5 хүртэл ийм бие даасан байгууллагын юутай ийм хүмүүс энэ хууль зүйн салбарын удирдлагын ёс зүйн асуудлыг авч хэлэлцдэг юм байна лээ. Тэр дотоод тухайн цаг цагдаагийн жишээ нь би ярих гэж байгаа шүү. Цагдаагийн ерөнхий газар дээр байгаа ёс зүйн асуудлуудыг тэр гүйцэтгэх болон дунд түвшний албан тушаал дээр шийдэж болж байгаа юм. Гэтэл удирдлагуудын ёс зүйн асуудлыг жишээ нь Хууль зүйн сайд дээрээ авчрахаар яг үнэндээ хэлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсдэг. Би энийг нуугаад яах вэ. Тийм учраас зөвхөн цагдаа дээр биш, шүүхийн шийдвэр ч бай бүгд байхгүй юу. Тэгэхээр энэ зүйлүүдийг гаргуулахгүйн тулд ийм бие даасан институцийг байгуулаад энд нь Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Прокурор, Шүүх, Хууль зүйн яамнаас нь ороод тэгээд энэ ёс зүйн асуудал болон хэрэг маргааныг ийн шийдвэрлэх ажиллагааны явцад гарч байгаа ийм зүйл, эсвэл нийтийн хэв журмыг зохицуулах .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Би Сайнаа гишүүн ээ, энэ тогтоол дээрээ тэр эрх зүйн орчныг боловсронгуй болгох дээр тэр Улсын Их Хурлын сонсгол гээч зүйлийг 2 үе шаттай хийдэг тийм зүйлийг оруулж болохгүй юу л гээд байгаа юм. Тийм саналыг. Тэгээд эхлээд хяналтын сонсголоо хийчихдэг, тэгээд 1 жил, 2 жилийн дараа дахиад үр дүнгийн сонсгол хийдэг байхгүй бол бид нар хаячхаад байгаа байхгүй юу. Нөгөө нүүрсний сонсгол юу болсон. Байхгүй, баахан хүмүүс буруудсан, баахан хүмүүс тодорсон, тэгээд эргээд алга болчихсон. Тэгэхээр ийм асуудлаар шийдвэрлэгдтэлээ ийм түвшинд явж байна. Тэр АТГ-ын ямар нөхөр хүн хэлмэгдүүлдэг хэн гэлээ Алтанхуяг дарга хэлээд байсан шүү дээ. Тэр хүн одоо ажлаа хийж байна уу гээд үр дүнг нь бид нар сонсдог л болмоор байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм 2 үе шаттай хийдэг ийм саналыг энэ дээр оруулж болохгүй юу л гэж байгаа юм. Зүгээр ингээд сонсгол хийгээд л нэг баахан хүмүүст хайртай болоод л ингээд л хаяж болно. Гэхдээ хэдүүлээ үр дүнг нь хянаж байвал яасан юм бэ л гэж байгаа юм л даа.

Д.Цогтбаатар: Яах вэ, хариулах уу. Алдаржавхлан гишүүн ээ, ийм байгаа юм. Таны хэлж байгаа бол зөв шүү. Та чинь Улсын Их Хурлын гишүүн шүү дээ. Энэ тогтоолтой тогтоолгүй та энийг шууд санаачлах эрхтэй. Наадах чинь надад бол сонсогдож байна. Тэгэхдээ хэдүүлээ нэг ийм юм яримаар байна. Бид нар чинь өөрсдөө Улсын Их Хурлын гишүүн байж сонсголоо явуулчихаад, зүгээр ингээд сонсоод өнгөрлөө гээд энэ танхим дотор өөрсдөө сонссон гишүүд ийм юм яриад суугаад байж болохгүй. Энэ сонсгол явагдсанаар, тэр нүүрсний сонсгол явагдсанаар шүүх хуралдаан чинь яваад хүмүүс тодорхой ял эдлээд, шорон орондоо суугаад явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ сонсгол эд нар чинь хэзээ ч зүгээр нэг хоосон сонсгол байдаггүй. Энийгээ бас хэдүүлээ одоо энэ тогтоол гаргах гээд, санал хураах гээд гишүүд ээ, байж байгаарай гээд байгаа чинь энэ тогтоол чинь заавал биелэх эрх зүйн чадамжтай бичиг баримт гарч байгаа байхгүй

юу. Биелүүлээгүй байвал тэр сайдтай нь харин эргээд хариуцлага тооцож болох энэ тогтоолыг Их Хурлын Байнгын хороо гаргачхаад байхад яагаад хэрэгжүүлээгүй юм бэ. Энэ чинь сонсголын дагуу явсан гээд асуудал гарч ирнэ шүү дээ. Тэгэхээр тийм тийм би саналыг чинь дэмжиж байна. Би үгүйсгээгүй. Өөрийг чинь харин зөв гээд харин хуулийн төсөл оруулаад ирэх юм биш үү гэж байхгүй юу. Тэмүүжин гишүүн энэ дээр бас санаа хэлье гэж байна.

Х.Тэмүүжин: Тийм Алдаржавхлан гишүүний хэлж байгаа нэг зүйл бол энэ чинь өөрөө нөгөө oversight hearing-ийн нэг чухал хэлбэр нь байхгүй юу. Бид нар энэ сонсголтой холбоотой хууль тогтоомжуудыг зарим зүйлийг нь буруу зохицуулчихсан юм байна лээ. Тэгээд Улсын Их Хурал дахиад яг энэ сонсголтой холбоотой хэсгүүдээ сайжруулах хэрэгтэй. Жишээ нь Сайнзоригийн саяын зохион байгуулсан сонсгол өөрөө oversight hearing байхгүй юу. Тэгээд яагаад энийг би буруу гэж хэлж байгаа юм бэ гэхээр oversight hearing гэдэг чинь парламент энгийн ажиллаж байгаа үедээ хуулийн биелэлтийг хангах чиглэлээр үндсэн бүтцээрээ ажилладаг сонсголын систем байхгүй юу. Тэгэхээр уг нь бол бид нар зөв зохион байгуулалттай хийсэн бол энэ сонсголыг даргалаад зохион байгуулах хүн нь Хууль зүйн байнгын хорооны дарга, Хууль зүйн байнгын хорооны бүтэц өөрөө байх ёстой. Эсвэл Хүний эрхийн дэд хорооны дарга, Хүний эрхийн дэд хороо өөрөө байх ёстой. Тэгээд Хууль зүйн байнгын хороо болон Хүний эрхийн дэд хороо гаргасан тогтоолоо араас нь дахиад oversight хийхийн тулд дахиад хяналтын сонсгол хийх ёстой байхгүй юу. Тэгээд энэ процессыг л Алдаржавхлан өөрөө нэхээд байгаа юм. Гэтэл манайх яагаад зохицуулчихсан бэ гэсэн чинь энэ нөгөө oversight hearing хийхдээ өөр хэн нэгнээр даргалуулдаг, тусгайлаад нөгөө Тусгай хяналтын түр хорооны сонсголтойгоо адилхан зохицуулалт хийгээд өгчихсөн юм байна лээ. Тэгэхээр нөгөө Байнгын хороо үндсэн үйл ажиллагаа нэг тусдаа яваад байгаа юм шиг нэг тийм ойлголт үүсчхээд, тэгээд түр хорооны байгуулсан сонсголын араас хяналтыг хэн хэрэгжүүлэх юм бэ гэдэг шиг асуулт тавиад байгаа юм байна лээ.

Түр хорооны сонсгол ч гэсэн яг тийм. Түр хороо сонсголоо хийгээд, шийдвэрээ гаргаад дуусаад, тэр шийдвэр нь эсвэл тэр шийдвэртэй холбоотой асуудал нь аль нэг Байнгын хорооны үндсэн асуудал учраас энэ шийдвэр биелж байна уу, үгүй юу гэдгийг тухайн асуудлыг эрхэлсэн Байнгын хороо нь араас нь дахиад oversight хийх ёстой байхгүй юу.

Гэтэл манайд энэ нэг сонсголууд болон шийдвэр гаргалт, үүний дараагийн хяналт гэх мэтчилэн ийм нэг үргэлжилсэн процесс чинь өөрөө ингээд тасалдалтай байгаа учраас Алдаржавхлан гишүүний асуугаад байгаа үүний ард чинь дахиад та нар сонсцоод л дуусчихдаг. Нэг шийдвэр гаргасан болгоод л шийдвэрийнхээ араас явдаггүй гэдэг ийм шүүмжлэл олон нийтээс бас гараад байгаа нь үнэн.

Тэгэхээр одоо яг парламентын үндсэн бүтэц өөрөө хяналтаа яаж тавьдаг юм, сонсголоо яаж зохион байгуулдаг юм, шийдвэрээ яаж гаргадаг юм, гаргасан шийдвэрийнхээ араас дахиад яаж хяналт тавьдаг юм гэдэг энэ үргэлжилсэн процессыг дэг дээрээ сонсголын систем дээрээ зөв оруулж өгөхгүй бол нэг алдаа гараад байгаа юм байна лээ.

2 дахь нь сонсгол бол зөвхөн мэдээлэл авах хэрэгсэл. Шийдвэр гаргах хэрэгсэл ерөөсөө биш. Шийдвэр гаргах хэрэгсэл нь түр хороо байгуулагдсан бол түр хороо. Байнгын хороо байвал Байнгын хороо. Дэд хороо бол дэд хороо.

Парламентынхаа энэ бүтцээрээ шийдвэр нь гарч байх ёстой. Одоо бид нар яг ингээд шийдвэр гаргах яг тэр процессоо өнөөдөр хийж байгаа юм. Шийдвэр гаргах процессоо. Энэ тогтоол дээр шийдвэр гаргах гэж байгаа процесс байгаа учраас энэ тогтоолын хэрэгжилтийг жилийн дараа тэгж хянаана, энэ тэр гэдэг заалт бас орж болно. Таны саналаар. Энэ шийдвэр гаргалтын хяналтыг хийхдээ сонсгол зохион байгуулна гээд тусгайлан бичиж болно. Энэ чинь манай Байнгын хорооны бүрэн эрх байхгүй юу. Ийм байдлаар бичих юм бол Алдаржавхлан гишүүний нэхээд байгаа бид нар шийдвэр гаргаад мартдаг биш шүү. Одоо шийдвэрийнхээ хяналтыг жилийн дараа сонсоно гэж байна шүү. Энэ хугацаа дотор энэ чиглэлийг нь авч байгаа яамнууд юм уу, Засгийн газрын гишүүд ажиллах ёстой шүү гээд ярих ёстой. Тэгэнгүүт Энхбаяр гишүүний өглөө хэлсэн байхгүй юу. Яг ийм асуултуудыг асуухын тулд нөгөө Хууль зүйн сайд байхгүй байгаа юм биш үү. Хууль зүйн сайдаас амлалт авах, асуулт асуух, бид ийм шийдвэр гаргаж байна энэ шийдвэрийнхээ дагуу хийгээгүй бол чамтай хариуцлага тооцно гэж ярих энэ өнцөг яг энэ хурал дээр бас байгаад байгаа байхгүй юу. Энэ өнцгөө гаргаж ирэх гэхээр нөгөө Хууль зүйн сайд маань энд байдаггүй. Энэ тогтоолоор үүрэг авч байгаа албан тушаалтнууд байдаггүй. Тэгээд байхгүй учраас Алдаржавхлан гишүүний болгоомжлоод байгаа энэ чинь дахиад нөгөө сонсоод өнгөрчихдөг, ард нь ямар ч үр дагавар байдаггүй хариуцлага .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Зөв зөв. Алдаржавхлан гишүүн ээ, би өөрийн чинь саналыг эсрэгээрээ дэмжээд байна шүү дээ. Өнөөдөр байгаа хууль чинь энэ сонсголыг бид нар хуулийн дагуу л явуулж байгаа шүү дээ. Энэ дээр сонсголын хэрэгжилтийн талаарх сонсгол явуулна гэж заалт байхгүй байхгүй юу даа. Тэгэхээр чинь л би таны хэлж байгаа зөв, эс үгүй бол ингэж хууль оруулж ирж энийгээ янзлах юм уу, эсвэл ер нь зүгээр Их Хурал бол өөрийнхөө тогтоолын хэрэгжилтийг араас нь бүр байнга хянаад, нэхээд, энэ Байнгын хорооны Тэмүүжин гишүүний тогтоол гарах гэж байна шүү дээ энэ чинь. Тэгэхээр Байнгын хороо өөрөө энийгээ нэхээд явчхаж болно шүү дээ. Та ч орж ирээд хэзээ ч дуртай цагтаа үүгээр бид нар 1 хурал хийж тайлангаа сонсьё гэвэл харин тэр хуульд заах шаардлагагүй. Бид нар үнэхээр энийг хийгээд явах боломжтой.

Тэгэхээр энэ дээр бол хэрэв бүр тийм тусгайлан сонсгол гэх юм бол тэрийг чинь тийм сонсгол зарлах хууль байхгүй байгаад байгаа юм. Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

Ж.Алдаржавхлан: Нэлээн удаж байж өгч байх юм. Би зүгээр ийм л юм яриад байна шүү дээ. Эртээдийн тэр сонсгол дээр чинь иргэд та нар бид нарыг зөндөө энэ танхимд авчраад зөндөө сонсоод явуулсан л гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр хэдүүлээ энэ тогтоол дээрээ би Сайнзориг дарга аа, тэр эрх зүйн шинэчлэлийн чиглэлээр юм оруулчхаач л гэж байна шүү дээ. Тэнд чинь тэрийг эсэргүүцээд л оруулахгүй. Заавал чи өөрөө тусдаа хууль санаачил гэх хэрэггүй шүү дээ. Та ч Их Хурлын гишүүн, Би ч Их Хурлын гишүүн. Хэдүүлээ хамтдаа нэгэнт Байнгын хорооноос шийдвэр гаргаж байгаад бол дотор нь оруулаад явуулчхаач ээ л гэж байна шүү дээ. Би яагаад асуудал тавихаар дотор нь оруулж болдоггүй юм.

Д.Цогтбаатар: Энэ чинь бид нар оруулах гээд одоо хэлэлцээд сууж байгаа юм байхгүй юу даа. Харин таны саналыг чинь сонсчхоод, харин гарц нь тийм л байгаа байхгүй юу. Тэгвэл тэрийгээ энэ тогтоолдоо оруулж болох уу, үгүй юу Сайнзориг гишүүн нь өөрөө хариулаг.

П.Сайнзориг: Баярлалаа. Дарга аа, түрүүн Сандаг-Очир гишүүн бас санал гаргасан оруулъя гэсэн байгаа. Тэмүүжин гишүүний тэр гэрч, хохирогчийн хамгаалах юмаа оруулчихъя. Номиогийн хэлж байгаа тэр хохирлыг барагдуулах асуудлыг тодотгон оруулчихъя. Харин гишүүд маань томъёоллоо өгчих. Энэ манай Байнгын хорооны тогтоол. Бид хэдийн бүрэн эрхийн асуудал байж байгаа. Дээрээс нь энэ асуудлыг бол оруулчихъя Алдараа дарга аа. Зөв байх. Ер нь зүгээр энэ сонсголыг хийж байхад анх удаа Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу сонсголыг зохион байгуулсан. Тэр хуулийг анх удаа хэрэглэх гэж байгаа байхгүй юу. Өнгөрсөн 6 сард батлагдсан хууль байсан. Тэгээд энийг анх удаа хэрэглэсэн. Олон юмнуудыг засахаар юм байна лээ. Үнэхээр засахаар юм байна лээ. Тэгээд сая Тэмүүжин гишүүний зарчмын хувьд ч зөв байх. Байнгын хорооноосоо салангид харагдаад байгаа ч юм шиг. Үнэхээр Байнгын хорооны хэн нэг даргалагчийн эрх ашиг, сонирхол зөрчилдөөнд орохгүй бол тэр хүн өөрөө даргалаад явчих ёстой. Эсвэл 2 Байнгын хорооны хоорондын асуудал байвал аль нэг Байнгын хороо ч гэдэг юм уу ийм зэргийн өөрчлөлтүүдийг хийгээд явъя. Бүгд ингээд саналуудаа оруулчихъя аа л гэдэг зүйлийг би .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тэгвэл Сайнзориг гишүүн энэ тогтоолдоо одоо чинь асуултын л үе явж байна шүү дээ. Та нарын бүх юмыг би сонсоод дараа нь үг хэлээд дуусахад би жишээлбэл өөрийнхөө зүгээс энэ тогтоолоо батлаад, гэхдээ үүнийхээ найруулгын шинж чанартай өөрчлөлтүүд дээр энэ гишүүдийн ярьж байгаа юмыг оруулаарай гэж би чиглэл өгөх гээд л сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр бол боломжтой. Би бол зүгээр байгаа хуулийнхаа л хүрээнд хуулиа л яриад байгаа байхгүй юу. Одоо ингээд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Яригдаж байгаа тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд энэ бас чухал сонсгол болсон. Ер нь зүгээр энэ хууль сахиулах салбарын үйл ажиллагаа дээр бол мэдээж бодлогын хувьд хууль, эрх зүйн орчныг нь тогтмол сайжруулж өгөх, эргээд хяналтын механизмыг хөндлөнгийн гэдэг юм уу ийм байдлаар тавих, эргээд олон нийтээс гарч байгаа санал шүүмжүүдийг сонсож бас хаанаа доголдож байна гэдэг зүйлүүдийг бас нягтлаад явах ийм зүйл байгаа. Хамгийн чухал юм бол төсөв, хүний нөөцийн бэлтгэж байгаа арга барил, тэдгээрийн сургалтын хөтөлбөр, магадгүй цаашдаа давтан сургаж албан хаагчдыг сайжруулах энэ асуудал дээр байгаад байгаа юм. Тэгэхээр энэ зүйлүүдийг огтоосоо мартаж болохгүй.

Тэгээд түрүүн Цогтбаатар дарга ч хэлсэн. Төсөв дээр бас Хууль зүйн байнгын хороо зарчмаа барьчихсан шүү гээд. Энэ хууль зүйн салбараас төсөв харамлах тусам хүний эрхийн зөрчлүүд гарах магадлал маш өндөр болж эхэлж байгаа юм. Тэгээд би бас гишүүдэд зарчим нэгтэй байдаг талархах гэж байгаа. Энэ тогтоолын төслийг та бүгдийн хэлж ярьж байгаа зүйлийг тусгаад баталж, дэмжиж өгөхөд туслаач гэж хэлж байгаа юм.

Ер нь Хууль зүйн сайд байсан бол би ч гэсэн бас асууя гэж бодсон. Ер нь зүгээр Хууль зүй, дотоод хэргийн яам дээр миний үед боловсруулаад, Засгийн газар дээр манай яамнаас оруулсан тухай үеийн хууль 20 гарчихсан байсан юм. Улсын Их Хуралд өргөн барьчихсан хууль. Тийм учраас эхний 20 батлагдаагүй байж байхад дараагийн 30 орчим хуулиуд явуулах хэрэггүй гэдгийг тухайн үеийн Хууль зүйн сайд Нямбаатар барьж байсан учраас тэр олон хуулиуд өнөөдөр яг энэ

зүйлүүдтэй холбогдож байсан байхгүй юу. Алга болчхоод байна. Хууль зүйн сайд хэзээ энэ зүйлүүдээ оруулж ирэх юм бэ. Шүгэл үлээгчийн хамгаалахын хууль хэзээ оруулж ирэх юм. Жагсаал цуглааны хуулийг хэзээ оруулж ирэх гэж байгаа юм. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийг хэзээ оруулж ирэх гэж байгаа юм. Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулийг хэзээ оруулж ирэх гэж байгаа юм. Байхгүй. Би жишээ нь энэ хууль сахиулах салбарын тэр удирдлагын ёс зүйн асуудал болон жагсаал цуглааны үеэр яг хууль сахиулах салбарын удирдлагын менежментээс болоод хүний амь нас болон олноороо хүмүүс үрэгдэж гэмтсэн тохиолдолд тэр бие даасан зөвлөл энэ тэр хэлэлцээд, шууд хариуцлагын асуудлыг ярих уу, түдгэлзүүлэх үү, эргээд энэ гэмт хэрэг зөрчил байна гээд холбогдох байгууллагад шилжүүлж шалгуулах уу, үгүй юу гэдэг хүртэл дээр тодорхой хуулийн төсөл бэлдчихсэн байсан. Ингээд алга болчхоод байгаа байхгүй юу. Энэ бүх зүйлүүд өнөөдөр бодлогын залгамж чанарын хувьд уг нь явж байх ёстой. Ингээд би бас энэ зүйлүүдийг яг энэ зарчмын хувьд нэхээд, энэ дундаа бас Хууль зүйн байнгын хорооны гишүүддээ өмнөх Засгийн газрын хувьд хийж байсан бодлогын зарим зүйлүүд байгаа. Сайжруулах юмнууд байна. Энийг үргэлжлүүлээд шинэ сайдтайгаа хамтраад явъя. Шинэ Засгийн газартайгаа хамтраад явъя гэдэг мэдээллийг бас давхар өгөх зорилго байгаад байгаа юм. Тэгж байтал дэгийн хуулиараа боломжгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг бас хэдүүлээ шахаж ажиллахад бол бас Засгийн газрын түвшин нь бол холбогдох бодлогын өөрчлөлтүүдийг хийсэн хууль, эрх зүйн орчнуудын төслүүд бол бэлэн байгаа. Энийгээ л харин анхаармаар байна. Бид хэдийн зүгээс бол төсөв энэ тэр дээр нь бол анхаарах зайлшгүй шаардлага байна.

Тэгээд эцэст нь бол энэ байгаа асуудлыг бол зөвхөн Засгийн газартай наалдуулаад байж болохгүй. Прокурор, шүүх эрх мэдлийн байгууллагуудтайгаа бид нар бас яг энэ чиглэлийнхээ юман дээр нь бас анхааралтай ойлголцлоо. Дээрээс нь хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага болох Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, энэ өмгөөлөгч хуульчдын ур чадварыг нэмэгдүүлэх асуудал байгаа юм. Өөрсдөө эд нар маань энэ чиглэлийн гэмт хэргүүдийн янз бүрийн юмнуудтай орооцолддог ийм зүйл байгаа шүү. Эрх ашгийг нь хамгаалах гэхээсээ илүүтэй. Тэгээд ерөөсөө би чадна гэдгийг би хаалт дотор хэлж байгаа юм. Сайн өмгөөлөгч нар бий. Үнэхээр үйлчлүүлэгчийн эрх ашгийн төлөө явж байхад үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хохироодог мөнгийг нь авчхаад гэрээ байгуулчхаад таг алга болдог, араар нь энэ үйлчлүүлэгч нь эрүүдэн шүүлтэд орчихсон ийм зүйлүүд ингээд байдаг юм. Тэгэхээр энийг хаана хаанаа бүгдээрээ энэ цогц байдлаар нь бас анхаарч, энэ чиглэлд нь явуулахад бас илүү бас бодолцох ёстой байна гэдэг зүйлийг хэлье. Тэгээд ингэх юм бол өмгөөлөгчдийг хүртэл аль шатын шүүхэд төлөөлөх гэдэг юм уу, үйлчилгээ үзүүлэх .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Би хоёрхон зүйлийг нэмээд хэлчихье гэж бодлоо. 2019 оны хамгийн анх хийгдэж байсан Утааны сонсголын материал, хувийн хэргийг татаад уншсан. Тэгэхээр тухайн хувийн хэрэг тухайн үедээ бас яг процессыг нь бас сонирхож уншсан гэсэн үг. Одоо яг нөгөө утаатай холбоотой асуудал яригдаж байгаа учраас бас тэр сонсголтой холбоотой тогтоол нь хэрхэн яаж гарч байсан юм, тэр үр дүнг нь яаж шахаж шаарддаг байсан юм бэ гээд өмнөх практикаа л харах гэж гэсэн үг. Тэгээд харамсалтай нь яах вэ яг тэр хувийн хэрэгт бол сонсгол хийгээд сонсголын хурлын тэмдэглэл дэлгэрэнгүй байгаад, тэгээд ингээд хувийн

хэрэг дуусдаг юм байна лээ. Ямар нэгэн тогтоол ерөөсөө байгаагүй гэсэн үг. Тэгэхээр эсвэл тогтоол нь өөр газар эсвэл тогтоол гардаггүй байсан юм уу. Тэгээд би бол тэр материалыг уншиж дуусаад, одоо энэ удаагийн сонголыг бол би маш ахиц дэвшилтэй байна гэж харж байгаа. Ямар ч байсан ахиц дэвшилтэй бид нар тогтоол гаргаад, дээрээс нь энэ тогтоолын заалт болгон дээр бас хариуцах эзнийг нь хугацаатай нь бас тавьчихсан байгаа. Тэгэхээр энэ хугацаа, энэ хариуцах эзэд, байгууллага институцүүд нь бас хариуцаад явчих учраас хэрэгжилтийг бол Байнгын хороо бас шахаад явахад боломжтой болов уу гэж харж байна.

2 дугаарт хохиролтой холбоотой заалт ганцхан заалт тэр ажлын хэсэг байгуулна гэдэг заалт байгаа. Тэгээд ажлын хэсэг дээр бол нэлээн нарийвчилсан зүйлүүд, ганцхан сонсголоор хязгаарлагдахгүйгээр энэ ажлын хэсэг ажиллах шаардлага бол байгаа. Тэгэхээр ганцхан энэ сонсголын хүр хүрээнд хохиролтой холбоотой энэ тогтоол дээр заалтууд бичихээр бас учир дутагдалтай зүйлүүд байна гэж ойлгоод, тэгээд яг энэ ажлын хэсэг зайлшгүй байгуулах ёстой юм байна гэдэгтэй бол санал нэгдэж байгаа.

Тийм учраас бусад заалт дээр юу гэдэг юм хохирол, төлбөр барагдуулах талаар, гэм хорын хохирлын талаар, сэтгэл санааны хохирлын талаар ямар нэгэн шийдэл ч гэдэг юм уу, ямар нэгэн тогтоол дээр заалт бол бичээгүй. Яг энэ ажлын хэсэг бол нэлээн ажил хэрэгч байдлаар ажиллаад, нэлээн цогц байдлаар бол санал боловсруулах байх гэж бодож байна. Дээрээс нь яг энэ тогтоол дээр байгаа ажлын хэсэг сая сонсголд оролцсон тэр хохирогчдын холбооны 40 хэдэн хүний асуудлаас хязгаарлагдахгүйгээр үл хязгаарлагдаж бас нэлээн ийм өргөн хүрээнд ажиллах ёстой гэдгийг нь протокол дээр бас тэмдэглэж үлдээх гэсэн юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр Сайнзориг гишүүнд бүр дахин энэ тогтоол дээр зайлшгүй тусгах ёстой зүйл дээр хэлэхэд хохирсон иргэний зөрчигдсэн эрхийг хамгаалах, сэргээх гэсэн энэ зүйл заалтыг бүр заавал тусгайлан оруулж өгөөрэй. Энэ дотроо хохирогчийн нэр хүнд, сэтгэл санаа, цаг хугацаа, нийгэм, эдийн засгийн гээд энэ алдагдсан боломжуудыг хэрхэн яаж нөхөх тухай ийм заалтууд байвал бүүр сайн байна.

Нөгөө талаараа хүнийг эрүүдэн шүүсэн, хэлмэгдүүлсэн энэ этгээдүүдэд, энэ эрх мэдэлтнүүдэд авах хуулийн хариуцлагыг чангатгахгүй бол мөн жишээлбэл маш энгийн жишээ татахад хүнийг хэлмэгдүүлээд амь насыг нь, амьдралыг нь, бүр тэр битгий хэл айлын амьдралыг самарчхаад эргээд тэр жишээлбэл цагдаагийн албан хаагч албан тушаалаас буурсан, албан тушаалаа ажлаа өгсөн нэрийдлээр эргээд энэ хүн төрийн тэтгэврийг аваад сууж байх нь зөв үү. Тэгэхээр зэрэг адилхан өөрийнх нь хувь заяатай холбоотой ийм зүйлтэй уяж өгвөл яадаг юм бэ. Энэ шийтгэлийг нь. Тэгэхгүй бол энэ хариуцлага нь сул байгаа учраас ийм алдаанууд гараад байна. Өөрийнх нь хувь заяатай холбогдохгүй байгаа учраас эргээд энэ эрүүдэн шүүсэн эсвэл бүр хэлмэгдүүлсэн ийм ноцтой зүйлүүд гараад байна.

Тийм учраас энэ одоо асуудлыг зөвхөн энэ хохирогчид төдийгүй үйлдсэн этгээдүүдэд ноогдуулах хариуцлагыг чангатгах тухай асуудлуудыг үнэхээр бас нарийвчлан шигтгэж өгөх хэрэгтэй байна. Тэгээд дээрээс нь хүнлэг бус харьцсан,

эрүүдэн шүүснээс үүдэлтэй эрүүл мэнд, гоо сайхны аливаа гэмтэл, бэртлийг тухайн бэртлийн эмчилгээний зардал юмыг тухайн үйлдсэн энэ эрх мэдэлтнээр бүрэн 100% гаргуулдаг ийм системийг бас гаргаж өгөхгүй бол ингээд бие, эрүүл мэндээрээ хохирчихсон, гоо зүйгээрээ хохирчихсон хүмүүс төр нь ч эмнэлгийн төлбөрийг нь шийддэггүй, нөгөө хүн нь ч гэсэн шийддэггүй. Ингээд дунд нь мөн л хүн ингээд хохирсон байдалтай яваад байгаа асуудлыг бид нар энэ тогтоол дээрээ маш сайн шигтгэж оруулж өгье гэж одоо бодож байна.

Тэгээд ер нь бид нар энэ хохирсон хүнд барагдуулах минимум стандарт гэдэг юмыг бас хэрэгжүүлэх боломжтой юу гэдэг дээр Сайнзориг гишүүн бас хуулийн олон олон гаргалгаануудыг нь бас бодох байлгүй дээ гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Надад бол 3 асуудал байгаа юм. Тэгэхдээ тогтоолын төсөл дээр нарийвчилж яаж тусгах вэ гэдэг нь нэг тусдаа байх. Энэ тогтоолоос гадна цаашаа үргэлжлэх ажил дээр концепцын хувьд бол энэ 3 асуудал дээр анхаараасай гэдэг үүднээс хэлж байгаа юм.

1 дүгээрт үнэхээр энэ Эрүүгийн хууль тогтоомж дээр байгаа эрүү шүүлттэй холбоотой, хүнлэг бус хэрцгий хандлагатай холбоотой зохицуулалтууд хуулийн байгууллагуудын хэлээд байгаа шиг учир дутагдалтай байна уу, үгүй юу гэдгийг нягтлах ёстой юм байна. Ерөнхий конвенцтойгоо нэгдэж байгаа юу, нийцэлтэй байгаа юу гэдгээ бас нэг харах ёстой юм байна. Онолынхоо хувьд бол харахаар хүнлэг бус, хэрцгий хандах гэдэг үйл явц чинь 3 хэсэг дээр гарч ирээд байгаа байхгүй юу. Нэг нь болохоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үйл явц дээр харагдаж байна. Нэг нь болохоор энэ ял шийтгэлийн хэлбэр болон агуулга дээр харагдаж байна. Нэг нь болохоор хүчтэй захиргааны эрх мэдэлтэй, дээгүүр албан тушаалтан доошийгоо тэр эрх мэдлээрээ дамжуулж үүрэг чиглэл өгөхдөө нөгөө доор байгаа хүн нь өөрийн дураар зорчиж чаддаггүй, эсвэл өөрийн үзэл бодлоо шууд илэрхийлэх хууль зүйн хязгаарлагдмал байгаа тэр нөхцөл дээр нь хэрэглэгдээд байгаа байхгүй юу. Цэрэг гэдэг юм уу, хүүхдийн асрамж гэдэг юм уу тийм газруудад. Энэ дотроосоо улс орнууд хамгийн их аюултай гэж үзэж онцгойлон татаж аваад хэрэглэж байгаа 2 хэсэг нь болохоор энэ ял шийтгэлийн бодлого болон хэрэг хянан шийдвэрлэх шударга ёсыг тогтоох ажиллагаа дээр харагдаад байгаа юм. Шударга ёсыг тогтоох буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дээр болохоор хэргийг илрүүлэхдээ хүнлэг бус, хэрцгий арга хэлбэрээр, эсвэл өөрийг нь сэтгэл санааны болон бие махбодын хүчирхийлэлд өртүүлсэн, барьцаалсан хэлбэрээр илрүүлж яллах бол шударга биш гэдэг энэ хэмжүүр дотор л ач холбогдол өгч өндөр хариуцлага, ял оногдуулах гэж оролдож байгаа юм.

Концепцын хувьд бид нар бол бодох ёстой байх. Техникийнхээ хувьд ямар зүйл заалтуудад энэ гэмт хэргүүдийг бичих вэ гээд. Зүгээр надад анзаарагдаж байгаагаар эрүү шүүлтээс гадна хэрэглэгдэж байгаа хүнлэг бус, хэрцгий хандах хэсэг дээр ялын бодлого учир дутагдалтай байгаа учраас энэ бага ял аваад байна гэдэг шүүмж бол хуулийн байгууллагууд дотор яваад байна.

2-т нь хохирол барагдуулах дээр бид нар концепцоор нь дахиад томоор шийдэхгүй бол хохирол барагдуулах сангийн тухай хуулиа болиод, хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль болгож процессжуулахгүй бол энэ

өөрөө нэг тийм яг процесс дотроо хүнд ээлтэй хууль ерөөсөө биш байгаа юм. Ямар хохирлууд дээр төр урьдчилж гаргадаг вэ гэдэг концепцоо бас шийдэхгүй бол бусад улс орнууд бол хүч хэрэглэсэн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг дээр төр түрүүлээд хохирлыг нь барагдуулаад, өөрөө араас нь хөөцөлдөж буруутай этгээдүүдээс олдог систем байгаа. Энэ төрлийн гэмт хэрэг дотроо хүүхэд, эрүү шүүлт гэх мэтчилэн илүү эмзэг бүлэг рүү илүү хамааралтай бүлэг рүү очиж байгаа эсэх дээр бүүр ач холбогдол өгч зохицуулалт хийсэн байна лээ. Тэгэхлээр энэ чиглэл рүүгээ бид нар нэг анхаараад асуудлаа шийдээсэй гэж.

3-д нь болохоор бид нар гэмт хэрэг үйлдээд мөрдөн шалгах үйл явцад орж байгаа бол эрүү шүүлттэй холбоотой мөрдөн шалгах үйл ажиллагааг яаж зохицуулах вэ, шүүхийн хяналтад яаж бүрэн оруулах вэ гэдэг талаараа нэлээн сайн концепц анхаарлаа авчхаад, гэмт хэргээс наана байгаа заавал хариуцлага тооцох ёстой, урьдчилан сэргийлэх ёстой, алдаа завхралыг засах ёстой хэсэг дээрээ хяналт яаж хэрэгжих юм бэ гэдэг дээрээ анхаарахгүй бол яг энэ хэсэг чинь сул болчихоод байгаа юм. Гэмт хэрэг гэж мөрдөж шалгаж явж байгаад, би цагаадсан шүүхээр гэнгүүтээ ажлаа буцаагаад хийнэ. Надад алдаа завхрал байхгүй гээд нөгөө эрүү шүүлт хийсэн гээд байгаа нөхдүүд чинь бүгдээрээ бараг шагнал авах нь хэмжээгүй албан тушаал дээр буцаж очоод, албан тушаал ахиад яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хэсгийг хянадаг дотоод хяналтыг нь яг Хууль зүйн яамны бүтэц болон хуулийн байгууллагуудын систем дотор яаж хийх юм. Хариуцлагыг нь яаж тооцох юм. Яаж албан тушаал ахиулахгүй байх юм. Энэ чиглэлээрээ жагсаалт гаргана гэж байгаа бол жагсаалтын чинь .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд ярьчих.

Х.Тэмүүжин: Эрүү шүүлт үйлдсэн хүмүүсийн жагсаалтыг бий болгоно. Жагсаалтын ард энэ муу түүхээр нь яаж илүү сахилгажуулсан, хариуцлагажуулсан тогтолцоо ажиллах юм гэдгийг нь шийдэж өгөхгүй бол манайд бол үндсэндээ юу болсон гэхээр шүүхээр асуудал нь шийдэгдээгүй л бол буцаж ирээд ер нь бол ингээд яг ямар ч алдаа дутагдал гаргаагүй, энэ арга хэмжээгээ бараг баригдахгүй бол их юм гэдэг өөр зөвтгөсөн халхавчаар эрүү шүүлтээ ингээд өөгшүүлээд байдаг соёлоо үргэлжлүүлээд байдаг, тэр соёлоо дараа дараагийн боловсон хүчинд уламжлаад яваад байдаг ийм хуулийн буруу практик тогтоод байна. Тэгээд энийг шийдэхийн тулд уг нь бол түрүүнээс хойш хэлээд байгаа. Засгийн газар буюу Хууль зүйн сайдыг авчраад танайх дотоод хяналтын ямар загвар, ямар шийдэл байна. Энэ талаар судалгаа байна уу. Ямар шийдэл рүү явах гэж байна гээд бүр асуумаар байгаа юм. Тэгээд тэр асуултаараа бас даалгавар, үүрэг өгмөөр байгаа юм.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Би бас нэг хэдэн зүйл хэлнэ.

1 дүгээрт энэ бол үр дүнд чиглэсэн байх ёстой гэдэг юм гишүүд яриад байна. Тэгээд энэ дээр энэ улсад байгаа Хууль зүйн байнгын хороо гэдэг чинь Хууль зүйн байнгын хорооны дарга биш, бид нар бүгдээрээ шүү дээ. Бид нар өөрсдөө байж байгаа. Тэгэхээр энэ дээрээ бүгдээрээ санаачилгатай, анхаарал тавиад, манай энэ гарсан тогтоолын энэ энэ заалтууд яаж хэрэгжээд явж байна. Дор дороо өөрсдөө юу ямар ч байгууллагаас асуулт тавиад, хэрэгжилтийг шаардах боломжтой. Бид нар үүгээрээ дахиж хуралдаад, яг үүгээрээ энэ бол сонсгол байхгүй. Бид нар хуралдаад яг энэ асуудлыг бол хэлэлцэх боломж бол бид нарт нээлттэй байгаа шүү. Тэгэхээр энийг хэдүүлээ харж ажиллах ёстой. Харин саяын

сонсгол удирдаж явуулсан Сайнзориг дарга өөрөө энэ дээр санаачилгатай ажиллаж, үр дүнд хүргэх тал дээр нь тэгээд Байнгын хорооны зүгээс бид нар үүнийхээ хэрэгжилтийн араас анхаарал тавьж, бичиг цаас явуулах хэрэгтэй бол бүгд дээр нь 100 хувь дэмжиж өгч ажиллана шүү.

Тэгээд ер нь гишүүддээ ч гэсэн энэ талаараа тайлангаа тавиад, тогтоолын энэ юм ингэж хэрэгжээд явж байна шүү гээд тогтмол мэдээллээ өгөөд явж байж болно. Энийг бол манай Байнгын хорооны ажлын аппарат анхаарч ажиллах ёстой. Тогтоолын хэрэгжилт яг яаж явж байна гэдгийг явц явцаар нь бас гишүүддээ мэдээлж байх нь зөв.

Энэ хохирлын асуудал дээр бол нэг ийм зүйл яримаар байна. Төр хариуцаад яваад байгаа байхгүй юу ер нь бол. Ялангуяа энэ 1937 оны их хэлмэгдэл дээр бол төр хариуцна гэдэг чинь хойч үеийн татвар төлөгчид хариуцаад байгаа байхгүй юу. Түүнээс төр гэж юу байх вэ дээ. Гэтэл тэр төрийн шийдвэрийг тухайн үедээ гаргаж байгаа хүн чинь хүн л байгаа байхгүй юу. Тэгвэл энэ дээр би хохирол тал дээр юу яримаар байна гэхээр сая Тэмүүжин гишүүн ч хэлж байна. Төр тэр хохирлоо нөхөөд төлсөн байхад эргээд тэр нөхцөл байдал руу өөрөө ухамсарласаар байгаад энийг хийгээд эсвэл хэн нэгний үгэнд автах ёсгүй байж автаж байгаад хийж байгаа нөхдүүдийг бол өөрсдөөс нь очиж тэр хохирлыг бүр заавал гаргадаг байх ёстой. Энэ асуудлыг тавиагүй хүн дээр өөр дээр нь хариуцлагад хэчнээн хойд талынх нь үеийн дарга байлаа гэхэд энэ миний өмнөх дарга надтай хамаагүй гэж болохгүй. Танай байгууллага ийм хохирол төлчихсөн байна шүү дээ. Тэгээд та яагаад энийг хойноос нь хөөцөлдөж, энэ хүнийг тэр ажлаа өгөөд явчихсан байсан ч хөөцөлдөхгүй байгаа юм гэж тухайн үед хариуцлагатай алба хашаад явж байгаа хүмүүсээс нь нэхдэг байхгүй бол энэ чинь яг ингээд л орхигдоод л явна. Ялангуяа манайх шиг төр засаг нь байнга солигдож байдаг дарга нар байнга солигдож байдаг ийм газар бол энэ чинь эргээд үнэхээр хариуцлага тооцогдохгүй. Тэгэхээр хохирол тооцно гэдэг бол эргээд тэр шийдвэрийг гаргасан хүн дээр заавал очиж хохирлоо нөхөж авдаг байх хэрэгтэй. Тэгэх юм бол энэ шийдвэрээ хүмүүс гаргаж чадахгүй болно. Энэ эзэнтэй болно гэсэн үг. Түүнээс төр гээд нэг ийм эзэн биегүй юм руу явчих гээд байгаа.

Түрүүн тэр Хүний эрхийн Комиссын тухайд бол тэр 461 дүгээр анги дээр нөгөө амь хохирсон хүүхдийн асуудал гармагц Хүний эрхийн Комисстой ярьж байгаад энэ мөрдөн байцаах ажиллагаанд Хүний эрхийн Комиссыг оруулдаг болно. Тэгэхгүй бол өнөөдөр байгаа хууль чинь хүний эрхийн зөрчил гарахыг нь хүлээгээд байгаа байхгүй юу. Тэгээд гарсных нь дараа явах гээд байгаа байхгүй юу. Гэтэл хууль гэдэг чинь гаргахгүйн төлөө явж байх ёстой учраас Хүний эрхийн Комиссыг энд оруулдаг болох хуулийн төслийг боловсруулаад явж байгаа. Энийг уд удахгүй өргөн бариад явна.

Хэдүүлээ бас ингээд яриад байна л даа. Гишүүд ингээд ярьчихаад үр дүнгүй байгаад байдаг гээд. Энэ дээрээ хэдүүлээ бодно шүү. Энэ Их Хурал гэдэг чинь бид нар энийг хэлэлцчихээд гав бариад юм уу, бороохой бариад гардаг хүмүүс биш шүү дээ. Энэ тогтоол гарна гэдэг чинь маш ноцтой асуудал байгаа учраас тогтоол гараад энийгээ хэдүүлээ хэрэгжүүлэх гээд явна. Энэ чинь бидний хамтын бүтээл шүү. Их Хурал гэдэг бол хэлэлцээд, тогтоол гаргаад ингэж л ажлаа хийдэг хүмүүс. Түүнээс бид нар цагдаагийн өмнүүр очоод юм хийдэг хүмүүс биш. Энийгээ одоо ингээд хэлэлцээд сонсгол явуулж байгаа гэдэг чинь Их Хурал хуулиар заагдсан ажлаа хийж байгаа нь энэ. Тэгээд энийгээ бас тал талдаа анхаарч, эргээд нөгөө

харин хариуцлагаа тооцож хийдэг газруудаараа хийлгэдэг байх ёстой. Тогтоол бол Сайнзориг гишүүн ээ, тогтоол бол заавал биелүүлэх Засгийн газраас бид нар биелэлтийг нь заавал шаардах ийм эрх зүйн бичиг баримт шүү. Тэгэхээр энэ дээрээ бас анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна. Тийм учраас энэ саяын гишүүдийн ярьж байгаа зүйлсийг тогтоолдоо энийгээ бид нар баталж байгаа яг найруулга дээрээ зарим юмнуудаа нөгөө ерөнхий утгаараа оруулчихсан байгаа бол нарийвчилж оруулж өгөөрэй гэж хэлмээр байна.

Тэгээд эцэст нь нэг зүйлийг хэлмээр байна. Одоо энд нөгөө Хууль зүйн сайд байхгүй байгаад байна гээд яриад байна. Үнэхээр Хууль зүйн сайд маань нөгөө Байнгын хороонд байхгүй болохоор энэ хуралд бол уриагүй байгаад байдаг. Нөгөө сонсголын үед ажлын хэсгүүдэд нь байсан болохоор ирж байсан. Ер нь бол энэ хууль дээр бид нар өөрчлөлт оруулж Их Хурлын хуульдаа өөрчлөлт оруулж, нээрээ холбогдох сайд нарыг нь оруулж ирж байхгүй бол бид нар хоорондоо яриад байгаа болчхоод байгаа байхгүй юу. Нөгөө хуулийг чинь яг хэрэгжүүлэх хүн нь өөрөө байхгүй байгаад байгаа. Тэгэхээр энийг бас ялангуяа би түрүүн Энхбаяр гишүүн бас яриад байна лээ. Ер нь санаачилж байгаад оруулах ёстой юм байна гэж бодлоо.

Ингээд үг хэлж дууслаа. Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой хяналтын сонсголын тайланг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Гэхдээ энэ дээр Алтанхуяг гишүүн дэмжсэн байна. Тэгэхээр Алтанхуяг гишүүнийг дэмжсэнээр тооцож, саналынхаа дүнг засаарай гэж хэлье. Сануулъя.

13.12 цаг.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудлын сүүлийн асуудалд орно.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүгдэд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Номинчимэг гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Энэ нөгөө тогтоолын төсөлтэй холбоотойгоор яг цаад хууль дээрх нөгөө дугаарлалтууд албан тушаалуудыг нь харж амжсангүй. Тэгэхээр энэ дээр одоо жишээлэх юм бол 1.4.13 дээр ТТ-11-ээс ТТ-19 гэж байсныг ТТ-Т1, ТТ-Т8 болгож гэх мэтчилэн өөрчлөлтүүд орчихсон байгаа шүү дээ. Тэгэхээр нөгөө өөрчлөгдсөн шалтгаан нь юу билээ. Дээрээс нь яг эндээс ямар нэг, яг ямар албан тушаалууд нэмэгдэж орж байгаа юм. Эсвэл яг ямар албан тушаалууд хасагдаж байгаа юм гэдэг талаар арай дэлгэрэнгүй мэдээлэл авч байгаад энэ шийдвэрийг гаргамаар байна.

Д.Цогтбаатар: Би ажлын хэсгийг танилцуулаадахъя. Т.Энхболд Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Б.Баярсайхан Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга, ахлах комиссар,

Ц.Баасандэлгэр Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар гэсэн ийм бүрэлдэхүүнтэй АТГ-аас ажлын хэсэг ирж ажиллаж байна. Тэгээд саяын асуултад хэн нь хариулах вэ. Хэддүгээр микрофон өгөх вэ. 5 дугаар микрофоныг өгье.

Б.Баярсайхан: Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өнгөрсөн 4 сард Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороогоор мэдүүлэг гаргах үүрэгтэй албан тушаалтнуудын жагсаалтыг баталсан. Тэрнээс хойш буюу 4 сард, 10 сард, тэгээд жилийн дундуур ингээд зарим байгууллагуудын ангилал зэрэглэл өөрчлөгдсөн. Энэ ангилал зэрэглэл одоогийн орж ирж байгаа ангилал зэрэглэлийн асуудлын хувьд бол яг энэ хэвээр нь батлахад ямар нэгэн байдлаар мэдүүлэг гаргагч нэмэгдэх, хасагдах зүйл бол байхгүй. Сая та асуулаа ТТ-11-ээс 9 байсныг яагаад 1-8 болгосон юм бэ гэхээр энэ бол тухайн үедээ Засгийн газрын тогтоолоор тухайн салбарынх нь асуудал салбар нь өөрөө шийдээд гээд ингээд оруулаад явсан байгаа. Энэ дээр бол бид нар хариулт хэлэх юм алга.

Тухайн байгууллагынх нь ангилал зэрэг л яг урвуугаараа өөрчлөгдчихсөн гэсэн үг.

Д.Цогтбаатар: Ер нь товчхондоо хэлэхэд нөгөө хууль тогтоомжуудад өөрчлөлт гарсан тэрэндээ л эд нар зохицуулаад өөрчлөлтөө зайлшгүй оруулаад л ирж байгаа юм байна лээ. Уянгахишиг гишүүн нэмж асуух уу. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Тэгэхээр саяны тайлбараар бол яг энэ зөвхөн тэмдэглэл нь өөрчлөгдсөн болохоос биш цаана байгаа албан тушаалтнуудын хувьд бүтцэд бол өөрчлөлт ороогүй, орохгүй байгаа гэж ойлгох юм байна. Тийм үү.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон. Микрофондоо хариулъя.

Б.Баярсайхан: Тэгэхээр тэмдэглэл ТТ1-7 ч гэдэг юм уу, ТТ1-8 ч гэдэг юм уу энэ тэмдэглэл нь бол өөрчлөгдөж байна. Тэрнээс бол яг мэдүүлэг гаргагчдынх нь тоо, нөгөө авлигын эрсдэлтэй гэж үзэх энэ асуудалд нь бол ямар нэг өөрчлөлт орохгүй юм.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Баярлалаа. Бараг Уянгахишиг гишүүнийхтэй давхацаж байна. Гэхдээ ингэж яриад байна шүү дээ. Энэ би шигтгэсэн хувилбарыг харж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ мэдүүлэг гаргах этгээдүүдийн гээд тэгснээ 1.4.7 дээр Гадаадын иргэн харьяатын байгууллага дээр тэгээд ТТ-7 гэдэг албан тушаалтан байхгүй болчихсон гэж ойлгож болох уу. ТТ1-ТТ7 гэж байсныг нь ТТ1-ТТ6 болгож байгаа шүү дээ. Тэгэхээр энэ байгууллага дээр ТТ-7 гэдэг зэрэглэлийн албан тушаалтан байгаа больчихсон гэж ойлгож болох уу.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

Б.Баярсайхан: Гадаадын иргэн харьяатын газар өмнө нь мэдүүлэг гаргадаг албан тушаалтнууд бол ТТ-1-7 байсан. Бүгд гаргадаг байсан. Одоо бол эдний ангилал зэрэглэл ТТ-1-8 болж байгаа учраас энд нь уялдуулж тогтоолынхоо юуг бас өөрчлөх гээд байгаа юм. Хэрвээ энийг батлахгүй явчих юм бол шинээр 8 гэдэг ангилал гарч ирж байгаа учраас 8-д байгаа 113 хүн хасагдах гээд байгаа юм.

Хасагдах нөхцөл байдал үүсчээд байгаа юм. Тэгэхээр энийг баталж байж бид нар явна гэсэн үг.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

О.Номинчимэг: Эсрэгээрээ ярьчихав уу. Яагаад гэвэл одоо өөрчилж байгаа чинь ТТ-1-7 байсныг нь ТТ1-6 болгоод ороод ирж байгаа байхгүй юу. Энэ Гадаадын иргэн харьяатын байгууллага дээр, дээр нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага дээр ТТ7 байсныг нь ТТ6 хүртэлх болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр зүгээр асуугаад байгаа юм маань Уянгахишиг гишүүний ч гэсэн асуугаад байгаа юм маань энэ албан байгууллагууд чинь тэгвэл ТТ-7 гэдэг юм байхаа болиод ТТ-6 бол засаж ирж байгаа юм уу, эсвэл ТТ-7 нь байгаад зөвхөн ТТ-6 хүртэл мэдүүлэг гаргадаг гэсэн ийм агуулга болчих гээд байна уу л гэдгийн асуулт.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

Б.Баярсайхан: Тэгэхээр сая яг төөрөгдөл үүсчэж байгаа. Нөгөө байгууллага тус бүрдээ өөр өөрийн ангилалтай байгаа юм. Төрийн тусгай албаныхан. Тэгэхээр тэр дээр нь ялгаа нь байгаад байна. Өөрөөр хэлбэл би түрүүн жишээ авч ярихдаа гадаадын иргэн харьяатынхыг ярилаа. Та болохоор сая бол Онцгой байдал эрхэлсэн асуудлын 1-7-г асуулаа. Тэгэхээр онцгой байдлын хувьд бол 1-9 ангилал гэж үндсэндээ байгаа. Үүний 1-7 нь гаргадаг байсан бол одоо 1-8 болоод ингээд ангилал нь өөрчлөгдөнгүүт бид нар эхний 1-6 гэдгийг нь авах шаардлагатай. Хуучин нөгөө мэдүүлэг гаргадаг байсан албан тушаалынхаа хүрээнд багтаагаад ингээд өөрчлөхөөр байгаа юм.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүн гүйцээгээд асуух уу.

Г.Уянгахишиг: Энэ дээр сая яг ингээд тайлбарласных нь дагуу харахаар бид нар ингээд тогтоолын төсөл оруулж ирчхээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр яг редакц талаасаа бол маш дутуу юмнууд хийгдсэн байна гэж харагдаад байна. Одоо жишээлбэл 1.2 дээр гол өөрчлөлтүүд тусгачихсан байгаа шүү дээ. Тэгэнгүүт энэ дээр сая яг хэлсэнчлэн 1.4.10 дахь заалтын ТТ1-ТТ7 гэснийг ТТ1-ТТ6 гэж өөрчилнө гэхихсэн байгаа байхгүй юу. Тэгсэн мөртөө хойно нь болохоор дугаарлалтын зөрөө гарчихсан харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр дугаарлалт дээр одоо энд жишээлбэл 1.4.10 гэх юм. Тэгэнгүүт энэ хойно 1.4.10 гэдгийг нь харахгүй, олохгүй байна л даа. Тэгэхээр яг одоо 1.4.10 энэ дээр байхгүй байгаад байгаа байхгүй юу. Эсвэл хэвлэлт дээр чинь дугаарлалтууд нь алга болчихсон юм уу.

Д.Цогтбаатар: Өөр байгууллагын тухай сая ярилаа гэж хэллээ шүү дээ. 5 дугаар микрофон өгье дөө.

Б.Баярсайхан: Энийг та нар тайлбарлахгүй бол гишүүд аргагүй. Энэ хардаа. Гишүүд бол зөв шүү энэ дээр. Ингээд тулгаад оруулаад ирсэн. Би асуудлыг чинь яаралтайгаар дор нь оруулаад өгч байгаа юм. Одоо та нар гишүүддээ энэ тайлбарла. Яагаад гэвэл тогтоолын төслөө та нар боловсруулаад л оруулж ирсэн байгаа. Би ажлыг чинь гацаахгүй, удаахгүй гээд л явуулж байна шүү дээ. 5 дугаар микрофон гүйцэд хариулаад явъя.

Б.Баярсайхан: Жишээлбэл энд нэг байгууллагыг жишээ авч ярья л даа. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хувьд бол ТТ гээд 2 ширхэг ТТ-тэй. Тэгээд 11-19 гэдэг ангилалд хамаарах албан тушаалтан мэдүүлэг гаргадаг байсан бол энэ 4 сард орсон өөрчлөлтөөр тухайн байгууллагын ангилал зэрэглэл нь 2 ТТ биш 3 ТТТ болчхож байгаа юм. Т, Т, Т гээд 3 т. Тэгээд арынх нь тоо нь болохоор 1-8 гэдэг ийм болчхож байгаа учраас ингээд бүүр шал өөр болчхоод байгаа юм байна. Тэгэхээр энийг л уялдуулж нөгөө хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн уялдааг нь л хангах ийм шаардлагатай байгаагаас л орж ирж байгаа зүйл.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүн микрофондоо асууя. Хэдүүлээ асууж байж нэгэнт тулгаж орж ирсэн болохоор асууж ойлголцож байж л тогтоолоо гаргана шүү дээ.

Г.Уянгахишиг: Одоо яг 1.4.7-г хар даа. Энэ нөгөө тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл дээр 1.4.7 чинь ТТ1-ТТ8 болно гэхчхэн байгаа биз. Тэгэнгүүт хойд талынхаа хавсралт болгоод шигтгээд оруулчихсаныгаа харахаар 1.4.7 дээр чинь ТТ1-ТТ6 болчихсон байгаа биз дээ. Үгүй ээ, энэ хэвлэсэн энэ мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт гээд төслийн шигтгэсэн хувь гээд бид нарт өгсөн шүү дээ хэвлээд. Тэгээд тэр дээр чинь болохоор чинь яг л 6 л гэсэн тоо байгаад байна шүү дээ. Уг нь бол тогтоолын төсөл дээр 8 гэж байгаад байхад. Тэгэхээр үгүй ээ, аваачиж үзүүлэх нь яах вэ дээ бид нарт гол нь бид нар санал өгөх ёстой тараасан материал чинь энэ шүү дээ. Тэгээд энэ тараасан материал чинь өөр байгаад байхад бид нар алийг нь зөв гэж хүлээж авч санал өгөх юм бэ.

Д.Цогтбаатар: Эднийхээс өгсөн материалаас одоо бид нар тогтоолын төслөө л барина шүү дээ. Гэхдээ энэ тогтоолын төсөл дээр миний ойлгож байгаагаар эдний өгсөн юуг хэвлээд гаргахад жоохон алдаа гарсан байх шиг байна. Би тэрийг нь хараадахъя. Микрофонд хэлчихье. 5 дугаар микрофон.

Б.Баярсайхан: Тэгэхээр 1.4.7 бол одоо шинэ нь 1-8 болж байгаа юм. ТТ. 1.4.10 бол ТТ1-8 болж байгаа шинэ нь. 1.4.13 бол ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: 1.4 дээр алдаа гараад байна гээд байна шүү дээ. 1.4.7, 1.4.6 гэсэн үү. 10. Тэр дээр яаж байна. 5 дугаар микрофон. Миний ойлгож байгаагаар ажлын хэсгийн юун дээр бол алдаа байхгүй, зөрүү байхгүй байх шиг харагдаад байна.

Б.Баярсайхан: Энэ дээр алдаа гарсан байна. Тэгэхээр гадаадын иргэний буюу 1.4.7 дээр ТТ1-8 байна. Онцгой байдлын ТТ1-6, төрийн тусгай хамгаалалтынх 3 ширхэг ТТТ1-8.

Д.Цогтбаатар: Тэгэхээр наадхыгаа засаад дараагийн хурал дээр энэ асуудлаа оруулж ирж хэлэлцүүл.

Сайнзориг гишүүн дараагийн хурал дээр орж ирэхэд бас анхаарах зүйл байгаа бол хэлчих.

П.Сайнзориг: Манай энэ мэдүүлэг гаргадаг энэ хүмүүсийн жагсаалтыг Хууль зүйн байнгын хороо тогтоож байгаа юм. Уг нь бол Байнгын хороо эцсийн шийдвэр гаргадаг гэдэг дээр би бол гайхаад байдаг юм. Энэ нөгөө захиргааны хэм хэмжээний акт Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хэм хэмжээ тогтоож

байгаа шийдвэрүүдийг эрх шилжүүлэхдээ бид нар бодолцохгүй бол Улсын Их Хурал нь дотроо өөрөө өөртөө эрх шилжүүлээд, Хууль зүйн байнгын хорооны гаргаж байгаа нэг нь ерөнхийдөө энэ жагсаалт зөв үү, буруу юу гэдгийг хэн хянах юм бэ гэдэг энэ асуудал нь ойлгомжгүй. Уг нь бол хэм хэмжээ тогтоосон актууд заавал бүртгэлүүд, дараа нь аль нэг хяналт нь байх ёстой. Гэтэл Байнгын хорооны шийдвэрийг жишээ нь захиргааны шүүх байтугай цэц ч хянадаггүй байхгүй юу. Яг энэ дунд нь ингээд асуудал үүсвэл усыг өөрөө л яана. Тэгээд ийм юм орхигдчихвол яах вэ гэдэг асуудлыг яах вэ. Тэгэхээр энэ ерөөсөө энэ урт нэртэй хууль гээд ярьчихъя. Уучлаарай. Урт нэртэй хуулийгаа бид нар бодоод энэ жагсаалтыг эсвэл Улсын Их Хурал өөрөө баталдаг баймаар байгаа юм. Зөвхөн Байнгын хороо ингэж Улсын Их Хурлын, эсвэл Улсын Их Хурал, Засгийн газарт шилжүүлэх ёстой байхгүй юу. Ингэж дундуур нь аваад ямар ч хяналтгүй, цэцийн хяналт нь ч байдаггүй, захиргааны шүүхийн хяналт нь ч байдаггүй нэг ийм зүйлийг ингээд явдаг юм. Би энийг зарчмын хувьд, хууль зүйн бодлогын хувьд хэлж байгаа шүү. Эрх шилжүүлэхдээ бид нар Байнгын хороонд эрх шилжүүлж болохгүй. Байнгын хороо бол зүгээр эрхлэх асуудлынхаа хүрээнд шийдвэрүүдээ гаргаад явна уу гэхээс биш ийм зүйлүүдийн жагсаалтыг наана уу, цаана уу гээд явахаар их ойлгомжгүй ийм жишиг манай бусад Байнгын хороо дээр байдаг юм байна лээ. Ямар Нийгмийн бодлогын зөвлөлийн юмны дүрмийг батална ч гэх шиг. Сүүлдээ ингээд мини мини парламентууд үүсэж эхэлж байгаа юм. Энэ бол ерөөсөө зөвхөн манай энэ жагсаалт баталж байгаатай холбоотой биш. Энэ өөрөө эргээд парламентын эрх шилжүүлэх delegation of power гадна парламент дээрээ байх уу, үгүй юү гэдэг бас нэг суурь зарчим шүү.

2 дугаарт энэ мэдүүлэг гаргах жагсаалт дээр байдаг юм. Банкны эрх хүлээн авагч яг ингээд ойлгочихсон. Өнөөдөр банк дампуурахад өөрөө эргээд хувийн салбар дээр банкны эрх хүлээн авагч мэргэжлийн хуулийн этгээд эсвэл мэргэжилтнүүд байхгүй байгаад байгаа учраас Монголбанкнаас 1 хүн томилоод явуулчихдаг юм. Тэгэнгүүт энийг нийтийн эрх зүйн этгээд гэж үзээд байгаа байхгүй юу. Энэ чинь цэвэр хувийн эрх зүй этгээд. Ийм учраас банкны дампуурал захиргааны шүүх дээр хянагдаад, бусад компаниудын дампуурал иргэний шүүх дээр хянагдаад, үнэндээ хэлэхэд энийг чинь манай эрх зүйн тогтолцоог чинь энэ олон улсын байгууллагууд ойлгохгүй байгаа юм. Наад зах нь үүнээс эхлээд бид нар ингээд төөрөгдөлд орчихоод байна. Энийг нэг үзээч ээ та нар. Банкны эрх хүлээн авагчийг бид нар энд мэдүүлэг гаргагч буюу нийтийн эрх зүйн этгээдэд авах хэрэггүй шүү дээ. Энэ хувийн эрх зүйн этгээдээр яваад үнэхээр тэр хүн албан тушаал, эд хөрөнгө шамшигдуулсан бол тэрүүгээр нь хариуцлагыг нь хүлээж болох байхгүй юу. Энэ нийтийн эрх зүй этгээд биш юм. Монголбанкнаас өөр томилчих хүн олдохгүй байгаа, зах зээл дээр энэ банкны эрх хүлээн авагч мэргэжлийн статустай тийм этгээдүүд байхгүй байгаа учраас л томилоод байдаг жишгээр та нар энэ дээрээ аваачиж яваад байна.

2 дугаарт 1 ийм юм байна. Төрийн тодорхой чиг үүрэг, ажил үйлчилгээ, холбогдох хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг Засгийн газрын бус байгууллага гээд явчихсан юм. Өнөөдөр яамнуудтай юм уу төрийн байгууллагатай нэгхэн удаагийн судалгаа хийж байгаа төрийн бус байгууллага болгоныг та нар энэ дээр мэдүүлэг гаргуулдаг байхгүй юу. Болохгүй шүү дээ. Харин Засгийн газрын гэдэг юм уу яамнуудын чиг үүргийг тогтмол хийх гэж байгаа буюу төсвийг нь авч байгаа, чиг үүргийг нь авч хийж байгаа магадгүй Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Нотариатын танхим, Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг энэ байгууллагуудыг бол гаргуулж болно. 1 удаа төрд 1 хуулийн жижигхэн

судалгаа хийгээд, тооцоо судалгаа хийгээд өгөнгүүт энийг ингээд байхаар ерөөсөө энэ чинь хянадаг нийтийн албан тушаалтан биш байхгүй юу. Энийг манай Авлигатай тэмцэх газрынхан бодооч. Эсвэл энэ дээр гэрээний үнийн дүнг нь тавимаар юм. Энэ чинь бүр хавтгай юм болоод байгаа байхгүй юу. Та хэд мэдэж байгаа шүү дээ. Хянахад хүртэл тийм өгөөжгүй.

Тэгээд би энэ 2 зүйлийг хэлмээр байгаа юм. Тэгээд манай бас яг энийг хянадаг залуучууд хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлд Хууль зүйн байнгын хороо энэ жагсаалтыг гаргаж байгааг би ер нь болохгүй гэж бодоод байгаа юм. Тэгэхээр аль институц нь .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Манай байнгын хороогоор хэлэлцэгдэж байгаа чинь одоо байгаа хууль нь л энэ Авлигын эсрэг хуулийн 10.1-д заасны дагуу эх сурвалж нь өөрөө хуульдаа л байж байгаа байхгүй юу. Түүнээс сайн дураараа эд нар авч орж ирээд ч юм уу, бид нар энд сайн дураараа авч хэлэлцэж байгаа биш. Байгаа хууль нь ийм байна. Сайнзориг гишүүн ээ, таны ярьж байгаа бол харин үнэхээр чухал асуудал байхгүй юу. Гэтэл одоо би хойшлууллаа шүү дээ. Энийг засчихвал орж ирж чадахгүй шүү дээ. Тэгэхгүй бол дараагийн хурал дээр энийг засаагүй байна гэх юм бол энэ чинь хуулиа өөрчлөх асуудал гарч ирж байгаа байхгүй юу.

Ингээд хурлыг хойшлууллаа. Өнөөдрийн хуралдаан хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул хуралдаан хаагдсаныг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал дууслаа. Энэ асуудлыг хойшлуулж байгаа юм. Түүнээс Байнгын хорооны хурал хэлэлцэх асуудлаа дууссан тул өнөөдрийн хуралдаан хаагдсаныг мэдэгдье. Гишүүддээ талархал илэрхийлье.

13.30 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ